



**Хууль зүй, дотоод
хэргийн яам**



**“Шүүх, эрх зүйн
шинэчлэлт” төсөл**

Олон улсын нийтийн эрх зүй

Гарын авлага

Зөвлөх: Л.Сэсээр

Боловсруулсан: Боловсруулсан:

*Энэхүү гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас
хэрэгжүүлж буй Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар 2007

DDC 341 C-97

Олон улсын нийтийн эрх зүй
Гарын авлага

Гарын авлага боловсруулсан:

Зөвлөх: Г.Сэсээр
Багийн гишүүд: Ч.Сарангэрэл, LLM С.
Ганхуяг, LLM

Хөтөлбөр боловсруулсан:

Зөвлөх: Ж.Амарсанаа
Багийн гишүүд: Ч.Сарангэрэл, LLM М.Мөнхбат, LLM

Хэвлэлийн хэмжээ: 12.4 х.х
Номын хэмжээ: 176х250/12
Хэвлэсэн газар: "Соёмбо принтинг" ХХК

ISBN 978-99929-4-138-3



“ШҮҮХ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ” ТӨСЛИЙН ТУХАЙ

Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудад

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл 2002 оноос хэрэгжээд дуусах шатандаа орж байна.



Төслийн зохицуулагч
Д.ОЮУНЧИМЭГ

Энэ төслийн хүрээнд эрх зүйн дээд боловсролыг чанаржуулах чиглэлээр эхний шатны зарим ажлыг хийж дуусгалаа.

Эдгээр ажлын үр дүн нь таны гар дээр очиж буй энэ гарын авлага юм. Бид энэ ажлыг зохион байгуулахдаа гадаадын зөвлөх гэхээсээ монголчууд бидний оюун ухаанд тулгуурлаж, дотоодын эрдэмтэн, багш нараар хийлгэсэн юм.

Энэ номыг бүтээхэд хууль зүйн сургуулиудаас нэр хүндтэй, туршлагатай ахмад багш, нөгөө талаар идэвхтэй, санаачлагатай, хийж бүтээе, өөрийгөө боловсрууля гэсэн эрмэлзэлтэй залуу багш нарыг баг болгон оролцуулсан юм. Энэ гарын авлагыг бүтээх явцад багш нар хамтран ажиллаж, бие биенээсээ харилцан суралцаж, цаашид судалгаа шинжилгээний ажил, эрх зүйн сургалтын шинэчлэлтийг хамтран хийхэд үр дүнд хүрнэ гэдгийг харуулсан болно.

Оюутанд зориулсан цогц гарын авлага (хичээлийн хөтөлбөр, тойм лекц) нь Монголд анх удаагаа гарч байгаа билээ. Оюутны гарын авлага нь тэдний судалж буй хичээлд хандах хандлагыг өөрчилж, “бэлэнчлэх” сэтгэлгээнээс ангижруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Төсөл бол тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг жамтай. Харин төсөл хэрэгжүүлэх явцад танилцсан, хамтарч ажилласан багш нар цаашдаа өөрсдийгөө боловсруулах, сургалтынхаа арга барил, чанарыг сайжруулах чиглэлээр хийж эхэлсэн ажлаа үргэлжлүүлнэ гэдэгт найдаж байна. Хичээлийн хөтөлбөр, оюутны гарын авлага бүтээхэд оролцсон 100 орчим эрдэмтэн, багш нар болон энэ ажлыг гардан зохион байгуулж, уялдаа холбоог нь хангах талаар идэвх зүтгэлтэй ажилласан төслийн ажилтан Б.Сарантуяад талархал илэрхийлье.

Үр дүнд чиглэсэн сургалтын хөтөлбөр



Төслийн зөвлөх
У.ТУЯА

Оюутан залуус та бүхэнд их мэдлэгийг хуримтлуулах нь чухал уу, харин уг мэдлэгээ ашиглах чадвар, мэргэжлийн үнэт зүйлсийг эзэмших нь чухал уу. Аль замыг чухал гэж сонгосноос таны суралцах арга барил, цаашлаад сургалтад хандах хандлага тань тодорхойлогддог байна. Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулахад ч энэ хоёр талаас авч үзэх хэрэгтэй болдог.

Бид 2003 оноос Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг сайжруулах” дэд төслийн хүрээнд энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулахдаа дараах шаардлагыг харгалзсан бөгөөд оюутан таныг ч энэ тухай мэдэж сургалтын хөтөлбөр, гарын авлагаа ашиглахыг зөвлөж байна. Үүнд:

- ❖ Оюутан ямар зорилгоор уг хичээлийг судалж, ямар үр дүнд хүрэхээ мэдэж байх ёстой.
- ❖ Мэргэжлийн мэдлэг нь мэргэжлийн ур чадвар болон хөгжиж, үнэт зүйл болон төлөвшсөн байх нь чухал. Иймээс мэдээлэл болгоныг боловсруулах бие даалтын ажил оюутанд хэрэгтэй.

ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН БАГ



Гончигийн Сэсээр

Олон улсын хуульч

Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал, Монгол Улсыг Олон улсын гэрээний эрх зүйн зарим асуудал, Олон улсын эрүүгийн шүүхийн эрх зүйн зарим асуудал, АНУ-ын цагаачлалын эрх зүй зэрэг бүтээл туурьвиж, Монгол Улсын Гаалийн эрх зүйг хянан тохиолдуулж, Дэлхийн худалдааны байгууллагын баримт бичгийн эмхтгэл, Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, дүрвэгсэдийн эрх зүй зэрэг 10 орчим ном орчуулжээ



Чулуунбатын Сарангэрэл

Хууль зүйн магистр.

ОТИС-ийн ХЗС-ийн ОУЭЗ-н тэнхимийн багш, МӨХ гишүүн, өмгөөлөгч.

Хүний эрх, Олон улсын нийтийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн.



Содномын Ганхуяг

Хууль зүйн магистр.

Гадаад Хэргийн Яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал.

Монгол Улсын 1990-2001 онд байгуулсан 2 талт хэлэлцээрийн эмхтгэлийг хэвлүүлж "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн тусгай дугаарын 1-8 дугаар ботийг хэвлүүлсэн.

Олон улсын нийтийн эрх зүй, хүний эрх, олон улсын терроризм, худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн.



ӨМНӨХ ҮГ

Даяаршлын эрин үед Олон улсын нийтийн эрх зүй нь нийт байгууллага, хүмүүсийн амьдралын өдөр дутмын хэрэгцээ, амин чухал шаардлага болж, ач холбогдол нь улам ихээр өргөжиж байна. Монгол Улсад Хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд олон улсын нийтийн эрх зүй хичээлийг судлах явдал зайлшгүй болоод байна.

Монгол Улсад хэрэгжүүлж буй "Шүүх, эрх зүйн шинэчлэлт" төслийн зүгээс бодитой дэмжлэг үзүүлсний дүнд "Олон улсын нийтийн эрх зүй" хичээлийн гарын авлагыг Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал болон орчин үеийн олон улсын эрх зүйд уялдуулан боловсруулав.

Олон улсын нийтийн эрх зүйн хичээлийг Хууль зүйн их, дээд сургуулийн Олон улсын эрх зүйн мэргэжлийн бус ангиудад үзэх учир гарыш явлага гүнзгийрүүлсэн сургалт биш, анхан шатны суурь мэдлэг олгоход зориулж, Эрх зүйн мэргэжлээр суралцагсдад аль болох хялбар дөхөм болгох чиглэл баримталсан болно.

Танд баярлалаа

Багийн гишүүд

ГАРЧИГ

НЭГ. ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Олон улсын нийтийн эрх зүй хичээлийн хөтөлбөрийн агуулга	10
Олон улсын нийтийн эрх зүйн хичээлийн заах арга зүй	26
Семинарын загвар хичээл	36
Олон улсын нийтийн эрх зүй хичээлийн үнэлгээ	39
Олон улсын нийтийн эрх зүй хичээлийн гарын авлага	45

ХОЁР. ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Нэгдүгээр бүлэг. Олон улсын нийтийн эрх зүйн удиртгал	45
1. ОУНЭЗ-н тухай ойлголт, эх сурвалж	45
2. Олон улсын нийтийн эрх зүйн түүхэн хөгжил	49
Хоёрдугаар бүлэг. Олон улсын нийтийн эрх зүйн үндсэн анги	53
3. ОУНЭЗ-н үндсэн зарчим	53
4. ОУНЭЗ-н субъект	58
5. ОУНЭЗ дэхь хүлээн зөвшөөрөх асуудал	62
6. ОУНЭЗ дэхь эрхзүйн өвлөлийн асуудал	66
7. Хүн ам ба нутаг дэвсгэр	70
Гуравдугаар бүлэг. Олон улсын нийтийн эрх зүйн тусгай анги	74
8. Олон улсын гэрээний эрх зүй	74
9. Олон улсын эрхзүй ба үндэсний эрх зүй хоорондын харилцан хамааарал	77
10. Олон улсын байгууллагын эрх зүй	80
11. Дипломатын эрх зүй	85
12. Консулын эрх зүй	89
13. Хүний эрх	92
14. Хүний эрхийг хамгаалах олон улсын механизм	95
15. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй	98
16. Олон улсын эрүүгийн эрх зүй	103
17. Олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх асуудал	107
18. Олон улсын эдийн засгийн эрх зүй	113
19. Олон улсын аюулгүй байдлын эрх зүй	117
20. Олон улсын далайн эрх зүй	121
21. Олон улсын агаарын эрх зүй	124
22. Олон улсын сансрын эрх зүй	129
23. Олон улсын олон нийтийн мэдээлэлийн эрх зүй	133
24. Хүрээлэн буй орчныг хамгаалах олон улсын нийтийн эрх зүй	136
25. Олон улсын цөмийн эрх зүй	140
26. Олон улсын эрх зүйн хариуцлага	144
27. Олон улсын маргааныг эв зүйгээр шийдвэрлэх арга зам	147



НЭГ. ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Олон Улсын Нийтийн Эрх зүй хичээлийн танилцуулга

Хичээлийн нэр: "Олон улсын нийтийн эрх зүй"

Индекс

Кредит цаг: 2

Нийт цаг: 56 /лекц 40, семинар 16/

Улирал: V

"Олон улсын нийтийн эрх зүй" хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага:

Олон улсын нийтийн эрх зүй бие даасан эрх зүйн шинжлэл ухаан бөгөөд үндэсний хэмжээнд түүний гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, эзлэх байр суурь нь нэмэгдсээр байна. Аливаа улс гадаад, дотоод үзэл баримтлал, хууль батлах, хэрэглэх үйл явцдаа Олон улсын нийтийн эрх зүйн зарчим, хэм хэмжээг харгалзан, зохих түвшинд хэрэглэдэг болжээ.

1997 онд Страсбург хотноо хуралдсан Олон улсын эрх зүйн Институтын ээлжит чуулганаас баталсан тогтоолд "Олон улсын нийтийн болон хувийн эрх зүйн суурь хичээлийг заавал судлах шаардлагатай" гэж Хууль зүйн дээд боловсрол эзэмших оюутанд тавигдах шаардлагыг тогтоож өгсөн. Энэхүү хэрэгцээ, шаардлага "Олон улсын нийтийн эрх зүй" хичээлийг хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд багтаасан юм.

Монгол Улсын хувьд нэг талаас олон улсын жишигт хууль зүйн дээд боловсролын тогтолцоог нийцүүлэх, нөгөөтэйгүүр олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн орсоны дараа Олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс олон улсын эрх зүйг судлах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Хичээлийн зорилго: Энэ хичээлээр олон улсын нийтийн эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байдалд үндэслэгдэн үүсэх харилцааны эрх зүйн зохицуулалт, онцлогийн талаар мэдлэг олж, улмаар эрх зүйн холбогдол бүхий асуудалд олон улсын нийтийн эрх зүйг үндэслэн хандах хандлага төлөвшиж, олон улсын харилцааны болон үндэсний хэмжээний хууль зүйн практикийн асуудалд зохих хэмжээнд олон улсын нийтийн эрх зүйг хэрэглэх, улмаар үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар эзэмшихэд хичээлийн зорилго оршино.

Хичээлийн зорилт:

- Олон улсын нийтийн эрх зүйн ойлголт болон нэр томъёог чөлөөтэй ашиглах,
- Олон улсын нийтийн эрх зүйн баримт бичгийн агуулгыг таниулах ба практикт хэрэглэх дадлыг хөгжүүлэх,
- Аливаа асуудлыг Олон улсын нийтийн эрх зүйд үндэслэж өөрийн үзэл бодол төлөвших, илэрхийлэх дадлыг хөгжүүлэх,
- Олон улсын харилцааны тодорхой асуудлыг шинжлэх чадвартай болгох,
- Эрдэмтэн шинжилгээ, судалгааны ажлын дадал олгох

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Олон улсын нийтийн эрх зүй хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цаг хуваарилалт

№	Бүлэг	Лекцийн сэдэв	Цаг	Семинарын сэдэв	Цаг	Бүлэгт ногдох цаг
1	Удиртгал	Олон улсын нийтийн эрх зүйн ойлголт, эх сурвалж	2	Олон улсын нийтийн эрх зүйн түүхэн хөгжил	2	4
2	Үндсэн анги	Олон улсын нийтийн эрх зүйн үндсэн зарчим	2			10
3		Олон улсын нийтийн эрх зүйн субъект	2	Олон улсын эрх зүй дэх хүлээн зөвшөөрөх асуудал	2	
4		Хун ам ба нутаг дэвсгэр	2	Олон улсын эрх зүйн эрх зүйн өвлөлийн асуудал	2	
5	Тусгай анги	Олон улсын гэрээний эрх зүй	4	Олон улсын нийтийн эрх зүй ба үндэсний эрх зүйн хоорондын харилцан хамаарал	2	42
6		Олон улсын байгууллагын эрх зүйн байдал	2			
7		Дипломатын эрх зүй	2	Консулын эрх зүй	2	
8		Хүний эрх	2	Хүний эрхийг хамгаалах олон улсын механизм	2	



9	Тусгай анги	Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй	2			42
10		Олон улсын эрүүгийн эрх зүй	2	Олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх асуудал	2	
11		Олон улсын эдийн засгийн эрх зүй	2			
12		Олон улсын аюулгүй байдлын эрх зүй	2			
13		Олон улсын далайн эрх зүй	2			
14		Олон улсын агаарын эрх зүй	2			
15		Олон улсын сансрын эрх зүй	2			
16		Олон улсын олон нийтийн мэдээллийн эрх зүй	2			
17		Хүрээлэн байгаа орчныг хамгаалах олон улсын нийтийн эрх зүй	2	Олон улсын цөмийн эрх зүй	2	
18		Олон улсын эрх зүйн хариуцлага	2			
19		Олон улсын маргааныг шийдвэрлэх арга зам	2			
	Нийт		40		2	56

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

1. Олон улсын нийтийн эрх зүйн ойлголт, эх сурвалж

Зорилго:

Олон улсын нийтийн эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын арга, чиг үүрэг, олон улсын нийтийн эрх зүйн хэм хэмжээ, түүний илрэх гадаад хэлбэр болох эх сурвалжын тухай мэдлэгийг эзэмшиж, олон улсын нийтийн эрх зүйг үндэсний эрх зүй болон олон улсын хувийн эрх зүйтэй харьцуулж онцлогийг тодорхойлох, эх сурвалжын төрөл, ангилал хоорондын харилцан нөлөөлөлийг тодорхойлох чадварыг эзэмшинэ.



Нэр томъёо

- Олон улсын харилцаа
- Зөвшилцөл
- Хүсэл зориг
- Хэм хэмжээ
- Эх сурвалж
- Олон улсын гэрээ
- Олон улсын заншил
- Эрх зүйн ерөнхий зарчим
- Номлол, сургаал
- Шүүхийн шийдвэр

Сэдвийн агуулга:

1. Олон улсын нийтийн эрх зүйн ойлголт, зохицуулах зүйл, субъект, объект, зохицуулалтын арга
2. Олон улсын нийтийн эрх зүйн чиг үүрэг
3. Олон улсын нийтийн эрх зүйн эх сурвалжийн тухай ойлголт, төрөл
4. Олон улсын нийтийн эрх зүйн үндсэн эх сурвалж
5. Туслах чанарын эх сурвалж

2. Олон улсын нийтийн эрх зүйн түүхэн хөгжил

Зорилго:

Олон улсын нийтийн эрх зүйн үүсэл, хөгжил, үе шат, тэдгээрийн онцлог, тухайн үеийн сэтгэгчдийн үзэл баримтлалтай танилцаж тэдгээрийг харьцуулан судлах замаар нийтлэг хийгээд ялгаатай талуудыг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, мэдээлэл цуглуулах чадвараа хөгжүүлэх, Олон улсын нийтийн эрх зүйн асуудалд түүхэн хийгээд олон талаас нь хандах хандлага төлөвшүүлэх



Нэр томъёо

- Jus gentium
- Jus intergentium

Сэдвийн агуулга:

1. Олон улсын нийтийн эрх зүйн үүсэл, түүний түүхийн үечлэл
2. Эртний үеийн олон улсын нийтийн эрх зүйн онцлог
3. Дундад зууны үеийн олон улсын нийтийн эрх зүйн онцлог
4. Сонгодог үеийн олон улсын нийтийн эрх зүйн онцлог
5. Орчин үеийн олон улсын нийтийн эрх зүйн онцлог

3. Олон улсын нийтийн эрх зүйн үндсэн зарчим

Зорилго:

Олон улсын нийтийн эрх зүйн суурь хэм хэмжээ болох үндсэн зарчим, тэдгээрийн хууль зүйн агуулгын тухай мэдлэгийг эзэмшиж олон улсын харилцааны эрх зүйн зохицуулалтын үндсэн чиглэл, зорилгын тухай хандлага төлөвшиж, Олон улсын нийтийн эрх зүйн бусад хэм хэмжээ, субъектийн зан үйлийг хууль ёсны эсэхийг тодорхойлох чадвар олгоход оршино.



Нэр томъёо

- Хэм хэмжээ
- Jus cogens
- Зарчим

Сэдвийн агуулга:

1. Олон улсын эрх зүйн үндсэн зарчмын тухай ойлголт, үүсэл, түүний ангилал
2. Олон улсын нийтийн эрх зүйн зарчмын эх сурвалжууд
3. Олон улсын нийтийн эрх зүйн зарчмын хууль зүйн агуулга

4. Олон улсын нийтийн эрх зүйн субъект

Зорилго:

Орчин үеийн олон улсын харилцааны оролцогчид, тэдний эдлэх эрх, хүлээх үүргийн тухай мэдлэгтэй болж, Монгол Улс бусад олон улсын харилцааны субъекттэй бүрэн эрхт гишүүний хувьд ямар эрх, үүрэгтэй харилцах талаархи хандлага төлөвшиж, дүгнэлт өгөх чадварыг хөгжүүлэхэд оршино.



Нэр томъёо

- Улс гүрэн
- Олон улсын байгууллага
- Холбооны улс
- Нийлмэл улс
- Улс хэлбэрийн тогтоц
- Үндэстэн
- Ард түмэн
- Олон улсын байгууллага
- Олон улсын байгууллагын дүрэм
- Түгээмэл олон улсын байгууллага
- Бүс нутгийн байгууллага
- Тусгай байгууллага
- Гишүүнчлэл
- Нээлттэй олон улсын байгууллага
- Хаалттай олон улсын байгууллага

Сэдвийн агуулга:

1. Олон улсын нийтийн эрх зүйн субъектын тухай ойлголт
2. Улс - олон улсын нийтийн эрх зүйн анхдагч субъект болох нь
3. Үндэстэн ард түмний эрх зүйн байдал
4. Олон улсын байгууллагын эрх зүйн байдал
5. Олон улсын нийтийн эрх зүйн тусгай субъект
6. Хувь этгээд олон улсын нийтийн эрх зүйн субъект болох асуудал

5. Олон улсын эрх зүй дэх хүлээн зөвшөөрөх асуудал

Зорилго:

Олон улсын харилцаанд шинэ субъект үүсэхтэй холбоотой хүлээн зөвшөөрөх харилцаа, түүний эрх зүйн зохицуулалтын үр дагавар, хэлбэр, төрлийн тухай . мэддэгтэй болж, олон улсын харилцаанд үүссэн, үүсэж болох харилцааг олон улсын эрх зүйн үүднээс үнэлэх, дүгнэх чадвартай болоход оршино.



Нэр томъёо

- de jure
- de facto
- ad hoc
- Конститутив
- Декларатив
- Тобарын онол
- Естрадын онол



Сэдвийн агуулга:

1. Хүлээн зөвшөөрөх ойлголт, түүний эрх зүйн үр дагавар
2. Улсыг хүлээн зөвшөөрөх, түүний хэлбэр
3. Засгийн газрыг хүлээн зөвшөөрөх
4. Хүлээн зөвшөөрөх бусад төрөл

6. Олон улсын эрх зүйн эрх зүйн өвлөлийн асуудал.

Зорилго:

Олон улсын харилцаанд эрх зүйн өвлөлийн харилцаа үүсэх үндэслэл, түүний эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудлуудын тухай мэдлэгтэй болж, олон улсын харилцаанд үүссэн. үүсэж болох харилцааг олон улсын эрх зүйн үүднээс үнэлэх, дүгнэх чадвартай болоход оршино.



Нэр томъёо

- Архив
- Олон улсын гэрээ
- Төрийн өмч хөрөнгө
- Өр төлбөр

Сэдвийн агуулга

1. Эрх зүйн өвлөлийн ойлголт, эх сурвалж
2. Олон улсын гэрээний харилцааны эрх зүйн өвлөл
3. Төрийн өмч, хөрөнгийн эрх зүйн өвлөл
4. Улсын архивийн эрх зүйн өвлөл
5. Улсын өр төлбөрийн эрх зүйн өвлөл

7. Нутаг дэвсгэр ба хүн ам

Зорилго:

Нутаг дэвсгэр түүний эрх зүйн дэглэм, иргэний харьяалал, харьяалал олж авах, алдах, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн, цагаач, дүрвэгчдийн олон улсын нийтийн эрх зүйн зохицуулалт, хамгаалалтын талаар мэдлэгийг эзэмшиж, нутаг дэвсгэрийн дэглэмийн онцлогийг харьцуулах, ертөнцийн орон зайг олон улсын эрх зүйн дагуу ангилах, тодорхойлох, иргэний харьяалалын талаархи Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг Олон улсын эрх зүйтэй харьцуулах, үнэлэлт, дүгнэлт өгөх чадварыг эзэмшинэ.



Нэр томъёо

- Нутаг дэвсгэр /улсын, холимог, олон улсын/
- Улсын хил
- Хилийн дэглэм, хил орчмын дэглэм

- Нээлттэй далай
- Эх газрын хормой
- Эдийн засгийн онцгой бүс
- Залгаа бүс
- Нутаг дэвсгэрийн далай
- Дотоод далайн ус
- Сансрын орон зай
- Харьяалал
- Ургийн зарчим (jus sanguinis)
- Нутаг дэвсгэрийн зарчим Qus soli)
- Харьяалалгүй хүн (апатрид)
- Хоёрдмол харьяалалтай хүн (бипатрид)
- Харьяалал сонгох (оптаци)
- Хүсэлтээрээ харьяалал олж авах (натурализаци)
- Хүсэлтээрээ харьяатаас гарах (экспатриаци)
- Харьяалалаас хасах (денатурализаци)
- Хүндэт иргэн

Сэдвийн агуулга:

1. Нутаг дэвсгэрийн ойлголт, ангилал, дэглэм
2. Улсын хил, түүнийг өөрчлөх зарчим, хил тогтоох үе шат
3. Хүн амын тухай ойлголт
4. Харьяатын тухай Олон улсын нийтийн эрх зүйн асуудлууд
 - харьяалал олж авах
 - харьяалалаа алдах
 - харьяалалгүй болон иргэний хоёрдмол харьяалалтай хүний эрх зүйн байдал
5. Цагаачид, дүрвэгчдийн эрх зүйн байдал

8. Олон улсын гэрээний эрх зүй

Зорилго:

Олон улсын харилцаанд эрх зүйн үндэс болсон олон гэрээ байгуулах үе шат, журам тайлбарлах, хүчин төгөлдөр болох дуусгавар болох, асуудлын талаар мэдлэг эзэмшин, Монгол улсын гэрээний тухай хууль тогтоомжийг харьцуулах дүн шинжилгээ хийх чадвартай болно.



Нэр томъёо

- Олон улсын гэрээ
- Олон улсын гэрээний нэр
- Олон улсын гэрээний тал
- Нийтлэг олон улсын гэрээ
- Бүс нутгийн гэрээ
- Гэрээ байгуулах итгэмжлэл бүхий үнэмлэх



- Ad referendum гарын үсэг зурах
- Үзэглэх
- Соёрхон батлах
- Соёрхон батласан жуух бичиг
- Батлах
- Нэгдэн орох
- Хадгалагч (Цепозитари)
- Бүртгэх, нийтлэх
- Гэрээнд тайлбар (reservation) хийх
- Гэрээг тайлбарлах (interpretation)

Сэдвийн агуулга:

1. Олон улсын гэрээний эрх зүйн тухай ойлголт, мөн чанар, эх сурвалж
2. Олон улсын гэрээний ангилал
3. Олон улсын гэрээний бүтэц
4. Олон улсын гэрээг байгуулах үе шат
5. Олон улсын гэрээнд тайлбар хийх
6. Олон улсын гэрээг тайлбарлах
7. Олон улсын гэрээ хүчин төгөлдөр байх
8. Олон улсга гэрээ дуусгавар болох ба түдгэлзүүлэх

9. Олон улсын нийтийн эрх зүй ба үндэсний эрх зүйн харилцан хамаарлын асуудал

Зорилго:

Олон улсын нийтийн эрх зүй үндэсний эрх зүйн харилцан хамааралтай байх ач холбогдлыг тодорхойлох, харилцан хамаарлын хүрээнд үндсэн асуудлын тухай мэдлэгтэй болж, Монгол улсын эрх зүй болон Олон улсын эрх зүй хоорондын харилцан хамааралд дүгнэлт өгөх чадвартай болно.



Нэр томъёо

- Хууль зүйн хүчин чадалын хувьд давуу хүчинтэй байх
- Дуалист онол
- Монист онол

10. Олон улсын байгууллагын эрх зүй

Зорилго:

Олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн түгээмэл хэлбэр болох олон улсын байгууллагыг үүсгэн байгуулах нөхцөл шалтгаан, чиг үүрэг, эрх хэмжээ, бүтэц, зохион байгуулалтын асуудлыг судлан танилцаж, олон улсын харилцаанд гүйцэтгэх үүрэгт үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай болно.

Сэдвийн агуулга:

1. Олон улсын байгууллагын ойлголт, үндсэн шинж
2. Олон улсын байгууллагын ангилал
3. Засгийн газрийн бус олон улсын байгууллага

11. Дипломатын эрх зүй

Зорилго:

Аливаа улсын гадаад бодлогыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болох дипломат ажиллагаа явуулах байгууллага, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, ангилал зэрэг асуудалтай судлан танилцах ба Монгол Улсын зохих байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтад дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Дипломат төлөөлөгчийн газар
- Дипломат төлөөлөгчийн газрын зэрэглэл
- Элчин яам / нунциатур
- Элчин сайдын яам / интернунциатур
- Агремен
- Итгэмжлэх жуух
- Дипломат/ консулын корпус
- Дуайен
- Эрх ямба
- Дархан эрх
- Тусгай төлөөлөгч

Агуулга

1. Гадаад харилцааны байгууллага, чиг үүрэг
2. Дипломатын эрх зүйн тухай ойлголт, эх сурвалж
3. Дипломат төлөөлөгчийн газар, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, зэрэглэлийн асуудал
4. Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох журам
5. Дипломат төлөөлөгчийн газрын болон тэргүүний үүрэг дуусгавар болох
6. Дипломат эрх ямба, дархан эрх



12. Консулын эрх зүй

Зорилго:

Консулын эрх зүйн тухай ойлголт, эх сурвалж, консулын байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, аниалт зэрэг асуудалтай судлан танилцах ба Монгол Улсын зохих байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтад дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Консулын төлөөлөгчийн газар
- Консулын корпус
- Эрх ямба
- Дархан эрх
- Консулын патент
- Консулын тойрог
- Өргөмжит консул

Сэдвийн агуулга:

1. Консулын эрх зүйн ойлголт, үүсэл, эх сурвалж
2. Консулын байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, зэрэглэлийн асуудал
3. Консулын газар, түүний ажилтны эрх ямба, дархан эрх

13. Хүний эрх

Зорилго:

Хүний эрхийг олон улсын эрх зүйгээр хамгаалах, шаардлага, ач холбогдол, олон улсын гэрээний агуулгын талаар мэдлэгтэй болж, Монгол улсын эрх зүйн хамгаалалтад харьцуулж, дүн шинжилгээ өгөх чадвартай болно.



Нэр томъёо

- Хүний эрхийн үечлэл
- Иргэний эрх
- Улс төрийн эрх
- Нийгмийн эрх
- Эдийн засгийн эрх
- Соёлын эрх
- Эмэгтэйчүүдийн эрх
- Хүүхдийн эрх
- Цөөнхийн эрх
- Хүний эрхийн үндэсний комисс (омбудсман)

Сэдвийн агуулга:

1. Хүний эрхийг олон улсын түвшинд хамгаалахын ач холбогдол, шаардлага
2. Хүний эрхийн үндсэн категори. Иргэний, улс төрийн, нийгмийн, эдийн засгийн, соёлын.
3. Хүний эрхийн салбарт улс хоорондын хамтын ажиллагааны гол баримт бичгийн агуулга. Хүний эрхийн олон улсын стандарт.

14. Хүний эрхийг хамгаалах олон улсын механизм

Зорилго:

Хүний эрхийг олон улсын эрх зүйгээр хамгаалах хэрэгцээ, шаардлага, ач холбогдол, олон улсын эрх зүйн хамгаалалтын механизмын талаар мэдлэгтэй болж, Монгол улсын эрх зүйн хамгаалалтад харьцуулалт хийж дүн шинжилгээ өгөх чадвартай болно.



Нэр томъёо

- Хүний эрхийн билл
- Хүний эрхийн хяналтын механизм
- Бүс нутгийн тогтолцоо
- Хүний эрхийн байгууллага

Сэдвийн агуулга:

1. Хүний эрхийг олон улсын түвшинд хамгаалахын ач холбогдол, хэрэгцээ шаардлага
2. НҮБ хүний эрхийг хамгаалах механизм болох нь
3. Хүний эрхийн конвенцийн байгууллагууд

15. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй

Зорилго:

Зэвсэгт мөргөлдөөний үед үйлчлэх эрх зүйн зарчим, хэм хэмжээ мөн дайн явуулах арга, хэрэгслийг хориглосон, хязгаарласан, зэвсэгт мөргөлдөөний үед хүний эрхийг хамгаалах, хариуцдагын тогтолцоо зэрэг асуудлыг судлан танилцах ба Монгол Улсын эзлэх байр суурь, өнөөгийн практикт дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Зэвсэгт мөргөлдөөн
- Дайн, дайны байдал
- Түрэмгийлэл
- Бүс нутгийн зэвсэгт мөргөлдөөн



- Дайн явуулах арга, хэрэгсэл
- Дайн явуулах хориглосон арга, хэрэгсэл
- Төвийг сахих
- Дайтагч
- Дайтагч бус
- Тагнуул
- Туршуул
- Цэргийн олзлогдогчид
- Шархадсан этгээд
- Өвчтөн
- Далайд осолдсон этгээд
- Хөлсний цэрэг

Агуулга

1. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн тухай ойлголт, эх сурвалж. "Гаагын" болон "Женевийн" дүрэм
2. Дайны үр дагавар. Дайны үед төвийг сахих
3. Байлдааны үйл ажиллагаа явуулахад хориотой арга хэрэгсэл
4. Зэвсэгт мөргөлдөөний үед хүний эрхийг хамгаалах
5. Зэвсэгт мөргөлдөөний үед иргэний байгууламж, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах
6. Дайн байдал ба байлдааны ажиллагааг төгсгөл болгох эрх зүйн журам

16. Олон улсын эрүүгийн эрх зүй

Зорилго:

Олон улсын хамтын ажиллагааны чухал салбар болох гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг судлан олон улсын болон олон улсын шинжтэй гэмт хэргийн талаархи ойлголт, бүрэлдэхүүн, шинж, болон эх сурвалжийг судлан танилцахаас гадна энэ хамтын ажиллагаанд Монгол Улсын эзлэх байрсуурь, өнөөгийн ирактикт дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Хувийн хариуцлагын зарчим
- Дээд албан тушаалын байдал ял, шийтгэлээс чөлөөлөх, эсхүл хөнгөлөх нөхцөл болсгүй байх зарчим
- Тушаал гүйцэтгэсэн байдал нь ял, шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй байх ба түүнийг хөнгөлөх нөхцөл болох зарчим
- Ne bis in idem
- Түрэмгийллийн гэмт хэрэг
- Дайны гэмт хэрэг
- Хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг
- Төрлөөр устгах гэмт хэрэг

Сэдвийн агуулга:

1. Олон улсын эрүүгийн эрх зүйн ойлголт, зарчим
2. Олон улсын болон олон улсын шинжтэй гэмт хэрэг
3. Олон улсын эрүүгийн Ромын шүүх

17. Олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа

Зорилго:

Олон улсын хамтын ажиллагааны чухал салбар болох гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг судлан, олон улсын шинжтэй гэмт хэргийн талаархи ойлголт, бүрэлдэхүүн, шинж, болон эх сурвалжийг судлан танилцахаас гадна энэ хамтын ажиллагаанд Монгол Улсын эзлэх байр суурь, өнөөгийн практикт тодорхой хэмжээгээр дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Экстрадаци
- Интерпол

Сэдвийн агуулга

1. Гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааны ойлголт, хэлбэр
2. Олон улсын шинжтэй гэмт хэрэг
3. Эрүүгийн хэрэгт эрхийн туслалцаа үзүүлэх, гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх
4. Олон улсын байгууллага

18. Олон улсын эдийн засгийн эрх зүй

Зорилго:

Олон улсын эдийн засгийн эрх зүйн асуудлыг судлан эдийн засгийн дэглэмийн талаархи ойлголт, шинж болон эх сурвалжийг судлан танилцахаас гадна энэ салбар дахь хамтын ажиллагаанд Монгол Улсын эзлэх байр суурь, өнөөгийн практикт тодорхой хэмжээгээр дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Үндэсний дэглэм
- Үлэмж найр тавих
- Онцгой дэглэм
- Үндэстэн дамнасан хуулийн этгээд
- Дэлхийн худалдааны байгууллага

Сэдвийн агуулга:

1. Олон улсын эдийн засгийн эрх зүйн тухай ойлголт
2. Олон улсын эдийн засгийн эрх зүйн субъект



3. Олон улсын эдийн засгийн эрх зүйн эх сурвалж, зарчим
4. Олон улсын эдийн засгийн эрх зүйн дэглэм
5. Олон улсын худалдаа, гааль, санхүү, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт

19. Олон улсын аюулгүй байдлын эрх зүй

Зорилго:

Олон улсын хамтын ажиллагааны үндэс нь олон улсын энх тайван, аюулгүй байдлын баталгаа байдаг. Энэхүү баталгааг хамтын аюулгүй байдлын тогтолцоогоор хангадаг. Уг сэдвийн хүрээнд хамтын аюулгүй байдлын талаархи асуудалтай судлан танилцах ба Монгол Улсын эзлэх байр суурь, өнөөгийн практикт тодорхой хэмжээгээр дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Олон улсын аюулгүй байдал
- Хамтын аюулгүй байдлын тогтолцоо
- Маргаан, маргаант байдал
- Эв зүйгээр шийдвэрлэх
- Албадлагын арга хэмжээ
- Хүч хэрэглэх, заналхийлэх
- Түрэмгийлэл
- Улсын аюулгүйн байдал
- Зэвсэг хураах ба зэвсэглэлийн хязгаарлалт
- Цөмийн зэвсэггүй байх статус
- Төвийг сахих бүс, улс

Сэдвийн агуулга:

1. Олон улсын аюулгүй байдлын эрх зүйн тухай ойлголт, тусгай зарчим
2. Бүх нийтийн хамтын аюулгүй байдлын тогтолцоо
3. НҮБ-ын гүйцэтгэх үүрэг. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа.
4. Зэвсэглэлийг дэлгэрүүлэхгүй байх олон улсын нийтийн эрх зүйн дэглэм. Цөмийн зэвсэггүй бүс. Бүх л улс цөмийн зэвсэггүй бүс болох асуудал. Монгол Улсын статус.
5. Олон улсын аюулгүй байдлыг хангахад төвийг сахих статусын гүйцэтгэх үүрэг

20. Олон улсын далайн эрх зүй

Зорилго:

Далайд гарцгүй манай улсын хувьд маш чухал салбар болох олон улсын далайн эрх зүйн асуудлыг судлан далайн бус, түүнд үйлчлэх дэглэмийн талаархи ойлголт, шинж, болон эх сурвалжийг судлан танилцахаас гадна энэ салбар дахь хамтын ажиллагаанд Монгол Улсын эзлэх байр суурь, өнөөгийн практикт дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Нээлттэй далай
- Эх газрын хормой
- Эдийн засгийн онцгой бүс
- Залгаа бүс
- Нутаг дэвсгэрийн далай
- Дотоод далайн ус

Сэдвийн агуулга:

1. Олон улсын далайн эрх зүйн ойлголт, эх сурвалж
2. Далайн орон зайн ангилал. Дотоод далайн ус. Нутаг дэвсгэрийн далай. Нээлттэй далай. Залгаа бүс. Эх газрын хормой. Эдийн засгийн онцгой бүс
3. Далайн орон зай дахь дэглэм
4. Далайд гарцгүй улсын эрх зүйн байдал

21. Олон улсын агаарын эрх зүй

Зорилго:

Олон улсын иргэний нислэгийн эрх зүйн асуудлыг судлан агаарын орон зай, түүний эрх зүйн байдал, үйлчлэх дэглэм, олон улсын байгууллага зэрэг асуудлын талаархи ойлголт, эх сурвалжийг судлан танилцахаас гадна энэ салбар дахь хамтын ажиллагаанд Монгол Улсын эзлэх байр суурь, өнөөгийн практикт дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Чөлөөт нислэгийн зарчим
- Бүрэн бөгөөд онцгой бүрэн эрхийн зарчим
- Нислэгийн аюулгүй байдлыг хангах зарчим

Сэдвийн агуулга:

1. Агаарын олон улсын нийтийн эрх зүйн тухай ойлголт, эх сурвалж, зарчим
2. Агаарын орон зайн эрх зүйн байдал
3. Иргэний агаарын нислэг
4. Агаарын харилцаа, холбоо
5. Агаарын олон улсын байгууллага

22. Олон улсын сансрын эрх зүй

Зорилго:

Сансрын орон зай, түүнд үйлчлэх дэглэмийн талаархи ойлголт, шинж, болон эх сурвалжийг судлан танилцахаас гадна энэ салбар дахь хамтын ажиллагаанд Монгол Улсын эзлэх байр суурь, өнөөгийн практикт дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Сансар
- Сансрын орон зай
- Сансрын эрхэс биет
- Сансрын объект
- Энхийн зорилгоор ашиглах

Сэдвийн агуулга:

1. Олон улсын сансрын эрх зүйн тухай ойлголт, эх сурвалж
2. Сансрын орон зай ба сансрын эрхэс биетийн олон улсын эрх зүйн дэглэм
3. Сансрын объект болон нисэгчийн олон улсын эрх зүйн дэглэм
4. Сансрыг энхийн зорилгоор ашиглах хамтын ажиллагааны үндэс
5. Олон улсын сансрын эрх зүйн дагуу хүлээх хариуцлага

23. Олон улсын олон нийгмийн мэдээлэлийн эрх зүй

Зорилго:

Олон нийтийн мэдээлэлийн хэрэгслийн ойлголт, олон улсын олон нийтийн мэдээлэлийн эрх зүй, зарчим, энэ салбарын улсуудын хамтын ажиллагааны хэлбэрийн тухай мэдлэгтэй болж, уг хамтын ажиллагаанд Монгол Улсын эзлэх байр суурь, өнөөгийн практикт дүн шинжилгээ хийхэд оршино.

Сэдвийн агуулга:

1. Олон нийтийн мэдээлэлийн хэрэгслийн ойлголт
2. Олон улсын олон нийтийн мэдээлэлийн эрх зүйн ойлголт, зарчим
3. Олон улсын олон нийтийн мэдээлэлийн салбар дахь улсуудын хамтын ажиллагаа
4. Олон улсын сэтгүүлчийн эрх зүйн байдал

24. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах олон улсын эрх зүй

Зорилго:

Хүрээлэн байгаа орчныг хамгаалах олон улсын эрх зүйн асуудлыг судлан түүний зарчим, эх сурвалжийн ойлголт, шинж, болон эх сурвалжийг судлан танилцахаас гадна энэ салбар дахь хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцоо, өнөөгийн практикт дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Хүрээлэн буй орчин
- Амьтан, ургамлын аймгийг хамгаалах
- Озоны давхарга
- Цаг агаарын өөрчлөлт
- Байгалийн тэнцэл
- Цөлжилт

Сэдвийн агуулга:

1. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах олон улсын эрх зүйн тухай ойлголт, зарчим, эх сурвалж
2. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах салбар дахь Олон улсын байгууллага ба бага хурал

25. Олон улсын цөмийн эрх зүй

Зорилго:

Цөмийн энергийг энх тайваны зорилгоор ашиглах, цөмийн зэвсгийн аюулаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой улсуудын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний эх сурвалж, зарчим, улсуудын хамтын ажиллагааны хэлбэрийн тухай мэдлэгтэй болж, энэ салбар дахь олон улсын байгууллага, хамтын ажиллагаанд Монгол Улсын оролцоо, өнөөгийн практикт дүн шинжилгээ хийхэд оршино.



Нэр томъёо

- Цөмийн энерги
- МАГАТЭ
- Цөмийн зэвсэггүй бүс

Сэдвийн агуулга:

1. Олон улсын цөмийн эрх зүйн тухай ойлголт, эх сурвалж
2. Цөмийн зэвсгийг энхийн зорилгоор ашиглах хамтын ажиллагаа
3. Цөмийн зэвсгийн аюулаас сэргийлэх
4. Цөмийн зэвсэггүй бүсийн ойлголт,

26. Олон улсын нийтийн эрх зүйн хариуцлага

Зорилго:

Олон улсын нийтийн эрх зүйн хариуцлагын институтын хүрээнд үндсэн асуудлуудын талаар онолын мэдлэг олж, Олон улсын нийтийн эрх зүйн субъектэд хариуцлага оногдуулах үндэслэл, хариуцлагын хэлбэр, төрөл, чөлөөлөгдөх үндэслэлийг тодорхойлох, холбогдох эх сурвалжыг сонгож хэрэглэх, ангилах чадварыг хөгжүүлэхэд оршино.



Нэр томъёо

- Олон улсын зөрчил
- Олон улсын гэмт хэрэг
- Олон улсын шинжтэй гэмт хэрэг
- Материаллаг хариуцлага
- Материаллаг бус хариуцлага

Агуулга:

1. Олон улсын нийтийн эрх зүйн хариуцлагын ойлголт
2. Олон улсын нийтийн эрх зүйн субъектын хариуцлага хүлээх үндэслэл
3. Олон улсын нийтийн эрх зүйн зөрчил, ангилал
4. Олон улсын нийтийн эрх зүйн хариуцлагын хэлбэр, төрөл
5. Олон улсын нийтийн эрх зүйн хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцөл
6. Олон улсын байгууллагын хүлээх хариуцлага

27. Олон улсын маргааныг шийдвэрлэх арга зам

Зорилго:

Олон улсын харилцаанд үүсэх маргааны ойлголт, түүнийг Олон улсын нийтийн эрх зүйн дагуу шийдвэрлэх аргын тухай онолын мэдлэгийг эзэмшиж, маргааныг тодорхойлох болон шийдвэрлэх механизмыг сонгох чадварыг эзэмшихэд оршино.



Нэр томъёо

- Олон улсын маргаан
- Маргаант байдал

Агуулга:

- Олон улсын нийтийн эрх зүйн маргааны ойлголт, төрөл
- Олон улсын нийтийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх зарчим, арга
- Шууд хэлэлцээр
- Найрсаг туслалцаа
- Зуучлал
- Магадлан шалгах
- Эвлэрэл
- Хөндлөнгийн шүүх
- Олон улсын шүүх

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА ЗҮЙ

Заах арга зүйд тавигдах шаардлага

Олон улсын нийтийн эрх зүй хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага, хичээлийн зорилготой уялдан энэхүү хичээлийг заах арга зүйд дараахь шаардлага тавигдана. Үүнд:

- Хичээлийн зорилгыг хангахуйц арга хэлбэрийг сонгох, агуулгад тохирсон байх
- Олон улсын нийтийн эрх зүйн талаар мэдлэг бүтээх, бүтээсэн мэдлэгээ практикт хэрэглэх, дүн шинжилгээ хийх чадварыг хөгжүүлэх нөхцөл боломжийг хангасан байх
- Оюутанд хичээлд жигд оролцох боломжийг бүрдүүлсэн байх

Мэдээлэл түгээх арга

Лекц /Lecture/

Лекцийн арга нь сэтгэлгээний мэдлэг, ойлголтын түвшний зорилтыг хангахад илүү үр дүнтэй байдаг. Харин дараах зорилтыг хангахад лекц тохиромжтой бус

- Оролцогчдын идэвхийг нэмэгдүүлэх
- Мэдээллийг хэрэглэх
- Дээд түвшний танин мэдэхүйн чадавхийг хөгжүүлэх
- Шүүмжлэлтэй хандах ур чадварыг төлөвшүүлэх
- Суралцагчдын хандлагыг өөрчлөх

Энэ аргыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

Хүн анхаарлаа дунджаар 15-20 минут төвлөрүүлж чаддаг тул лекц үүнээс урт хугацаагаар үргэлжлэх ёсгүй бөгөөд боломжтой нөхцөлд сургалтын үр ашгийг дээшлүүлэх үүднээс хэлэлцүүлэг, дүрд хувирах, биечлэн үзүүлэх зэрэг бусад аргыг нэмж ашиглах нь зүйтэй.

Хүн нэг зэрэг 7-оос илүүгүй мэдээллийг л тогтоох боломжтой гэж судлаачид дүгнэсэн байдаг. Мөн барууны судлаачдын дүгнэснээр хүмүүсийн 60-65 хувийнх нь харааны ой (харж сурах), 20-25 хувийнх нь сонсох ой (сонсож сурах) илүү хөгжсөн байдаг бол 15-20 хувь нь үйл хөдлөлөөр (хийж сурах) дамжуулж сурдаг.

Багш ярихын (лекц) хажуугаар үзүүлэн таниулах материал ашигласан тохиолдолд суралцагчдын тогтоох мэдээллийн хэмжээ 25 хүртэл хувиар нэмэгддэг бол заалгасан зүйлээ туршиж хэрэглэсэн нөхдөлд энэ үзүүлэлт 70 хувь хүртэл өсдөг (Бэфелийн Үндэсний сургалтын лаборатори).

Эвлүүлгийн арга /Jacksaw/

Энэ арга нь оролцогчдод богино хугацаанд их мэдээлэл олж авах боломж олгодог ба лекцийг орлуулахад ашигладаг.



Зорилго: Энэ арга нь бие биедээ сургах боломж олгодог. Бие биедээ сургах энэхүү арга нь тухайн хичээлээр мэдээлэл олж авах болон хүнд хэцүү хичээлийг тайлбарлах, асуулт асуух, бусадтай харилцах ба сонсох чадварыг амьдралд хэрэглэхэд хамгийн үр дүнтэй.

"Эвлүүлгийн" аргыг хэрэглэх үе шат:

Зарим хичээлээр оюутнуудад маш их мэдээлэл олгох хэрэгтэй байдаг. Энэ тохиолдолд тухайн мэдээлэл, лекцийн агуулга болон бусад нэмэлт хэрэглэгдэхүүнийг тухайн ангид ажиллах багийн тоогоор хувааж бэлтгэсэн байна. Бэлтгэсэн материалаа нэг дугтуйд хийж багуудад тараан өгөх болно.

Мөн оролцогчдыг багт хуваахдаа ашиглах өнгийн цаасыг бэлдэнэ.

Эхлээд "гэрийн" багийг (1,2,3-аар тоолуулан) бүрдүүлнэ. Багийн гишүүн тус бүр өөр өөр өнгийн цаастай байна. Жишээ нь: 1-р багт 5 гишүүн байгаа бол хүн тус бүрт өөр өөр өнгийн цаас байна. (нэг нь улаан, нөгөө нь цэнхэр, гурав дахь нь ногоон, дөрөв дэхь нь шар гэх мэт).

Гэрийн" багийн гишүүд одоо шинэ газар очиж, эрдэм сурч ирээд бие биедээ сурсан эрдмээ заах болно гэдгийг хэлээд гэрийн баг бүрт байгаа адил өнгийн цаастай хүмүүсийг дахин шинэ баг үүсгэхийг хүснэ. Шинээр үүссэн энэ баг бол "Мэргэжилтнүүд"-ийн баг бөгөөд энд та бүхэн шинэ юм мэдэж авах болно гэдгийг хэлнэ.

"Мэргэжилтнүүд"-ийн багуудад бэлтгэсэн ууттай материалуудыг өгч, ажиллах заавраар хангана. Тухайлбал,

- дүрүүдийг хуваарилах хөтлөгч, цаг харагч, асуулт тавигч г.м
- тараасан ууттай материалыг уншиж, ярилцах
- асуултад хариулж буй сурагч бүгд материалыг ойлгосон гэдэгт итгэлтэй байхыг тулд бусдаасаа асуух.
- багийн гишүүд өөрийн "гэрийн" багийнхандаа чухам юуг заахаа шийдэх.

Тэдэнд "мэргэжилтэн" болоход хангалттай хугацаа өгөх хэрэгтэй. Баг бүрт очиж материалаа ойлгож байгаа эсэх, гэрийхэндээ очоод яаж тайлбарлах талаар ярилцаж туслах хэрэгтэй байдаг.

Суралцагчид "гэрийн" багтаа буцаж очно. "Гэрийн" багт "мэргэжилтнүүдийн багаас нэг юг төлөөлөгч буцаж ирнэ. Өөрсдөө юу сурсанаа багийн гишүүддээ нэг нэгээрээ зааж өгнө. Материалын их бага, хүнд хөнгөнөөс шалтгаалаад дахиад нэг бүтэн хичээл шаардагдаж магадгүй.

Шалгах асуулт бэлдээд тэдний юу сурсныг нь дүгнэнэ. Мөн шаардлагатай нэмэлт мэдээллийг өгнө.

Хүн бүр багш /Each one teach one/

Бүлэг сэдвийг танилцуулахад болон үзсэн сэдвийн агуулга, ухагдахуунуудыг дүгнэх, лекцийн агуулгыг хүргэхэд энэ аргыг гол төлөв хэрэглэнэ.

Зорилго: Сургалтын үйл явцад идэвхтэй оролцох болон бие биетэйгээ санаа бодлоо солилцоход оролцогчдод ихээхэн ач холбогдолтой болно. Энэ аргыг хэрэглэснээр хичээлийн үед заавал эзэмших ёстой агуулга болон ухагдахууны талаар ерөнхий ойлголт өгөх ба тэдний сонирхолыг өдөөж, асуулт тавихад хүргэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

Лекцийн агуулга, мэдээллийг утгат хэсгээр нь хувааж, хүн бүрд тарааж өгөх зорилгоор жижиг цаасан дээр бичиж бэлдэнэ. Энэ нь таны сургалтад оролцогчдын тоогоор байх ёстойг анхаараарай.

Оролцогчид мэдээллийг уншсаны дараа уг уншсан зүйлийнхээ агуулгыг ярих, зураглал, бүдүүвчээр илэрхийлэх зэргээр бусдад түгээх бэлтгэлээ хийнэ. Энэ үед багш тусламж шаардлагатай хүн дээр очиж зөвөлгөө өгч, тайлбарлаж болно.

Бэлтгэх хугацаа дууссаны дараа тэд мэдээллээ бие биедээ танилцуулж ангиа тойрон явна. Хүн бүр өөрт буй мэдээллээ танилцуулж, бусдаас мэдээлэл авч дуустал энэ ажил үргэлжилнэ. Зорилго нь бусадтай мэдээлэл солилцох буюу өөрт буй мэдээллээ бусдад тарааж, шинэ мэдээлэл бусдаас олж авахад оршино.

Энэ ажлыг дууссаны дараа багш бие биенээсээ юу мэдсэн, ямар шинэ мэдээлэл авсан тухай, уг мэдээллийг юу гэж ойлгож байгаа тухай, энэ мэдсэн зүйл өөрт нь ямар хэрэг болох тухай ярилцуулна.

Ярилцлагын явцад оюутнуудад юу хэрэгтэй байгаа, тэдний бие биеэсээ авсан мэдээллийг хэрхэн цэгцлэх шаардлагатайг багш ажиглаж, тэр дагуу нэмэлт мэдээллийг өгнө.

Оролцооны арга

Маргаамтай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга

Маргаантай асуудлыг яагаад хэлэлцэх хэрэгтэй вэ?

Хичээлийн хүрээнд эсрэг тэсрэг үзэл бодлыг хамтран хэлэлцэж сурсан оюутнууд бодит байдал дээр улсын удирдлагын үүрэг болон үйл ажиллагааны хэлбэрийн талаар санал бодлоо илэрхийлэх болон мэдээлэл солилцох дадлаа хэрэгжүүлэх бололцоотой байдаг.

Судалгаанаас үзэхэд маргаантай асуудлаар хэлэлцүүлэг хийх аргаар хичээлийг явуулахад оюутанд дараахь чадвар, хандлага төлөвших боломжтой. Үүнд:

- Нийгмийн болон иргэний амьдралд идэвхтэй байр суурь эзлэх эрмэлзлэлтэй болох
- Төрийн удирдлага болон улс төрийн, нийгмийн чухал асуудлуудыг олон талаас нь шүүмжлэлтэйгээр эргэцүүлэн бодож, түүнийгээ илэрхийлэх чадварт суралцах
- Эсрэг, тэсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, ойлгож, няцаах нотолгоог дэвшүүлэх чадвар хөгжих.

Хичээлээр хэлэлцэх маргаантай асуудлыг сонгох шалгуур:

- Асуудлыг олон талаас нь авч хэлэлцэх боломжтой эсэх
- Энэхүү асуудал үнэхээр маргаантай асуудал мөн эсэх
- Хуулийг дээдлэхэд болон ардчиллыг хөгжүүлэхэд энэхүү асуудал нь чухал ач холбогдолтой эсэх
- Энэ асуудал суралцагчдын хувьд чухал эсэх
- Энэ асуудал нь тухайн ангид хэлэлцэхэд тохиромжтой эсэх

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд баримтлах дүрэм:

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд хувь хүний үзэл бодлыг хөндөх ба сэтгэлийн



Хөдөлгөөн үүсгэдэг учраас заримдаа түүнийг зохион байгуулалттай дарааллаар хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Иймээс хичээлийг дээд зэргийн түвшинд явуулах, үүссэн байдлыг хяналтандаа байлгахад дараах дүрэм нь багшид тус болно. Тухайлбал, дүрмийг зөвшилцож гаргаад бүгд биелүүлнэ.

- Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.
- Цаг барьж, ганцаараа ярихаас зайлсхийнэ.
- Уриа хэрэглэхээс зайлсхийнэ.
- Маргааныг хийсвэр түвшинд хүргэхээсээ өмнө тодорхой асуудлуудаар ярилцана.
- Таны байр сууринд эргэлзэх бололцоог бусдадаа олгоно.
- Өөрийн байр суурийн эргэлзээтэй зүйл, хүнд хэцүү болон сул талуудыг хүлээн зөвшөөрнө.
- Бусдын санааг өөрчлөн хэлэх замаар ойлгож сурна. Ийм дадалтай болгохын тулд бусдаас сонссоноо өөрчлөн хэлж сурна.
- Үзэл бодол болгонд хүндэтгэлтэй хандана.

Байр сууриа илэрхийлэх арга

Энэ арга нь маргаантай асуудлыг хэлэлцэхэд ихээхэн ач холбогдолтой. Маргаантай асуудал нь хууль зүйн үндэслэлтэй, зөв хариулт байхгүй, 2-ба түүнээс дээш эсрэг байр суурьтай байх ёстой.

Зорилго: Үзэж буй сэдвийн хүрээнд олон янзын эсрэг байр сууриуд байдаг гэдгийг харуулах, суралдагчдад өөрсдийн байр сууриа илэрхийлэх болон харилцааны чадвараа амьдралд хэрэглэх боломж олгох зэрэг болно. Тухайн сэдвийг суралцагчид хэрхэн ойлгосныг үнэлж дүгнэх үүднээс мөн хичээлийн эцэст хэрэглэж бас болно.

Хэрэгжүүлэх дараалал:

Ангийн булангуудад хэлэлцэх асуудлын сэдвээс хамааран "Санал бүрэн нийлж байна", "Санал нийлж байна", "Шийдээгүй буюу эргэлзэж байна", "Санал нийлэхгүй байна", "Санал бүрэн нийлэхгүй байна" эсвэл "Маш зөв", "Зөв", "Шийдээгүй буюу эргэлзэж байна", "Буруу", "Маш буруу" гэсэн бичиг бүхий цаасыг дээрх дарааллаар байрлуулсан байна.

Энэ дасгал ажлыг хэрхэн хийх талаар дүрэм зохиогоод түүнийгээ хэлэлдэж батлана. Дүрмийн жишээг доороос үзнэ үү.

- Хэлэлцэж буй асуудлын хүрээнд суралцагчид өөрсдийн байр суурийг илтгэсэн бичиг бүхий буланд очиж зогсоно.
- Суралцагчдыг өөрсдийн байр суурийг тодруулж тайлбарлахыг хүснэ. Бүх суралцагчдыг хамруулах үүднээс ижил сонголттой сурагчид нэг багийг үүсгэж ярилцаад байр сууриа танилцуулахад бэлдэнэ.
- Өөрсдийн байр сууриа тайлбарласны дараа хэн нэг нь байр сууриа өөрчилж өөр буланд очихыг хүсэхгүй байгаа эсэхийг асууна. Хэрэв өөрчлөх хүсэлтэй хүн гарвал яагаад ингэх болсон шалтгааныг асууна.
- Эсрэг баримтлалын дэвшүүлсэн үндэслэлээс аль нь хамгийн үнэмшилтэй байсныг асууна.

Байр сууриа илэрхийлэхэд баримтлах дүрэм

- Өөрийнхөө ярих ээлжийг хүлээх.
- Нэг нь ярьж байхад бусад нь чимээгүй сонсох.
- Шинэ санал, үндэслэл гаргах.
- Бие биетэйгээ маргалдахгүйгээр, соёлтой харьцах.
- Өөрийнхөө байр суурийг хэзээ ч өөрчилж, өөр буланд очиж болно. Гагцхүү яагаад үзэл бодлоо өөрчлөх болсон шалтгаанаа хэлнэ.
- Бусад хүмүүсийн үзэл бодлыг сонсож, хүндэтгэх.
- Бусад үзэл баримтлал, үндэслэлээс илүү их таалагдсанаа тайлбарлах.

Байр сууриа илэрхийлж сурахын тулд дагаж мөрдөх үе шат:

- Өөрийн үзэл бодлоо тодорхойлох.
- Өөрийн үзэл бодлыг хамгаалсан нэг шалтгааныг хэлэх.
- Өөрийн хэлсэн шалтгаан тодруулах нэг жишээ хэлэх.
- Өөрийн үзэл бодлоо нэгтгэх.

Жишээ:

- Би тасалгаанд хүмүүс тамхи татахын эсрэг байна.
- Тамхи татах нь тамхичдад хортойгоос гадна тасалгаанд байгаа тамхи татдаггүй хүмүүст ч мөн хортой.
- "Идэвхгүй" байдлаар тамхи татах нь хорт хавдарт хүргэдэг гэдгийг судалгаа харуулсан.
- Ийм учраас би хүмүүсийг тасалгаанд тамхи татуулахын эсрэг байдаг.

Багаар ажиллах /Group work/

"Жижиг багаар ажиллах" энэхүү арга нь бусдыг анхааралтай сонсох, нэгдсэн дүгнэлтэнд хүрэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, багийг буюу хэсэг бүлгийг төлөөлөх зэрэг чадварыг амьдралд хэрэглэх боломжийг оюутанд олгодог учир ихээхэн дэлгэрсэн юм.

Зорилго: Энэхүү арга нь хамтран ажиллах болон бусдыг ойлгох зэрэг чухал чадваруудыг эзэмших боломжийг олгодог. Үүнээс гадна өөр хоорондоо зөрүүтэй бодол санааг нийцүүлэхэд тусалдаг.

Жижиг багаар ажиллуулахад юу анхаарах хэрэгтэй вэ?

Суралцагчид тухайн ажлыг гүйцэтгэх мэдлэг, дадал, чадвар эзэмшсэн байх ёстой. Эзэмшээгүй тохиолдолд тэд тухайн даалгаврыг хийж гүйдэтгэх ямар ч сонирхолгүй байх тул та үүнийг нэн түрүүнд мэдэх шаардлагатай.

- Багт ажлын зааварчилгааг маш тодорхой өгөх ёстой. Нэг дор (хэдий маш тодорхой ч) хоёроос дээш зааварчилгаа өгөхгүй байх.
- Жижиг багт тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд хангалттай цаг хугацаа олгох ёстой. Түрүүлж ажлаа дуусгасан багийг бусаддаа саад болгохгүйн тулд юу хийлгэхээ сайтар төлөвлөсөн байна.
- 2-4 гишүүнтэй баг бүрдүүлэх. Гэхдээ эхлээд 2-3 гишүүнтэй багтай ажиллах. Жижиг багийн хувьд 5 гишүүнтэй байх нь хамгийн дээд хэмжээ байна. 5-аас дээш хүнтэй баг бүрдүүлж үл болно.



- Бие дааж болон хамтаараа ажиллах чадварыг зэрэг хөгжүүлэх буюу тэнцвэртэй байлгахыг зорьсон асуудал, даалгаврыг өгөх ёсгүй. Учир нь жижиг багаар ажиллах аргыг ширээ тойрон сууж бие даан ажиллах чаднарыг бус зөвхөн хамтаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд л ашиглах нь илүү тохиромжтой байдаг.
- Энэ аргыг тодорхой зорилготойгоор, тохиромжтой үед, дүрмийн дагуу хэрэглэх ёстой болохоос биш улиг домог болсон лекцийг орлуулах нэгэн арга болгон ашиглаж үл болно.
- Баг доторх удирдлагын асуудлыг мон тооцож үзэх ёстой. Багаас нэг гишүүн хийсэн зүйлээ танилцуулах тохиолдолд тэр суралцагчийг шударгаар сонгоход анхаарах.
- Багаар ажиллахад гарах дуу чимээг хүлээн зөвшөөрөх ёстой.
- Жижиг багаар ажиллах явцад суралцагчид бие биеийнхээ нүдийг харах боломжтой байдлаар суусан байна. Гишүүн тус бүр бусад гишүүдээ төвөггүйгээр харж, харьцах ёстой.

Хэрэг шинжлэх /Case method/

Хэрэг шинжлэх арга нь суралцагчдад эрх зүйн хэм хэмжээг амьдралын тодорхой жишээн дээр үндэслэн хэрэглэж сурахад туслахад чиглэгдсэн асуултын аргад тулгуурласан хэлбэр юм. Тодорхой жишээ гэдэг нь түүхэн явдал, бодит хэрэг, зохиомол үйл явдал, шүүхийн сонсгол мэдээ зэрэг суралцагчдад нийгэм, эрх зүй, хүний эрхийн асуудлаар шинэ сэргэг ойлголт, мэдлэг өгөх, асуудалд олон талаас нь шүүмжлэлтэй, нухацтай хандах сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдэж ашиглагдах хэрэглэгдэхүүн юм.

Сургалтын хэрэг ихэвчлэн эх бичвэрийн хэлбэртэй байдаг боловч кино болон дүрс бичлэг, дуу хураагчид бичигдсэн, дүр бүтээж тоглох болон бусад хэлбэрээр байж болно.

Хэрэг шинжлэх аргыг хэрэглэхийн тулд амьдрал, практикт гарч байсан тухайн эрх зүйтэй холбоотой хэрэг маргааны талаарх янз бүрийн мэдээлэл, хууль тогтоомж, эрх зүйн акт болон холбогдох гарын авлагуудыг бэлтгэсэн байх зайлшгүй шаардлагатай.

Зорилго:

Сургалтын энэ арга нь суралцагчийг ямар нэгэн бодит баримтын талаар асуулга тавих, тухай бүрийн тодорхой нөхцөлд ямар элемент нь чухал болохыг тодорхойлж, тэдгээрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж, тохиолдол бүрт эргэцүүлэн бодож байх боломж олгодог. Тохиолдлыг шинжлэх явцдаа суралцагчид нь цээжлэн тогтоох эхний хэлбэрээс эхлээд бодит баримтыг үнэлэх хүртэлх сэтгэхүйн үйлүүдийг хийж дадлагажих батно. Түүнчлэн оюутнууд шүүхийн шийдвэр болон хэрэг маргаанд дүн шинжилгээ хийх, хууль хэрэглэх дадал, арга зүй олгох, гэрээ байгуулах, оюутнуудын уг хичээлийг сонирхон судлах идэвхийг өрнүүлэхэд энэ аргын зорилго оршино.

Хэрэг шинжлэх аргыг яагаад хэрэглэдэг вэ?

- Тоймлосон дүгнэлт. тодорхой үзэл санааг гаргадаг.
- Харьцангуй өндөр түвшинд хийсвэрлэн сэтгэх боломжийг хангадаг.

- Суралцагчдын дотоод сэтгэлгээний дадлага, чадварыг хөгжүүлж, бие даасан задлан шинжилгээ хийх болон шийдвэр гаргах хүнд бэрх сэтгэн бодох үйлдэлд дасгана.
- Хүний сэтгэл, хөдлөл, мэдрэмжийг таниулахын зэрэгцээ суралцагчдын дүрслэн бодох сонирхол, сэтгэлгээг өдөөдөг.
- Танхимд суралцаж буй суралцагчдыг бодит амьдралын туршлага, жишээтэй сэтгэлгээний хувьд холбоотой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Суралцагчдад мэдсэн, сурснаа хэрэглэх боломж олгохын зэрэгцээ хүний эрх, эрх зүйн салбарт шинэ үзэл санаа, ойлголт, зарчмыг хөгжүүлэхэд нөлөөлнө.

Хэрэг шинжлэх аргыг хэрэглэхэд тавих хязгаарлалт болон санамж:

Хэдийгээр авч байгаа тохиолдол нь бодит байдлын тусгал болдог ч жинхэнэ бодит байдал хараахан биш юм. Нэг ч жишээ жинхэнэ бодит байдлыг орлохгүйг санах хэрэгтэй. Зарим тохиолдолд жинхэнэ байдал дээр шийдвэр гаргахдаа танхимын сургалтын жишээнд үзүүлж хэрэглэх аргагүй тийм үл мэдэгдэм, үл ойлгогдох баримтад үндэслэхэд хүрдэг ч бий.

Сургалтад хэрэглэгдэж буй жишээ бүр нь өөрийн тодорхой үзэл бодол, мэргэжлийн түвшин бүхий хүн /багш/-ээр дамжиж суралцагчдад хүрдгийг мартах аргагүй. Уг аргыг хэрэглэх нь үлэмж цаг хугацаа шаардана. Энэ нь бусад хичээл, сэдвийн цагт эсрэгээр нөлөөлдөг. Иймээс тохиолдол нь маш сайн шилж авсан, баялаг агуулгатай, өгөөжтэй, суралцагчдын дадлага, чадварыг үнэхээр хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой.

Зөвхөн ганцхан тохиолдлыг шинжилснээр суралцагчид маш том дүгнэлтэд хүрч болох юм. Мөн нэг сэдэв дээр хэд хэдэн жишээ, эсвэл өгсөн жишээн дээрх статистик тоо баримт дээр ажиллах боломжтой

Ердийн танхимын нөхцөлд багш нь энэ аргаар хичээл явуулахад лектор биш ярилцлагыг хөтлөгчийн дүрд тоглох болно. Гэтэл багш бүр энэ үүрэгтээ бэлэн бил үү? Зарим тохиолдолд хууль, эрх зүй тэр бүр ойлгомжтой биш, тэгээд ч цоорхой ихтэй байдаг. Батлагдсан хуулийн эдгээр дутагдал нь сургалтын жишээг танхимын нөхцөлд заахад хүндрэлтэй. Ийм тохиолдолд багш, суралцагчид ямар хууль батлагдсан байх ёстой байсан, хуулийг хэрхэн өөрчлөн сайжруулж болох, ийнхүү өөрчлөн сайжруулахад оролцох арга замын талаар ярилцахад хүрдэг.

Энэ аргыг хэрэглэхдээ нэг багшид 20-оос илүүгүй оюутан оногдохоор тооцоолох хэрэгтэй бөгөөд илүү олон оюутантай багш нэгэн зэрэг ажилласан тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлдөг.

Холбогдох гарын авлага /гарын авлага, дасгал, хураамж зэрэг/, материал, хууль тогтоомжоор зайлшгүй хангагдсан байх ёстой бөгөөд энэ шаардлага хангагдаагүй тохиолдолд хичээлийг үр дүнтэй явуулах боломжгүй.

Багшийн хувьд хууль, хяналтын байгууллагад хоёроос дээш жил ажилласан, онол, практикийн өндөр мэдлэг, чадвартай байх учиртай.

Хэргийг бэлтгэх:

Тохиолдлыг сонгож авах болон боловсруулахдаа дараах шалгуурыг анхаарах хэрэгтэй.



- Хүмүүсийн амьдрал, эрх зүйн практикт олонтоо тохиолддог маргаантай асуудлыг тусгасан өөрөөр хэлбэл, бодит байдалд туйлын нийцсэн эсэх
- Суралцагчдад сонирхолтой бөгөөд зохимжтой эсэх
- Тохиолдолд авсан нөхцөл нь суралцагчдын зүгээс задлан шинжилгээ хийж, өөрсдийн эргэцүүлээ бодож боловсруулах боломж олгохуйц байгаа эсэх
- Эерэг, сөрөг баримт нотолгоог гаргаж болохуйц тэнцлийг хангаж чадсан эсэх.

Үе шат

Нэг. Шийдвэр гаргахад бэлтгэх үе:

Аливаа шийдвэрийг гаргахад хангалттай сайн мэдээлэл, баримт нотолгоо цуглуулж боловсруулах хэрэгтэй байдаг. Үүний нэг адил тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахыг тулд ч бэлтгэл ажил хэрэгтэй. Үүнд

- Тухайн тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг өгөх. Мэдээллийг өгөх олон янзын арга байдаг. Тухайлбал, уншуулах, бага хэмжээний лекц сонсох, видео бичлэг үзэх гэх мэт.
- Тохиолдлыг уншуулах. Энэ үед суралцагчдад тохиолдол /шүүхээр хянан хэлэлцэх ажиллагаа/-ын эцсийн үр дүн, шийдвэрийг мэдээлэхгүй байх хэрэгтэй. Уг асуудлын бодит төгсгөлийг нилээд хожим нь авч үзэх болно.

Цаашдаа суралцагчдын анхаарлыг бодит баримтын учрыг олоход чиглүүлэх хэрэгтэй. Юуны түрүүнд тохиолдлын үйл явдлыг сайтар ойлгуулах нь чухал. Дараахь асуултад хариулт авах замаар тэдний ойлголтыг гүнзгийрүүлж болно.

- Уг тохиолдолд /шүүхээр хянан хэлэлцэх ажиллагаа/ чухам юу болсон бэ?
- Уг маргаанд ямар хүмүүс, аль аль талууд оролцсон болох?
- Оролцсон талууд болон хүмүүсийн үйлдсэн, хийсэн зүйл нь чухам ямар учир шалтгааны улмаас үйлдэгдсэн болох?
- Ямар нөхцөл чухал болох, ямар баримт, юу дутагдаж байна вэ?

Хичээлийн энэ үед бүх суралцагчид бүгд нэг ижил баримтад тулгуурлах ёстой бөгөөд энэ үндсэн дээрээ идэвхтэй ажиллах ёстой тул багш танд сургалтын энэ шатанд анхааралтай байх нь маш чухал. Үүний хамт уншлагын дадал суугаагүй суралцагчдад ч энэ үе нь их ач холбогдол, нөлөөлөлтэй байдаг.

Багшийн зүгээс өөрөө асуулт боловсруулж суралцагчдад тавьж болно, эсвэл өөр нэг хувилбар нь тэднээр өөрсдөөр нь ажиллуулж, асуулт боловсруулж ч болох юм. Ингэхдээ хоёр хоёроор нь ажиллуулах бөгөөд нэг нь чухал баримт дээр товч дүгнэлт хийж байхад хоёрдахь нь асуултыг боловсруулан бэлтгэж байх юм.

Хоёр. Шийдвэр гаргах үе:


Суралцагчид хэрэгтэй мэдээллээ авч, тохиолдлыг хангалттай сайн судалж, ойлгосны үндсэн дээр шийдвэр гаргах үйл ажиллагаандаа орно. Тэдний шийдвэр гаргах үйл явцыг багш олон аргаар зохион байгуулж болно.

Энэ аргыг хэрэглэхийн тулд эхлээд оюутнуудад тухайн сэдвээр лекцийн хичээл орж, тодорхой ойлголт өгсөн байх нь манай өнөөгийн нөхцөлд тохиромжтой.

Яагаад модны арга

Энэ аргыг Олон улсын нийтийн эрх зүй хичээлийн хүрээнд маргаантай асуудлын учир шалтгааныг олж тогтоох, оюутнуудаар олон талт асуудлыг хэлэлцүүлэн, сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор хэрэглэнэ.

Яагаад, яагаад, яагаад буюу таван яагаадын аргачлал хэмээх аргын тусламжтайгаар талууд /багууд/ тухайн асуудлын учир шалтгааны гинжийг тодорхойлдог. Нэг гинжийн хүрээнд бүх шалтгааныг олж тогтоогоод яагаад гэсэн асуултад өөр хариулт олдохгүй болсон үед дахин огт өөр шалтгааныг авч түүнд яагаад асуулт тавин хариулах байдлаар ажиллана.



Сургалтыг идэвхижүүлэхэд чиглэсэн арга, дасгал

Сургалтын арга зүйд мэдээлэл түгээх, оролцооны зэрэг дээр дурдсан аргаас гадна тэдгээртэй хослуулан сургалтын явцад оюутнуудыг идэвхижүүлэх, өдөөх, анхаарал төвлөрүүлэх зорилгоор тусгай арга, дасгалыг хэрэглэх нь зүйтэй. Гэхдээ аль аргыг ямар сэдэв бүхий хичээл дээр, ямар аргуудтай хослуулан хэрэглэх талаар багш урьдчилан бэлтгэж, төлөвлөх хэрэгтэй. Энэ утгаар багш хичээлийн агуулга, сургалтын арга, аргачлал, дасгалыг уялдуулан төлөвлөх хүснэгтийг ашиглах боломжтой.

Сургалтыг идэвхжүүлэх арга, дасгалыг Олон улсын нийтийн эрх зүй хичээлийн агуулгатай уялдуулан багш өөрийн арга барилаар баяжуулан хэрэглэж болно. Сургалтад өргөнөөр хэрэглэдэг зарим арга, дасгалуудыг санал болгоё. Тухайлбал

Мөс хайлуулах буюу танилцах дасгал

а/. Цасан өнхрүүш

Зорилго: Оюутныг идэвхжүүлэх, алжаалыг тайлах, бие биенийхээ нэрийг мэдэх

Анхаарах зүйл: Жижиг багаар ажиллах үед тохиромжтой

Оролцогч бүр нэрээ хэлэхээс гадна нэрнийхээ үсгээр эхэлсэн ямар нэгэн тэмдэг нэр бодож олно. Тухайн хүний хувийн шинж чанарыг тодорхойлсон тэмдэг нэр байх нь чухал. Оролцогчид нэгэндээ тэмдэг нэр хэлж өгөх, давхцаж байгаа эсэхэд анхаарал хандуулах нь чухал. Дасгал дараах байдлаар явагдана. Үүнд: оролцогч эхлээд өмнөх хүнийхээ нэр, нэрний үсгээр эхэлсэн тэмдэг нэр хэлээд дараа нь өөрийн нэр, нэрний үсгээр эхэлсэн тэмдэг нэрийг хэлнэ. Дараагийн оролцогч түрүүчийн оролцогчийн хэлсэнийг бүгдийг давтаж хэлээд дараа нь өөрийн нэр, тэмдэг нэрийг мөн хэлнэ. Дасгал ийм маягаар цааш үргэлжилсээр сүүлчийн хүн бүх оролцогчийн нэр, тэмдэг нэрийг давтан хэлээд өөрийн нэр, тэмдэг нэрийг хэлнэ.



б/. Бөмбөг

Зорилго: Оюутныг идэвхжүүлэх, алжаалыг тайлах, бие биенийхээ нэрийг мэдэх,

Материал: жижиг бөмбөг

Дасгал дараах байдлаар явагдана. Бүх оролцогчид тойрог болон зогсоно. Дасгалыг эхлэхдээ өөрийн нэр болон хэн нэгний нэрийг хэлэнгээ тэр хүн рүүгээ бөмбөгөө шиднэ. Бөмбөг авсан хүн өөрийн нэрээ мөн бөмбөгөө дамжуулах хүний нэрийг хэлэнгүүтээ бөмбөгөө шидэх байдлаар тоглоом өрнөх ба оролцогчид нэгнийхээ нэрийг лавлаж асуухгүйгээр, мөн бөмбөгөө хурдан дамжуулдаг болтол үргэлжлүүлэн тоглож болно.

Солилцооны арга

Зорилго: тодорхой асуудлыг шинжлэхэд оролцогчдыг бүгдийг хамруулах, идэвхижүүлэх, бие даан асуудал дэвшүүлэн дүгнэх, шүүмжлэн хэлэлцэх

Анхаарах зүйл: оролцогчид баг дотроо шийдвэрлэх асуудлаа зураг, график, хүснэгт гэх мэт аргаар илэрхийлэн хамтран ажиллана.

Хэрэгжүүлэх дараалал

Багийн гишүүдийг дугаарлана.

Багшийн хэлсэн тоо, эсвэл оюутан өөрсдөө хэн нэгнийгээ сонгон багтаа үлдээж, үлдсэн хэсэг нь бусад багийн ажилтай танилцахаар явна. Энэ үедээ бүх багийн ажлыг тойрон явж танилцахаас гадна асуулт асууж, өөрсдийн саналыг хэлнэ.

Багтаа үлдсэн хүн өөр багаас ирж байгаа хүмүүст өөрсдийн хийсэн ажлаа танилцуулна. Бүх оролцогчид өөрсдийн багтаа эргэн ирж, багтаа үлдсэн хүндээ бусдын санал бодлыг танилцуулж ярилцана. Багууд хийсэн ажлаа дахин хянаж, нэмэх, хасах зүйлийг тодорхойлон ажлаа нэгтгэнэ.

Марафон бичлэгийн арга

Энэ арга нь бага хугацаанд олон хүний саналыг гаргах, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой оролцооны арга юм.

Анхаарах зүйл тодорхой сэдэв үзсэний дараагаар хэрэглэж оюутнуудаар дүн шинжилгээ хийлгэнэ.

Хэрэгжүүлэх дараалал

Сургалтын агуулгыг харгалзсан оновчтой асуултыг урьдчилан бэлтгэнэ.

Дээрх асуултад багийн гишүүн бүр нэг хуудас цаасан дээр өөрийн хариултаа бичээд баруун гар талын хүнрүүгээ дамжуулна. Ингээд анхны бичсэн хуудас эхний хүн дээр иртэл дамжуулна.

Хариулт нилээд зөрүүтэй байвал баг дотроо ярилцах замаар цааш үргэлжлүүлж болно. Хэрвээ багийн гишүүд бүр бүгд ижил хариулт бичсэн байвал эхний хүнийг урамшуулж болно.

Марафон бичлэгийн аргыг аль болох хурдан хугацаанд тодорхой асуудлыг дүгнэн хэлэлцэх, оюутнуудыг идэвхжүүлэх, анхаарлыг төвлөрүүлэх болон хичээлийн төгсгөлд дүгнэх байдлаар хэрэглэхэд тохиромжтой.

ЗАГВАР ХИЧЭЭЛ

Олон улсын нийтийн эрх зүй ба үндэсний эрх зүйн хоорондын харилцан хамаарлын асуудал

Зорилго: Олон улсын эрх зүйн мэдээлэл цуглуулах, боловсруулах, тайлбарлах, харьцуулах чадвараа хөгжүүлж, эрх зүйн үзэгдэл, үйл явцад олон улсын эрх зүйн онолын үүднээс ханддаг болох, тэдгээрийн харилцан хамаарал болон ялгаатай байдлын учир шалтгааныг тайлбарлах, ялгааг тодорхойлох, харилцан мэтгэлцэх, чөлөөтэй сэтгэх сэтгэлгээг хөгжүүлэх, биесээ сонсох, мэдээлэл цуглуулах, богино хугацаанд дүгнэлт хийж, өөрсдийн итгэл үнэмшилд тулгуурлан асуудлыг шийдвэрлэж сурах чадвар эзэмших, багаар хамтран ажиллах чадварыг бүрдүүлэх, ялгаатай үзэл санаанд дүн шинжилгээ хийж шүүмжлэлт сэтгэлгээ хөгжүүлэх, эрх зүйн сэтгэлгээний зөв хандлага сурах.



Нэр томъёо

- Хууль зүйн хүчин чадалын хувьд давуу хүчинтэй байх
- Нигелист монист онол
- Дуалист онол
- Монист онол
- Координацийн онол

Өгөгдөхүүн

Олон улсын эрх зүйн ойлголт, мөн чанар, түүхэн хөгжил, эх сурвалж, үндсэн зарчим, субъект зэрэг сэдэвт лекцийн дараа семинар орох бөгөөд тус лекцэд ашиглагдсан материал, жишээг өгөгдөхүүн болгон ашиглана. Мөн тухайн сэдвийг бие дааж судлах гэрийн даалгавар болгон өгнө.

1. Олон улсын эрх зүй дотоодын эрх зүйн харилцан хамаарлын талаарх үзэл баримтлалын нэг нь олон улсын эрх зүй дотоодын эрх зүйгээс давамгайл байдаг гэдэг хэлбэр юм. Үүнийг тодруулахын тулд дараах алхамыг авч үзэх шаардлагатай.

Тухайлбал: ОУЭЗ болон дотоодын эрх зүйн хоорондын ялгааг дараах байдлаар авч үзэх

- Судлах зүйл
- Судалгааны арга
- Хартлцаанд оролцогч субъект
- Хэм хэмжээ бүрдүүлэх болон хэрэгжилтийг нь хангах механизм /тухайлан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжинд нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах ямар механизм тогтоосныг судлан авч үзэх/

2. Олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн харилцан хамаарлыг дараах 2 алхамаар авч үзнэ.



Нэгдүгээрт: Олон улсын эрх зүй дотоодын эрх зүйд хэрхэн нөлөөлдөг талаар /нэгдэн орсон гэрээний хэрэгжилтийг хангахын тулд бусад улс дотоодын эрх зүйдээ ямар ямар өөрчлөлт, нэмэлтийг хийдэг талаар эх сурвалжийг ашиглан тодруулах/

Хоёрдугаарт: Дотоодын эрх зүй олон улсын эрх зүйд хэрхэн нөлөөлдөг талаар /олон улсын эрх зүйн хэм хэмжээ бүрдүүлэхэд оролцогч улс, тэдгээрийн үндэсний ашиг сонирхол, эрх зүй нь хэрхэн нөлөөлдөг талаар эх сурвалжийг ашиглан тодруулан анализ хийсэнээр асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.

3. Нэгдүгээрт: Монгол улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлээр тогтоосон журам, мөн энэ зүйлийн 3,4 хэсэг хоорондоо зөрчилтэй эсэхэд дүн шинжилгээ хийх.

Хоёрдугаарт: Монгол Улсын гэрээний тухай хуулиар ямар журам тогтоосныг авч үзэх.

Санал болгож буй арга:

- Багаар ажиллах
- Хүн бүр багш
- Хэрэг шинжлэх

Үйл ажиллагааны дараалал

1. Багуудад хуваах
2. Багийн гишүүд тус бүрийн оролцоог хангах
3. Багаар ажиллуулах
4. Багийн ажлыг нийт оюутнуудад танилцуулах
5. Хэлэлцүүлэг явуулах
6. Дүн гаргах

Оюутнуудыг анхаарлыг төвлөрүүлэх, чиглэл өгөх үүднээс багш урьд үзсэн лекцийн талаар асуулт тавьж хичээлийг эхэлнэ.

1.Хичээлийн зорилгыг танилцуулна.

2.Нийт оюутныг

- Нигелист монист онол баримтлагч тал,
- Дуалист онол баримтлагч тал,
- Монист онол баримтлагч тал,
- Координацийн онол баримтлагч тал зэргээр дөрвөн жижиг багт хувааж дараах байдлаар даалгаврыг өгнө. Үүнд:

- Багийн гишүүд тус бүр бичгийн цаасыг 4 хуваасны 1 жижиг цаас бэлдэнэ. Мөн баг бүр А-3 форматын цаас бэлдэнэ.
- Багийн гишүүд тус бүрийн оролцоог хангах үүднээс оюутан тус бүрд 5-минутын дотор бие даан ажиллах даалгавар өгч, бэлдсэн жижиг цаасан дээр онолын үүсэл, баримтлагч сэтгэгч, үндэслэл, баримтлагч улс гэсэн байдлаар өөрийн хийсэн дүгнэлтээ бичнэ.
- 15 минутын дотор багийн гишүүд тус бүр 1 минутын хугацаатай өөрсдийн дүгнэлтээ багтаа танилцуулах ба санал солилцооны явцад багийн нэгдсэн

дүгнэлтээ гаргана.

- 3 минутын дотор мэдээллээсээ хамгийн чухал гэсэн хэсэг, үзүүлэнгээ нэгтгэж бусад багийнханаа танилцуулна.
- Бусад бага өөрийн дүгнэлтээ танилцуулах явцад бага тус бүр өөрийн баримтлагч онолыг бусад гурван багийн баримтлагч онолтой харьцуулан давуу болон дутагдалтай талыг гаргана (бэлдэх хугацаа= багууд өөрийн дүгнэлтээ танилцуулах нийт хугацаа).
- Өөрийн онолоо бусад онолтой харьцуулсан дүгнэлтээ бусад багуудад танилцуулна.

3. Багийн ажлын эхний хэсгийг дүгнэж ярилцахдаа дараахь асуултыг ашиглана.

Үүнд:

- Бусад багаас авсан мэдээллээс аль хэсэг нь хамгийн сонирхолтой байсан бэ?
- Ямар шинэ мэдээлэл авсан бэ?
- Хууль зүйн хүчин чадалын хувьд холбогдох эрх зүйн систем нөгөөгөөсөө давуу хүчинтэй байх талаарх таны ойлголт өөрчлөгдсөн үү?

4. Багийн хоёр дахь хэсэгт оюутнууд тохиолдол дээр дараах үе шатын дагуу ажиллана.

- өгөгдэхүүнтэй танилцаж агуулгыг ойлгох
- баг бүр өөрийн гаргасан шийдлээ бусдад танилцуулах
- багууд хэлэлцүүлэг хийсний үндсэн дээр зөвшилцөж нэгдсэн шийдэл гаргах
- багууд амжилттай зөвшилцсөнд баяр хүргэж нийт оюутнуудыг ярилцлагад урьж, багуудад үнэлэлт өгнө.

Ярилцлагын асуулт

1. Монгол Улс ямар онол дээр тулгуурладаг вэ?
2. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 4 заалт хоорондоо хэрхэн уялдаж байна вэ?
3. Эдгээр онолоос шинэлэг нь аль нь вэ?
4. Энэ нь бусдаасаа ялгарах үндэсэл?



ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний зорилго:

Олон улсын нийтийн эрх зүй хичээлээр олж авсан мэдлэг, хийж чаддаг болсон зүйл болон оюутны үнэт зүйлийн баримжаалалд гарсан өөрчлөлтийг бодитойгоор үнэлэх нь уг хичээлийн үнэлгээний гол зорилго болно. Үнэлгээ нь бүхэлдээ зорилгодоо хүрч чадсан эсэхийг илрүүлэхэд чиглэгдэнэ.

Багш үнэлгээний дүн давтан заах шаардлагатай эсэхийг тогтоох, сурч боловсрох эрмэлзлэлийг идэвхжүүлэх, сургалтын үр дүнд хүрэх явцад оюутны мэдлэг, чадвар чухам ямар түвшинд байгааг тэдэнд мэдэгдэх зэрэг зорилгоор мөн ашиглана.

Үнэлгээний шалгуур

Мэдлэг

- Асуудалд онолын үндэстэй хариулж чадаж байгаа эсэх
- Мэдлэгээ бусдад танилцуулж, тайлбарлаж чадаж байгаа эсэх
- Тухайн судлагдахууны тодорхойлолт гаргах, үндсэн ба үндсэн бусыг ялгах, харьцуулалт хийх, хамаарлыг тогтоох арга зүйг эзэмшсэн эсэх
- Хариулт болон үзэл бодлынхоо үндэслэл, нотолгоог гаргаж байгаа байдал

Чадвар

- Тодорхой онолын мэдлэгийг ашиглан /үндэслэл, нотолгоо болгох, жишээ баримт татах, тайлбарлах/ тухайн асуудлыг тайлбарлаж, шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх
- Бодлого бодох, тохиолдол шийдвэрлэхдээ онолын мэдлэгээ ашиглаж чадаж байгаа эсэх
- Баримт бичиг боловсруулах чадварт суралцсан байдал
- Амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадварын хөгжлийн түвшин

Хандлага

- Өөрийн үзэл бодол, байр суурь, үнэлгээ дүгнэлтийг илэрхийлж чадаж байгаа эсэх, ийнхүү илэрхийлэхдээ бусдыг үзэл бодол, байр сууринд хүндэтгэлтэй хандаж түүнээс үнэ цэнтэй зүйлийг олж харж, авч чадаж байгаа эсэх
- Багийн гишүүн байх, бусдыг төлөөлөх чадварын хөгжилт
- Ялгаатай үзэл хандлага, байр сууринд хандах хандлага, түүний хүлээн зөвшөөрч байгаа байдал

Дээрхээс гадна оюутны мэдлэг, чадварын түвшнийг дараахь байдлаар ангилан, үнэлгээг ялгавартай тогтоож байх нь зүйтэй. Үүнийг хамгийн энгийн буюу доод түвшнээс хамгийн төвөгтэй буюу дээд түвшинд хүрэх дарааллаар тодорхойлж болно. Үүнд:

Мэдлэг

Хамгийн доод түвшин. Голчлон тодорхой баримт, мэдээллийг тогтоож авах, сэргээн санах чадварыг авч үзнэ.

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Ойлгоц	Өөрөө анхлан сэдэж олсон бус, өөрөөр хэлбэл, бусдын олж тогтоосон зүйлсийг оюутан наад захын түвшинд ойлгосон болохыг харуулж буй тайлбарлах, өөрийн үгээр илэрхийлэх, ургуулан бодож дүгнэлт хийх зэрэг чадвар юм.
Хэрэглээ	Оюутан мэдэж авсан ойлголт, зүй тогтол зэргийг урьд тохиолдож байгаагүй шинэ нөхцөл байдал, мөн практикийн тодорхой тохиолдолд хэрэглэх чадвар.
Дүн шинжилгээ	Мэдээллийг бүрэлдхүүн хэсэгт нь задлан хувааж, ялгаж зааглахыг хэлнэ.
Сингез	Бүрэлдхүүн хэсгийг нэгтгэн бүхэл зүйл бий болгохыг хэлнэ. Оюутан урьд нь байгаагүй бүтцийн шинэ хувилбарыг бүтээх чадвартай байх ёстой.
Үнэлэлт	Хамгийн дээд түвшин. Бусдын бүтээсэн зүйл, түүний логик бүтэц, үндэслэл нотолгоо нь бүрэн гүйцэд хийгдсэн эсэхэд үнэлгээ өгөх зэргийг ойлгоно.

Дээрх чадварын түвшинг дотор нь дараахь байдлаар ангилж болно. Үүнд

- Сургалтын зорилго Оюутны чадвар
- Заавал эзэмшсэн байвал зохих (essential) мэдлэг, ойлгоц, хэрэглээ
- Эзэмшсэн байвал сайшаалтай (desirable) анализ, синтез, үнэлгээ

Жишиг үнэлгээ, даалгавар

"Олон улсын нийтийн эрх зүй" хичээлийн шалгалтын асуулт

Хугацаа 90 мин

Нийт оноо 30

1. Дараах хүснэгтийг гүйцээж бөглөнө үү. /оноо 12/

№	Онол	Онол тус бүрийн гол агуулга /0-1.5 оноо/	Гол төлөөлөгчид /0-0.5 оноо/	Онол тус бүрийн харьцуулалт	
				Дэвшилтэт тал /0-0.5 оноо/	Шүүмжлэлт тал/0-0.5 оноо/
1	Нигилист монист онол				
2	Дуалист онол				
3	Монистонол				
4	Координацийн онол				

2. Та Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйл, 66 дугаар зүйлийн 4 дүгээр заалтын агуулгатай танилцаад дараахь асуултанд хариулна уу /оноо 10/



Аравдугаар зүйл

1. Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.
2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.
4. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.

Жаран зургадугаар зүйл

4. Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно.

Асуулт:

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэхь заалт, 66 дугаар зүйлийн 4 дэхь заалт 10 дугаар зүйлийн 2 заалттай зөрчилдөж байна уу?

3. Дараахь ухагдахууныг тодорхойлно уу.

Олон улсын нийтийн эрх зүйн зорилго	/2 оноо/
Олон улсыш эрх зүйн дагуу үүргээ шударгаар биелүүлэх (pacta sunt servanda)	/2 оноо/
Олон улсын нийтийн эрх зүйн үндсэн зарчим	/2 оноо/
Хууль зүйн хүчин чадлын хувьд давуу хүчинтэй байх	/2 оноо/

I-р ажлын шалгуур

Онол, үзэл санаа тус бүрийн гол агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлсэн эсэх	0-1.5 оноо
Онол тус бүрийн гол төлөөлөгчдөөс 3-с доошгүйг нэрлэсэн эсэх	0-0.5 оноо
Онолыг харьцуулж дэвшилтэт болон шүүмжлэлт талаас илрүүлж чадаж буй эсэх	0-1 оноо

II-р ажлын шалгуур

Хариултыг онолын үндэслэлээр нотолсон байдал	5 оноо
Хариултыг олон талаас нь үндэслэсэн байдал	2 оноо
Хариултад олон улсын нийтийн эрх зүйн үндсэн зарчимтай холбож тайлбарлаж чадсан эсэх	2 оноо
Хариултыг бичгээр илэрхийлсэн байдал /найруулга, логик/	1 оноо

III-р ажлын шалгуур

Эрх зүй гэдэг ойлголтыг олон талаас нь, мөн чанарынх нь үүднээс тайлбарлаж чадсан эсэх	5 оноо
Хариултыг олон талаас нь үндэслэсэн байдал	2 оноо

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Хариултыг эрх зүйн үнэт зүйлстэй холбож тайлбарлаж чадсан эсэх	2 оноо
Хариултыг бичгээр илэрхийлсэн байдал /найруулга, логик/	1 оноо

Илтгэлийн шалгуур

Тодорхой ойлгомжтой байдал

А. Оршил хэсэг

Илтгэлийн зорилгыг тодорхойлсон байдал

Б. Бүтэц,

Утгын хувьд нэгдмэл, логик дараалалтай байгаа эсэх

В. Хэл найруулга

Тухайн асуудлыг бичлэг, дүрслэл, найруулгын сонголт, үгийн сонголтыг оновчтой хийсэн эсэх Өгүүлбэрийн төгсгөл, түүний давталт цөөн байх

Агуулга

А. Мэдлэгт тулгуурласан байдал

Илтгэгчийн уг сэдвийн талаарх мэдлэгийн байдал

Жишээ нь оновчтой эсэх

Онолын эх сурвалжийг тайлбарласан байх

Ялгаатай онолын үзэл баримтлалыг тайлбарласан байх

Б. Гол санааг тусгасан байдал

Дэвшүүлсэн санаагаа гаргахдаа үндэслэл, нотолгоо хийсэн эсэх

В. Шүүмжлэлтэй хандсан байдал

Илтгэлээ шинжлэх ухааны бусад тайлбартай харьцуулж дүгнэлт хийсэн эсэх

"Олон улсын нийтийн эрх зүй" хичээлийн бие даалтын ажлын сэдэв

1. Олон улсын эрх зүйн үүсэл, хөгжил, орчин үеийн олон улсын харилцаанд гүйцэтгэх үүрэг
2. Олон улсын ба үндэсний эрх зүйн системийн хоорондын холбоо
3. Олон улсын эрх зүйн хэм хэмжээ
4. Олон улсын эрх зүйн систем
5. Гадаад бодлого, дипломат харилцаанд гүйцэтгэх үүрэг
6. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал
7. Олон улсын нийтийн эрх зүйн эх сурвалж /үндсэн ба туслах чанарын эх сурвалж/
8. Олон улсын эрх зүйн хэм хэмжээ
9. Олон улсын эрх зүйг төрөлжүүлэн хуульчлах, дэвшилттэйгээр хөгжүүлэх нь
10. Олон улсын нийтийн эрх зүйн зарчим
11. Улс гүрний бүрэн эрхийн зарчим
12. Улс гүрний тэгш эрхийн зарчим
13. Улсын нутаг дэвсгэр бүрэн бүтэн, улсын хил халдашгүй байх зарчим
14. Улсын дотоод хэрэгт үл оролцох зарчим
15. Олон улсын маргааныг эв зүйгээр шийдвэрлэх зарчим
16. Хүч үл хэрэглэх хүчээр үл заналхийлэх зарчим
17. Ард түмэн ба үндэстэн өөрөө засан тогтнох эрхийн зарчим



18. Олон улсын үүргээ шударгаар биелүүлэх зарчим
19. Улс Олон улсын нийтийн эрх зүйн субъект болох нь
20. Монгол Улс олон улсын нийтийн эрх зүйн субъект болох нь
21. Үндэстэн, ард түмний Олон улсын нийтийн эрх зүйн субъект болох нь
22. Олон улсын байгууллага Олон улсын нийтийн эрх зүйн субъект болох нь
23. Хувь хүн Олон улсын нийтийн эрх зүйн субъект болох нь
24. Олон улсын эрх зүй ба хүлээн зөвшөөрөх асуудал
25. Олон улсын нийтийн эрх зүйн улс гүрний эрх залгамжлалын асуудал
26. Нутаг дэвсгэр түүний бүрэлдэхүүн
27. Улс гүрний нутаг дэвсгэрийн өөрчлөлт, түүний эрх зүйн үндэслэл
28. Арктик, Антарктидын эрх зүйн байдал
29. Далайд гарцгүй улсын эрх зүйн байдал
30. Байнга төвийг сахисан улсын эрх зүйн байдал
31. Олон улсын нийтийн эрх зүй дэх хүн амын асуудал
32. 32.Харьяалал ба олон улсын эрх зүй
33. Хоёрдмол харьяалалтай болон харьяалашгүй хүмүүсийн эрх зүйн байдал
34. Цагаачдын эрх зүйн байдал
35. Дүрвэгчийн эрх зүйн байдал
36. Монгол Улс дахь гадаадын иргэний эрх зүйн байдал
37. Хүний эрхийг хангах олон улсын механизм
38. Хүний эрхийн салбар дахь бүс нутгийн хамтын ажиллагаа
39. Хүний эрхийн салбар дах олон улсын хамтын ажиллагаа
40. Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын /1966 оны/ агуулга, ач холбогдол
41. Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт Протоколын /1966 оны/ агуулга, ач холбогдол
42. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын /1966 оны/ агуулга, ач холбогдол
43. Олон улсын гэрээ ба үндэсний хууль тогтоомж
44. Олон улсын гэрээ байгуулах журам
45. Олон улсын гэрээний үйлчлэл
46. Олон улсын гэрээний эрх зүйн тухай /1969 оны/ Венийн конвенц, түүний агуулга, ач холбогдол
47. Дипломатын эрх зүй
48. Консулын эрх зүй
49. Гадаад харилцаа эрхлэх байгууллага
50. Дипломат төлөөлөгчийн газар, түүний ажилтны эрх ямба, дархан эрх, суугаа улсын өмнө хүлээх хариудлага
51. Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох журам, үүрэгт ажил дуусгавар болох нь
52. Консулыг томилох, консулын үүрэгт ажил дуусгавар болох, консулын тойрог ба консулын корпус
53. Олон улсын байгууллагын дэргэдэх төлөөлөгчийн газар, түүний үүрэг ажил
54. Консулын төлөөлөгчийн газар, түүний ажилтны эрх ямба, дархан эрх, суугаа улсын өмнө хүлээх хариуцлага
55. НҮБ ба түүний төрөлжсөн байгууллага, тэдгээрийн албан хаагчдын эрх, дарх
56. Олон улсын байгууллага, түүний эрх зүйн байдал
57. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм түүний агуулга, ач холбогдол

58. Бүс нутгийн олон улсын байгууллага
59. НҮБ дэх Монгол Улсын үйл ажиллагаа
60. НҮБ-ын Олон Улсын Шүүх
61. Нюрнбергийн олон улсын цэргийн шүүх
62. Олон улсын эрүүгийн шүүх
63. Олон улсын хэлэлцээ, түүнд тавигдах олон улсын эрх зүйн шаардлага
64. Олон улсын хурал, түүний эрхлэх байгууллага тэдүэрийн эрх хэмжээ
65. Олон улсын маргаан, түүнийг эв зүйгээр шийдвэрлэх нь
66. Олон улсын маргааныг энх тайвнаар шийдвэрлэхэд олон улсын байгууллагын үүрэг
67. Олон улсын эрх зүйн хариуцдага, түүний төрөл
68. Олон улсын хариуцлага хүлээх субъект
69. Олон улсын аюулгүй байдал, түүнийг хангах асуудал
70. Олон улсын эрх зүй дэх хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйн харилцан хамаарал
71. Бүс нутгийн аюулгүй байдлыг хангах асуудал
72. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба цөмийн зэвсэггүй бүсийн асуудал
73. Зэвсэгт мөргөлдөөний үе дэх олон улсын эрх зүйн зохицуулалт
74. Зэвсэгт мөргөлдөөний үед хүний эрхийг хамгаалах асуудал
75. Дайны ажиллагаа ба дайн бүхий байдлыг төгсгөх олон улсын эрх зүйн журам
76. Байлдааны үйл ажиллагаа явуулахад хориотой арга хэрэгсэл
77. Гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа
78. Олон улсын шинж чанартай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага
79. Терроризмтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа
80. Цэргийн олзлогдогчидын эрх зүйн байдал
81. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, түүний агуулга, ач холбогдол
82. Интерпол
83. Олон улсын эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалт
84. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны эрх зүйн зохипуулалт
85. Далайн олон улсын эрх зүй
86. Далайн эрх зүйн тухай /1982 оны/ НҮБ-ын Конвенц түүний агуулга, ач холбогдол
87. Далай дахь залгаа бүс, эдийн засгийн бүс болон эх газрын хормойн эрх зүйн дэглэм
88. Нээлттэй далайн эрх зүйн дэглэм
89. Далайн олон улсын байгууллагын эрх зүйн байдал
90. Агаарын олон улсын эрх зүй
91. Агаарын нислэгийн олон улсын байгууллагын эрх зүйн байдал
92. Улсын нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэх журам
93. Нээлттэй далай, олон улсын усан хоолой дээгүүр нислэг үйлдэх журам
94. Сансрын олон улсын эрх зүй
95. Сансрыг цэргийн зориулалтаар ашиглахыг хязгаарлах, хориглох асуудал
96. Сар ба тэдгээрийн бусад эрхсийн олон улсын эрх зүйн дэглэм
97. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах олон улсын хамтын ажиллагаа
98. Амьтны ба ургамлын аймгийг хамгаалах асуудал
99. Агаар мандал ба сансрын уудмыг хамгаалах асуудал



ХОЁР. ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

I бүлэг. ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН УДИРТГАЛ

1. Олон улсын нийтийн эрх зүйн тухай ойлголт, эх сурвалж

Олон улсын нийтийн эрх зүй нь олон улсын энхтайван, аюулгүй байдлыг хангах, бүх талын хамтын ажиллагааг тогтоох, хөгжүүлэх хүрээнд, хэрэгжилтийг түүний субъектүүд ганцаар болон хамтын журмаар хангадаг улс болон олон улсын эрх зүйн бусад субъектын бүтээсэн гэрээний болон заншлын хэм хэмжээний нийлбэр цогц юм.



Зохицуулах зүйл

Олон улсын нийтийн эрх зүйн зохицуулалтын арга тогтоосон хэм хэмжээ субъектын зан үйлд үзүүлэх нөлөөлөл юм. Зохицуулалтын арга нь субъектүүдийн хүсэл зоригын зөвшилцөх арга буюу диспозитив шинжтэй арга байдаг. Энэ арга мөн чанарын хувьд иргэний эрх зүйн зохицуулалтын аргатай төсөөтэй юм.

Олон улсын эрх зүйн зохицуулах зүйлээс түүний объект ялгаатай ойлголт юм. Олон улсын эрх зүйн зохицуулах зүйл нь нийгмийн харилцааны онцлог төрөл болох улс хоорондын харилцаа бол, түүний объект нь тухайн харилцаанд өртөх материаллаг болон материаллаг бус баялаг юм. Олон улсын эрх зүйгээр объектод нөлөө үзүүлж болохгүй боловч объектод холбоотой үүсэх харилцааг зохицуулдаг юм.


Олон улсын нийтийн эрх зүйн субъект

ОХУ-ын эрдэмтэн, судлаач Г.И.Тункин "Олон улсын эрх зүйгээр эрх эдлэж, үүрэг хүлээдэг, түүнийгээ олон улсын эрх зүйн дагуу хэрэгжүүлэх чадвартай, шаардлагатай тохиолдолд олон улсын эрх зүйн дагуу хариуцлага хүлээх чадвартай олон улсын харилцааны оролцогч байна" гэж тодорхойлжээ.


ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН УДИРТГАЛ

Олон улсын нийтийн эрх зүй өөрийн субъектын ашиг сонирхолд үйлчилж, тэдний хоорондын харилцааг зохицуулж, эрх зүйн байдал буюу эрх, үүргийг тогтоож өгдөг. /Олон улсын эрх зүйн субъект сэдвээс дэлгэрүүлж танилцах/



Олон улсын нийтийн эрх зүйн чиг үүрэг



Олон улсын эрх зүйн эх сурвалж

Олон улсын эрх зүйн субъектын хүсэл зоригын зөвшилцдийн дүнд үүссэн олон улсын эрх зүйн хэм хэмжээний хэлбэржилт буюу илрэх гадаад хэлбэр юм. НҮБ-ын Шүүхийн Дүрмийн 38-р зүйлд эх сурвалжийн нийтээр хүлээн зовшөөрсөн цэсийг тусгасан байдаг.



Олон улсын гэрээ нь тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тотоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоо юм.



- > Агуулгын хувьд хууль ёсны байх
- > Эрх зүйн дагуу байгуулагдсан байх
- > Бодитой байх буюу биелэгдэх шинжтэй байх
- > ОУНЭЗ субъектэд эрх, үүрэг олгосон байх

Олон улсын заншил түгээмэл практикаар бүтээгдсэн зан үйлийн горим юм.



- > Тодорхой харилцааг зохицуулсан байх
- > Бичгэн хэлбэржилтгүй
- > Улсын практик жишигт үүсдэг.
- > *Opinio juris sive necessatis* практикийг хууль зүйн хэм хэмжээ гэж хүлээн зөвшөөрөх

Эрх зүйн зарчим эрх зүйг хэрэглэх тайлбарлахад хэрэглэдэг эрх зүйн нийтлэг ойлголт, логик дүрэм, техникийн зарчим юм.



- > Хэрэглэгдэх давтамж
- > Эрх зүйн хөгжлийн зүй тогтолд үндэслэж үүсдэг
- > Эрх зүйн тогтолцооны зөрчлийг зохицуулдаг
- > Олон улсын эрх зүй болон үндэсний эрх

зүйд аль алинд хэрэглэгддэг

Олон улсын гэрээ болон заншил анхдагч эх сурвалжийн хувьд хууль зүйн адил хүчинтэй байдаг. **Эрх зүйн ерөнхий зарчим нь** эрх зүйн хэм хэмжээ биш, харин олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүйн аль алинд хамааралтай хууль зүйн

НҮБ-ын Шүүхийн Дүрмийн
38-р зүйлд тодорхойлсноор
туслах эх сурвалжид

Олон улсын шүүх, арбитрайн
шийдвэр

Эрдэмтдийн номлол,
сургаал



Даалгавар:

Олон улсын эрхзүйн мөн чанарыг ойлгохын тулд түүнийг үндэсний эрх зүйтэй харьцуулж авч үзэх нь дөхөм болно. Иймд энэхүү 2 эрх зүйн тогтолцоо хоорондын ялгааг тодорхойлон бичиж, тус бүрд харилцан ярилцана уу.

1.
2.
3.
4.
5.
6.
7.



Хяналтын асуулт

1. Олон улсын эрх зүйн хэм хэмжээг тодорхойлно уу.
2. Олон улсын эрх зүйн онцлогыг илэрхийлсэн хамгийн гол шинж юу вэ? Тайлбар хийнэ үү?
3. Туслах эх сурвалжийн нийтлэг чиг үүрэг юу вэ?
4. Эрдэмтэдийн номлол, сургаалыг туслах эх сурвалж гэж тусгасаны ач холбогдол юунд орших вэ?



Эх сурвалж

1. М. Дүгэрсүрэн. 0. Хосбаяр. Олон улсын эрх зүй 1-25 х. УБ.1999 он.
2. НҮБ-ын Дүрэм,



логикийн дүрэм хамаардаг.


2. Олон улсын нийтийн эрх зүйн түүхэн хөгжил

Олон улсын нийтийн эрх зүйн үүсэл, түүхийн үечлэл

Аливаа улсын үндэсний нийгмийн байгуулал нь олон улсын харилцаанаас өмнө үүссэн. Үндэсний ашиг сонирхлоо хамгаалахад хууль зүйн хүчин чадал бүхий хэм хэмжээнд захирагдах ёстойгоо ухамсарлаж эхэлсэнээр олон улсын эрх зүй, улсуудын практикт хүлээн зөвшөөрөгдөж эхэлсэн.


ОУНЭЗ-н үүслийн талаар судлаачдын дунд 3 үзэл баримтлал байна.

- ▲ Овог хоорондын харилцааны явцад / Барууны судлаачдын үзэл/
- ▲ Төр, улстай зэрэг,
- ▲ Дундад зууны төгсгөлөөр буюу 1648 оны 10 сарын 24-ны өдөр Европт Вестфалын энхийн гэрээ байгуулагдсанаар үүссэн гэж үзэж байна.




Эртний үеийн Олон Улсын эрх зүй

МЭӨ 4000 жилээс МЭ 476 дугаар он хүртэл аажим бүрэлдсэн тэр үеийн улсуудын хоорондын харилцааг зохицуулж байсан хууль зүйн зарчим, хэм хэмжээний нийлбэр цогц эртний үеийн ОУЭЗ-д хамаардаг. Тэр үед олон улсын харилцаа өнөөгийн утгаараа байсангүй. Дэлхийн газрын зурагт бүхэл бүтэн эх газар болох Америк, Австрали, Африк тивийн ихэнхи хэсэг мэдэгдээгүй, олон улсын амьдралын төв Ойрхи Дорнод, Энэтхэг, Хятад, Грек, Ром улсууд байсан. Судлаачид Ойрхи Дорнод буюу Тигр, Евфрат, Нил мөрний эрэг хавиар оршиж байсан улсуудын хооронд ОУЭЗ бий болсон хэмээн үздэг.



Дундад зууны олон улсын эрх зүй


Ромын эзэнт гүрэн МЭ 476 онд бутран унаснаар феодалийн нийгмийн үндэс тавигдаж, олон улсын эрх зүйн феодалийн хэв загвар бүрэлдсэн. V-XVII зуун хүртэл аажимдаа төлөвшсөн улсуудын харилцааг зохицуулах зарчим, хэм хэмжээ нь дундад зууны үеийн олон улсын эрх зүй юм. Эртний үеийн адилаар бүх улсуудад нийтлэг ОУЭЗ байхгүй. Олон улсын амьдралын төвөөр Баруун Европ, Византи, Киевский Русь, Арабын Хойг, Энэтхэг, Хятад зэрэг улс байсан. Дундад зууны үед ОУЭЗ шинжлэх ухаан үүссэн гэж үздэг бөгөөд Голландын хуульч Гуго Гроци үндэслэгч хэмээн судлаачид үздэг. Тэрээр 1625 онд "Дайн ба энхтайвны тухай" бүтээлдээ "ард түмэн, удирдагчдын хоорондын харилцааг зохицуулсан эрх зүй" байх тухай анх үндэслэж гаргасан.



Сонгодог Олон улсын эрх зүй

Англи улсад өрнөсөн хөрөнгөтний хувьсгалийн үр дүнд 1642-1649 онд дэгдсэн иргэний дайн XVIII зуунд Баруун Европ, Хойд Америкт хөрөнгөтний хувьсгал гарахад нөлөөлсөн. Дундад зууны үед ардчилалын зарчим өргөн дэлгэрээгүй байсан бол 1789 оны Хүний ба Иргэний эрхийн тунхаглал, 1787 оны АНУ-ын Үндсэн хууль, 1791, 1793 оны Францын Үндсэн хуулиудад ард түмний бүрэн эрх, улс гүрний тэгш эрх, улсын дотоод хэрэгт үл оролцох, улсын нутаг дэвсгэр халдашгүй байх зэрэг зарчмуудыг тусгаж баталгаажуулсан. 1648 оны 10-р сарын 24-нд Вестфалийн найрамдлийн гэрээгээр улсуудын тэгш байдал, засаглалыг шашнаас тусгаарлах, дайныг хязгаарлах, түрэмгийлэлийн эсрэг хамтаар тэмцэх зэрэг зарчмуудыг тусгаж өгснөөр ОУЭЗ-н хөгжилд шинэ хуудас нээсэн байна.

XIX зууны төгсгөл руу Олон улсын эрх зүй олон улсын харилцааны зохицуулагч, улсуудад ОУЭЗ ухамсарын үндэс тавигдсан гэж үздэг байна.






Орчин үеийн олон улсын эрх зүй

ОУНЭЗ дараагийн үечлэлд шилжих үйл явцад Дэлхийн I дайн, 1917 оны Оросын хувьсгал, ЗХУ дайныг хүн торолхтний эсрэг гэмт хэрэг хэмээн зарласан зэрэг нөлөөлсөн. Дэлхийн I дайны дараа Версалийн найрамдлын гэрээ байгуулж, 1919 онд Энхтайвныг сахин хамгаалах Үндэстний Зөвлөл байгуулагдсан. Үндэстний Зөвлөлийн Дүрэмд "Зөвлөлийн бүх гишүүдийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн байдалд хүндэтгэх, хамгаалах" үүрэг хүлээлгэж, үүргээ зөрчсөн улсыг Зөвлөлийн нийт гишүүдийн эсрэг дайн өдоосон гэж үзнэ" хэмээн тунхагласан. Үндэстний Зөвлөлийн Дүрэм нь дайныг шууд хориглоогүй, хязгаарласан байв.

1928 онд 15 улс Парисын гэрээгээр хоорондын харилцаа, үл ойлголцох явдлаа дайны аргаар зохицуулахаас татгалзсан нь дайныг хориглосон анхны олон талт гэрээ юм.

1945 онд НҮБ үүссэнээр ОУЭЗ хөгжилд дахин шинэ хуудас нээгдсэн юм. Дайнаас хойш олон улсын эрх зүй өндөр хурдтай хөгжиж байна.



Орчин үеийн олон улсын эрх зүйн онцлог Дэлхийн II дайнаас хойш хурдацтай хөгжсөн явдал юм. Үүнд: Олон улсын агаарын эрх зүй /1944 оны Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц/, Гадаад харилцааны эрх зүй /1961 оны Дипломат харилцааны тухай Венийн конвенц /, Олон улсын гэрээний эрх зүй /1969 оны Олон улсын гэрээний эрх зүйн Венийн конвенц/, Олон улсын далайн эрх зүй /1982 оны Далайн эрх зүйн тухай конвенц /, Олон улсын сансрын эрх зүй /1967 оны Сансрын гэрээ/, зэрэг салбаруудад кодификаци хийгдсэн юм.

1963 оны Хүрээлэн орчинд цөмийн зэвсэг туршихыг хориглох тухай гэрээ, 1968 оны цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ, 1972 оны Бактериологийн зэвсгийг хориглох конвенц, зэрэг байгуулагдснаар богино хугацаанд олон улсын аюулгүй байдлын эрх зүйн салбар бүрэлдсэн юм.

Орчин үеийн олон улсын эрх зүйн шинэлэг тал нь хүний эрхийн хамгаалалт үндэсний хууль тогтоомжийн хүрээнээс хальж олон улсын хэмжээнд хамгаалагдах болсонд оршино.

Хүч үл хэрэглэх, хүчээр үл заналхийлэх, ард түмэн өөртөө засан тогтнох, улсын хил халдашгүй байх, нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх, хүний эрхийг хүндэтгэх, хамтын ажиллагааны зэрэг Олон улсын эрх зүйн үндсэн зарчмууд төлөвшсөн юм.



Хяналтын асуулт

1. 1648 оны Вестфалийн энхийн гэрээ олон улсын нийтийн эрх зүйн хөгжилд ямар ач холбогдолтой байсан бэ?
2. ОУНЭЗ-н сонгодог үеийн онцлогийг тодорхойлно уу?
3. Орчин үеийн ОУНЭЗ-н хурдацтай хөгжилд нөлөөлсөн хүчин зүйлсийг дурьдана уу?
4. ОУНЭЗ үүсэх ямар шалтгаан нөхцөл байсан бэ?
5. ОУНЭЗ үүссэн хугацааг тодорхойлно уу?



Даалгавар:

1. Та ОУНЭЗ-н түүхэн хөгжлийн аль нэг үечлэлийг сонгон авч тухайн нөхцөл байдал, үеийн онцлог шинжийг бүрэн илэрхийлэхүйц сүлдийг зурна уу?

Тавигдах шаардлага:

- > Сулд нэртэй байна.
- > А-4 цаасан дээр
- > Өнгийн будгаар ялгана.
- > Сүлдний тайлбарийг бичгээр хийнэ.



Эх сурвалж

М.Дүгэрсүрэн, (ХХосбаяр, Олон улсын эрх зүй 9-14 х. УБ.1999 он. Ю.М.Колосов, Э.С.Кривикова, Международное право Москва 2004 17-39 стр.



II бүлэг. ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДСЭН АНГИ

3. Олон улсын нийтийн эрх зүйн үндсэн зарчим



Нэр томъёо

Jus cogens - ОУГЭЗ-н тухай 1969 оны Венийн конвенцийн 53 дугаар зүйлд олон улсын нийтлэг эрх зүйн заавал мөрдөх хэм хэмжээ нь түүнээс тагталзаж үл болох бөгөөд адил шинж чанартай олон улсын нийтлэг эрх зүйн дараагийн хэм хэмжээгээр зөвхөн өөрчилж болох хэм хэмжээ гэж олон улсын хамтын нийгэмлэгийн улс нийтээр хүлээн авч, зөвшөөрч байгаа хэм хэмжээ.

Pacta sunt servanda- гэрээ заавал биелэгдэх ёстой хэмээх олон улсын эрх зүйн суурь хэм хэмжээ.

Олон улсыг эрх зүйн үндсэн зарчмын тухай ойлголт,

Хууль зүйн категорийн хувьд үндсэн зарчим ХJM хэмжээ МӨН боловч хэм хэмжээний системд онцгой байр суурийг эзэлдэг. Үүнийгээ илэрхийлсэн хэд хэдэн онцлог шинжтэй.

Императив хэм хэмжээ /
jus cogens/



ОУНЭЗ бусад салбарыг бодвол үндсэн зарчмыг бүтээхэд оролцох, хүлээн зөвшөөрсөн эсэхээс үл хамааралтай бүх субъектэд заавал биелэгдэх, дагаж мөрдөх шинжтэй. Субъектүүд хоорондоо тухайн хэм хэмжээгээр хүлээсэн үүргээ харилцан тохиролцож өөрчилж болдоггүй.

Адилхан хүчинтэй



Үндсэн зарчмууд хууль зүйн хувьд харилцан бие биедээ захирагдаггүй. Гэвч комилекс шинжтэй буюу харилцан бие биенээ агуулгын хувьд нөхцөлдүүлж байдаг.

Суурь харилцааг
зохицуулдаг



Олон улсын аюулгүй байдал, энх тайван, хүний эрх, эрх чөлөө гэх мэт өнөөгийн улс хоорондын амин чухал харилцааг зохицуулдаг.

Бүтээх, өөрчлөх



Үндсэн зарчмыг өөрчлөх, эсвэл хүчингүй болгох тохиолдолд зөвхөн шинэ зарчмаар солигддог ба хамгийн түгээмэл олон улсын баримт бичгүүдэд хэлбэрждэг.

Хэрэгжилтийг хангах
механизм




ҮЗ хэрэгжилтийг хангах, механизм өөр байдаг. Тухайлбал: зөрчсөн улсын Хэрэгжилтийг хангах тусгаар тогтнол, бүрэн хязгаарлах механизм х ү р т э л арга хэмжээ авах, мөн тухайн улсын удирдагч, эрх бүхий хүмүүст хариуцлага тооцох гэх мэт.

Үндсэн зарчмын чиг үүрэг


- > Олон улсын харилцааны системийн тогтвортой байдлыг хангах,
- > Нийтээр дагаж мөрдөх журмын хувьд ОУЭЗ системийн хөгжил, төлөвшилд дэмжлэг үзүүлэх,
- > ОУНЭЗ-д субъектын хууль ёсны ашиг сонирхол, үндсэн эрх, үүргийг тогтоох,
- > ОУНЭЗ-н зохицуулалт, түүний хууль ёсны байдлын үндсэн шатуур болох,
- > ОУЭЗ субъектийн эрх зүйн ухамсарын хөгжил, төлөвшилд нөлөөлөх

Олон улсын эрх зүйн зарчмын ангилал





ОУНЭЗ үндсэн зарчмын эх сурвалж



1945 оны 06-р сарын 24-нд батлагдсан НҮБ-ын Дүрмийн 2-р зүйлд тусгагдсан. Дүрэм батлах үед эдгээр зарчмуудыг ОУНЭЗ үндсэн зарчим гэж томъёолоогүй, ийм үзэл санаа байгаагүйг зарим судлаачид бичсэн байдаг.

Харин 25 жилийн дараа буюу 1970 оны 10-р сарын 24-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблей "НҮБ-ын Дүрмийн дагуу улс хоорондын хамтын ажиллагаа, найрсаг харилцааны ОУЭЗ -н зарчмын тухай Тунхаглал баримт бичиг баталсан. НҮБ-ын

Дүрмийн зарчмыг тодотгон, дэлгэрүүлж 3-р бүлэгт ОУЭЗ үндсэн зарчмууд мөн гэж тунхагласан.

1975 оны Европын Аюулгүй байдал Хамтын ажиллагааны Зөвлөгөөнөөс баталсан Төгсгөлийн актад оролцогч улсууд хоорондоо баримтлах 10 зарчмыг тодорхойлсон.

Хэдийгээр бүс нутгийн шинжтэй баримт бичиг боловч нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хүний эрх, эрх чөлөө хүндэтгэх зарчим агуулгаараа НҮБ-ын зорилгод тунхаглагдсан байсан юм.



Даалгавар:

1. А, Б улсууд НҮБ-ын гишүүн бус улсууд ажээ. А улс Б улсын нутаг дэвсгэрт цэргийн хүчээр халдсан байна. Дээрхи улсууд НҮБ-ын Дүрэмийг сахин биелүүлэх үүргийг хүлээх үү.
2. А улс НҮБ-д нөлөө бүхий гишүүн бөгөөд бодлогын дийлэнхийг тодорхойлдог. Б улс дөнгөж тусгаар тогтносон шинэ улс байсан ба түүнд А улс их хэмжээний туслалцаа үзүүлдэг байв. А улс цөмийн зэвсэг туршиж, үйлдвэрлэж эхэлсэн тул НҮБ А улсын эсрэг албадлагын арга хэмжээ авсан. А улс түүний иргэд тун хүнд байдалд орсон тул Б улс түүнд тусламж үзүүлжээ. Энэ тохиолдолд олон улсын эрх зүйн ямар зарчим зөрчигдсөн бэ?
3. Б улс зөвхөн А улстай хил залгадаг, Өөрөөр хэлбэл, А улсын нутаг дэвсгэр дээр Б улс оршдог байжээ. А улс өөрийн бүх хилээ хаах шийдвэр гаргажээ. А улс ийм эрхтэй юу?
4. НҮБ-ын гишүүн А улс лалын шашинтай улс байжээ. Тус улс бусад шашныг илт буруушаадаг. Тус улсын гадаад хэргийн яамнаас гаргасан гадаад бодлогын үзэл баримтлал гэсэн баримт бичигт "лалын шашнаас өөр шашинтай улстай олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхгүй" гэжээ.
5. А улсын үйлдэлд олон улсын эрх зүйн үүднээс дүгнэлт хийнэ үү.



Сорил

1. Олон улсын гэрээг заавал биелүүлэх зарчим нь аль вэ?
 - a. *pacta sunt servanda*
 - b. *stare decisis*
 - c. *ordre public*
 - d. аль нь ч биш
2. ОУЭЗ-н үндсэн 10 зарчим ямар шинжтэй вэ?
 - a. уян
 - b. эдийн бус
 - c. түр зуурын
 - d. императив



Хяналтын асуулт

1. Олон улс эрх зүйн үндсэн зарчим бусад олон улсын эрх зүйн хэм хэмжээнээс ялгааг гаргаж, дүгнэлт хийнэ үү?
2. Улс гүрний тэгш эрхийн тухай зарчмын хууль зүйн агуулгыг тодорхойлно уу?
3. Улсын хүч хэрэглэсэн үйлдлийг хууль ёсны байх тохиолдлыг нэрлэнэ үү?
4. Улсын хил халдашгүй дархан байх зарчмын агуулгыг тодорхойлно уу?
5. Хүний эрхийг бүх нийтээр хүндэтгэх зарчмын агуулгыг тодорхойлно уу?
6. Хамтын ажиллагааны зарчмын нийгэм, эдийн засгийн агуулгыг тодорхойлно уу?
7. Олон улсын үүргээ шударгаар биелүүлэх зарчмын агуулгыг тодорхойлно уу?



Эх сурвалж

1. 0. Хосбаяр. М. Дүгэрсүрэн. Олон улсын эрх зүй 26-44 х. УБ.1999 он
2. НҮБ-ын Дүрэм, 1, 2- зүйл, VI, VII бүлэг
3. 1970 оны ОУЭЗ-н зарчмын тунхаглал
4. 975 оны Хельсинкийн Төгсгөлийн Акт
5. Монгол улсын Үндсэн хуулийн 4,10-р зүйл, II бүлэг.
6. Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал II , IV бүлэг

4. Олон улсын нийтийн эрх зүйн субъект




Нэр томъёо


Конфедераци-улсуудын холбоо буюу тодорхой асуудлаар хамтарсан бодлого явуулахаар улсууд гэрээ байгуулж холбоо тогтоох, **Уни-бие** даасан улсуудын нэгдэл

Олон улсын нийтийн эрх зүйн субъектын ойлголт, ангилал

Олон улсын нийтийн эрх зүйд субъект гол байр суурийг эзэлдэг. Олон улсын эрх зүйн мөн чанар, агуулга субъектын мөн чанар, агуулгаас улбаалж байдаг. Олон улсын нийтийн эрх зүй өөрийн субъектын ашиг сонирхолд үйлчилж, тэдний хоорондын харилцааг зохицуулж, эрх үүргийг тогтоодог.



Олон улсын эрх зүйн субъект дээрхи чадварыг заавал эзэмших боловч хэмжээний хувьд харилцан адилгүй байж болдог байна.




ОУНЭЗ-н субъектын эзэмших чадварын хэмжээнээс шалтгаалж түүнийг анхдагч ба үүсмэл субъект гэж ангилдаг. Анхдагч субъект нь бүрэн эрхийн үндсэн дээрхи чадварыг бүрэн хэмжээнд эзэмшинэ. Харин үүсмэл субъектын эзэмших чадвар нь түүнийг үүсгэн байгуулагчийн хүсэл зоригын зөвшилцөл буюу гэрээний үндсэн дээр үүсдэг онцлогтой



Улс анхдагч субъект болох нь

ОУНЭЗ-д улс анхдагч субъект бөгөөд олон улсын гэрээ байгуулах замаар бусад субъектыг үүсгэдэг. Улс ОУНЭЗ-г бүтээж, түүний биелэлтийг хангах гол баталгаа болдог. 1933 оны Монтевидеод хуралдсан Америкийн улсуудын бага хурлаас баталсан **Улсын эрх, үүргийн тухай** конвенцийн 1-р зүйлд улсад байх үндсэн шинжийг тусгасан ба өнөөдөр энэхүү тодорхойлолт олон улсын нийтийн эрх зүй болон төр, эрх зүйн онолд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн юм.

Үүнд:



Төрийн бүрэн эрхт байдал нь улсын онцлог, ОУНЭЗ-н үндсэн субъект болохыг тодорхойлох үндсэн шинж юм. Төрийн бүрэн эрхт байдал гэдэг нь тухайн улс нутаг дэвсгэрийн хүрээнд бусдаас хараат бусаар туйлийн шинжтэй онцгой эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм.



Нэгдмэл улс олон улсын харилцаанд нэг субъект болж оролцдог, түүний засаг захиргааны нэгжийн олон улсын субъектын эрх зүйн байдлын тухай асуудал үүсдэггүй.

Нийлмэл улсын хамгийн түгээмэл хэлбэр холбооны улс ба түүний Үндсэн хууль эсвэл Холбооны эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй бусад улстай харилцаанд оролцож болдог. Нийлмэл улсад улсуудын холбоо, уни багтана.

Үндэстэн, ард түмний эрх зүйн байдал

Үндэстэн, ард түмэн өөртөө засан тогтнох эрхийн зарчмаас үүсэлтэй субъект хэмээн хүлээн зөвшөөрдөг. Зовхон энэхүү зарчмыг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэлд боссон, тэмцэл нь ард түмнээрээ нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын харилцаанд төлөөлөх чадвар бүхий засаг захиргааны байгууллагатай үндэстэн ард түмнийг субъект гэдэг.

Олон улсын байгууллагын эрх зүйн байдал

Улс гүрэн ОУЭЗ-н анхдагч субъектын хувьд нийтлэг ашиг сонирхолын хүрээнд харилцан тохиролцож бусад субъектыг үүсгэдэг. ОУБ ОУЭЗ-н үүсмэл субъект,

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ


ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДСЭН АНГИ

улсуудын байнгын хамтын ажиллагааны хамгийн түгээмэл хэлбэр юм ОУБ субъектын хувьд дараах шинжүүдийг агуулсан байх ёстой.



- ОУБ, түүний үйл ажиллагаа ОУЭЗ нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцсэн байх, Гишүүд улс гүрэн байх буюу улсуудын нэгдэл байх, Үүсгэн байгуулсан баримт бичигтэй байх,
- Үндсэн зорилго, үйл ажиллагааны зарчимтай байх,
- Үйл ажиллагаа нь байнгын шинжтэй байх

ОУБ-ын эрх зүйн байдал



ОУЭЗ-н тусгай субъект

Тусгай субъектэд улс хэлбэрийн тогтоцийг хамааруулж ойлгодог. ОУЭЗ-н дагуу эрх эдлэж, үүрэг хүлээдэг тул ОУЭЗ-н субъект болдог. Ийм тогтоци нь нутаг дэвсгэр, бүрэн эрхт байдал, иргэний харьяалал, хууль ТОГТООХ байгууллагатай байж болдог. Өнөөдөр ийм тусгай субъектээр Ватикан, түүхийн явцад чөлөөт хотууд байсан байна.

1929 онд Италийн Засгийн газрын тэргүүн Муссолин Ромьш Папын төлөөлөгч Гаспарин нарын байгуулсан Латероны гэрээний үндсэн дээр Ватикан улс үүссэн. Түүнийг үүсгэсэн нь Итали улс өөрийн дотоод болон гадаад бодлогод католик шашин, сүм хийдийн дэмжлэгийг авах зорилготой байсан. Ватикан дэлхийн олон улстай албан ёсны харилцаатай, олон улсын байгууллагад гишүүнчилэлтэй юм.



Хяналтын асуулт

1. Хувь хүн олон улсын нийтийн эрх зүйн субъект болох уу? Эл асуудлаар өөрийн үзэл бодлоо илэрхийлнэ үү?
2. Олон улсын харилцааны субъект олон улсын эрх зүйн субъект хоорондын ялгааг тодорхойлно уу?
3. Олон улсын байгууллага ямар онцлог шинжтэй субъект вэ?
4. Үндэстэн, ард түмэн олон улсын эрх зүйн субъект гэж хүлээн зөвшөөрөгдөх эрх зүйн үндэслэл юу вэ? Ямар шалгуурыг хангасан байх ёстой вэ?



Бодлого

1. Төрийн тусгаар тогтнолын төлөө Манжийн эсрэг тэмцэлд боссон ард түмнийг удирдан зохион байгуулах зорилго бүхий Халхын Хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн шийтгах газар буюу түр Засгийн газрыг 1911оны 11 сард багуулж байжээ.

а. Орчин үеийн ОУНЭЗ-н үүднээс субъект гэж авч үзэж болох уу? Хэрэв субъект бол ялгар эрх эдлэж, үүрэг хүлээх вэ?



Эх сурвалж

1. О. Хосбаяр. М. Дүгэрсүрэн. Олон улсын эрхзүй 48-58 х. УБ. 1999 он
2. Монгол улсын Үндсэн хуулийн 4,10-р зүйл, II бүлэг.

5. Олон улсын эрх зүй дэхь хүлээн зөвшөөрөх



Нэр томъёо

de jure- албан ёсоор бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрөх

de facto-албан ёсны боловч бүрэн биш хүлээн зөвшөөрөх

ad hoc- зөвхөн нэг удаа хүлээн зөвшөөрөх

Конститутив- үүсгэх онол

Декларатив -тунхаглах онол

Тобарын онол- Эквадорын Гадаад хэргийн сайд Карлос Тобарын боловсруулсан Засгийн газар хүлээн зөвшөөрөх онол.


Естрадын онол -1930 онд Мексикийн Гадаад хэргийн сайд Эстрад засгийн газрыг хүлээн зөвшөөрөх тухай онол.

Хүлээн зөвшөөрөх ойлголт, түүний эрх зүйн үр дагавар

Олон улсын харилцаанд шинэ улс үүсэхтэй холбоотой ойлголт юм. Улс өөрөө анхдагч субъектын хувьд харьцангуй тогтвортой нэгдэл боловч, түүний хувь заяа өөрчлөгдөх тохиолдол гардаг. Тухайлбал: ХХ зууны дунд үед колонны систем задран унаж олон шинэ улсууд үүссэн, мөн хуучны ЗХУ, Югослав улс тусгаар улс болж задарсан гэх, мэт. Ингэж үүссэн шинэ улсын эрх зүйн статусыг тодорхойлох, түүнд олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүд өөрсдийн байр суурийг илэрхийлдэг.

Хүлээн зөвшөөрөх нь улс төрийн болон эрх зүйн агуулгатай. Хүлээн зөвшөөрөхийн улс төрийн ач холбогдол нь хүлээн зөвшөөрөгдөж буй шинэ улстай тухайн улс дипломат харилцаа тогтоож, бүх салбарт хамтран ажиллах хүсэлтэй буйгаа илэрхийлсэн түүний эрх бүхий дээд байгууллагын тунхаглал юм.


Хүлээн зөвшөөрөхийн эрх зүйн агуулга шинэ үүссэн улсын олон улсын харилцааны эрх зүйн чадварыг хүлээн зөвшөөрч буй явдал юм.





Олон улсын практикт дипломат болон консулын харилцаа тогтоох хүсэлтээ илэрхийлсэн тунхаглал эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай албан ёсны нот бичиг гаргах зэргээр тодорхой илэрхийлэгдэх, түүнчлэн тусгаар тогтносонд баяр хүргэх, элчин сайд, консул зэргийг хүлээн авах гэх зэргээр хэрэгждэг. DE JURE - албан ёсоор бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрөх буюу албан ёсны дипломат харилцаа тогтдог үр дагавартай. DE FACTO- албан ёсны гэхдээ бүрэн биш буюу DE JURE хүлээн зөвшөөрөгдөхөөс ялгаа нь эрх зүйн үр дагаварын хувьд бөгөөд зөвхөн консулын болон худалдааны харилцаа тогтдог. AD HOC- албан бус, нэг удаа хүлээн зөвшөөрөх буюу улсууд^бие биенээ хүлээн зөвшөөрөх сонирхолгүй боловч ямар нэг асуудлыг шийдвэрлэхийн тулд албан ёсоор холбоо тогтоохыг ойлгоно.

Улс хүлээн зөвшөөрөх



Хүлээн зөвшөөрөх бусад хэлбэр

Тусгаар тогтнолын төлөө буюу гадаадын түрэмгийлэлийн эсрэг ард түмэн өөрсдийн зохион байгуулалтын хэлбэрт ордог. Ийм байгууллагыг хүлээн зөвшөөрснөөр доорхи үр дагавар бий болно. Үүнд:

- > Бусад улс, олон улсын байгууллагатай харилцаанд орно,
- > Олон улсын гэрээ байгуулах ба нэгдэн орох,
- > Олон улсын башууллагын үйл ажиллагаанд оролцох,

Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг хүлээн зөвшөөрөх явдал бол шинэ улс үүсэх шилжилтийн алхам юм.

Иргэний болон үндэсний эрх чөлөөний дайны үед босогч болон дайтагч талыг хүлээн зөвшөөрөх асуудал гардаг. Дайтагч болон босогч талыг хүлээн зөвшөөрснөөр гарах үндсэн үр дагавар нь:

- > Дайны үеийн эрх зүйн хэм хэмжээ үйлчлэнэ.
- > Төрийн эсрэг гэмт хэрэгтэнд тооцогдохгүй.
- > ОУЭЗ бусад субъектүүдтэй харилцаа тогтоож, тусламж дэмжлэг авах эрхтэй болно.



Бодлого

1. 1921 оны 11-р сарын 5-нд Монгол Оросын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай РСФСР-ийн Засгийн газар ба Монголын Ардын Засгийн газар хооронд гэрээ байгуулжээ.

а. Монгол уясыг хэрхэн хүлээн зөвшөөрсөнд дүгнэлт хийнэ үү?

2. 1945 оны 10-р сарын 20-нд Монгол улсад ард нийтийн санал асуулга явуулсан бөгөөд Дундад иргэн улс 1946 оны 1-р сарын 05-нд гаргасан мэдээндээ " ард нийтийн саналын дүн нь гадаад Монголын ард түмэн тусгаар тогтносон байдлын төлөө саналаа өгсөнийг батлав" гэжээ.

а. Монгол улсыг хэрхэн хүлээн зөвшөөрсөнд дүгнэлт хийнэ үү?

3. 2004 оны сонгуулийн ур дүнд байгуулагдсан Ц.Элбэгдоржийн тэргүүлсэн зөвлөлийн Засгийн газрийг 2006 оны 01-р сард УИХ-аар хэлэлцэж бүрэн бүрэлдэхүүнээр огцруулж, М.Энхболдын тэргүүлсэн Засгийн газар байгуулагдсан. Үүний дараа Монгол улсын өдөр тутмын нэг хэвлэлд ОХУ-ын улсын Засгийн газрийн тэргүүний баяр хүргэсэн цахилгаан нийтлэгдсэн байв.

а. Засгийн газрийг хэрхэн ямар тохиолдолд хүлээн зөвшөөрөх вэ?

4. 1990 оны 8-р сарын 2-нд Иракийн ерөнхийлөгч Саддам Хуссейн Кувейтыг эзлэн авах тушаал гаргаж мөн сарын 8-нд Ирак улс Кувейт улсыг албан ёсоор өөрийн 19-дэхь муж хэмээн зарласан. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тоот тогтоолыг хэрэгжүүлж Ирак улс 1994 онд Кувейт улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүлээн зөвшөөрсөн байна.

а. Хүлээн зөвшөөрөх үүргийн шинжийг агуулж болохуу?



Хяналтын асуулт

1. De jure хүлээн зөвшөөрөх, De facto хүлээн зөвшөөрөхийн ялгаа юунд орших вэ?
2. Хүлээн зөвшөөрөхийн үүсгэх болон тунхаглалын ач холбогдлыг та юу гэж ойлгож байна вэ?
3. Олон улсын эрх зүйн хүлээн зөвшөөрөх ямар төрөл, хэлбэр байдаг вэ?
4. Шинэ улсыг хүлээн зөвшөөрөхдөө түүнд тодохой нөхцөл, шаардлага тавьж болох уу?
5. Ямар тохиолдолд Засгийн газар хүлээн зөвшөөрөгддөг вэ?



Эх сурвалж

1. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. 58-64 х. УБ., 1999 он.
2. Б.Нармандах, Н.Гантулга. Олон улсын нийтийн эрх зүй. УБ., 2003 он.

6. ОУНЭЗ-н эрх зүйн зөвлөлийн асуудал

Эрх зүйн өвлөлийн ойлголт, эх сурвалж

Улсын нутаг дэвсгэр өөрчлөгдснөөр тухайн өөрчлөгдсөн нутаг дэвсгэрийн төлөө хүлээх хариуцдага нөгөө субъектэд шилжихтэй холбоотой харшшааг эрх зүйн өвлөл гэнэ. Эрх зүйн өвлөл нь өвлүүлэгч /эрх зүйн өвлөлд өөр улсаар солигдсон/, өвлөгч /шинэ үүссэн улс / улсуудын хооронд үүсдэг. Эрх зүйн өвлөлийн харилцааг зохицуулсан олон улсын баримт бичиг НҮБ-ын хүрээнд боловсруулсан Гэрээний эрх зүйн өвлөлийн тухай 1978 оны Венийн конвенц, Төрийн өмч, архив, өр төлбөрийн эрх зүйн өвлөлийн тухай 1983 оны Венийн конвенци юм. Конвенциуд хууль зүйн хувьд хүчин төгөлдг^ болоогүй боловч улсуудын практикт өргөн хэрэглэгддэг эх сурвалж юм.

Эрх зүйн өвлөлийн тухай дээрхи 2 конвенц диспозитив зохицуулалттай, шинэ субъект үүсэх факт өөрөө онцлог байж болох учир ямар ч тохиолдолд холбогдох талууд гэрээгээр тохиролцох боломжийг субъектүүдэд үлдээсэн байна.



Улсын өр төлбөрийн эрх зүйн өвлөл

ОУЭЗ-н дагуу бий болсон бусад улс, ОУБ, болон олон улсын эрх зүйн бусад субъектэд гүйцэтгэх өвлүүлэгч улсын аливаа санхүүгийн үүргийг ойлгоно. Улсын өр төлбөрийн эрх зүйн өвлөл нь зээлдүүлэгчийн эрх, үүргийг хөндөх ёсгүй.

Улсууд нэгдэх тохиолдолд тэдгээрийн нийт өр, төлбөр өвлөгч улсад шууд шилждэг.



Улс задрах, түүнчлэн нэг улсын нутаг дэвсгэрийн хэсэгт шинэ улс үүсэх, эсвэл нутаг дэвсгэрийн хэсэг нөгөө улсад шилжих зэрэг тохиолдолд өвлүүлэгч улсын өр төлбөр, өвлөгч улс бүрт шударгаар хувь тэнцэн шилждэг. Энэ тохиолдолд тухайн өвлөгч улсад шилжиж буй хөрөнгө, эрх зэргийг харгалздаг байна.

Олон улсын гэрээний эрх зүйн өвлөл

Улсын нутаг дэвсгэр, хил, хилийн дэглэмийн талаархи олон улсын гэрээний хувьд эрх зүйн өвлөлийн харилцаа үүсэхгүй.

Нэгдэх

Нэгдсэн улсуудын гэрээ хүчин төгөлдөр байх ба, эрх өвлөгч-улсын нутаг дэвсгэрийн тэрхүү хэсэгт тухайн гэрээ хүчинтэй байдаг. Олон талт гэрээний хувьд өвлөгч улс мэдэгдэл хийсэн тохиолдолд түүний бүх нутаг дэвсгэрт үйлчилж болно. Харин хоёр талт гэрээний эрх өвлөгч-улс гэрээний нөгөө талтай тохиролцож өөрөөр шийдвэрлэж болно.

Задрах

Өвлүүлэгч улсын бүх нутаг дэвсгэрт хамааралтай гэрээ шинэ үүссэн улс бүрт хүчин төгөлдөр болно. Гэхдээ тухайн улсууд өөрөөр тохиролцох боломжтой.

Шилжихэд

Өвлүүлэгч улсын байгуулсан гэрээ шилжсэн нутаг дэвсгэрт үйлчлэхээ больж, уг нутаг дэвсгэр харъяалагдах болсон улсын олон улсын гэрээ үйлчилдэг.

Төрийн өмч, хөрөнгийн эрх зүйн өвлөл

Конвенцид зааснаар өвлүүлэгч улсын төрийн өмч гэдэгт- эрх зүйн өвлөлийн үед түүний дотоодын хууль тогтоомжийн дагуу түүнд харъяалагдах хөрөнгө, эрхийг хамааруулж ойлгодог байна.

Нэгдэх

Нэгдсэн улсуудын бүх өмч хөрөнгө өвлөгч улсад шилждэг.

Задрах

Өвлөгч улсын нутаг дэвсгэрт орших өвлүүлэгч улсын үл хөдлөх хөрөнгө шууд шилждэг. Харин 1983 оны Конвенциор өвлүүлэгч улсын гадаад улсад байх үл хөдлөх хөрөнгө өвлөгч улс бүрт хувь тэнцүүлэх замаар шилждэг. Мөн энэ нутаг дэвсгэрт өвлүүлэгч улс үйл ажиллагаа хэвийн явуулахад шаардлагатай хөдлөх эд хөрөнгө өвлөгч улсад шилжэх ба бусад хөдлөх хөрөнгө нь шударгаар хувь тэнцэн шилждэг.

Шилжих

Тухайн нутаг дэвсгэрт орших үл хөдлөх хөрөнгө өвлөгч улсад шилжинэ. Шилжиж буй нутаг дэвсгэрт өвлөгч улсын үйл ажиллагаанд шаардлагатай хөдлөх хөрөнгө өвлөгч улсад шилждэг. Бусад хөдлөх хөрөнгийн хувьд шударгаар хувь тэнцүүлэх зарчмаар шилждэг байна.

Улсын архивийн эрх зүйн өвлөл

1983 оны Конвенцийн 20-р зүйлд өвлүүлэгч улсын архив нь эрх зүйн өвлөлийн үед түүний дотоодын хууль тогтоомжийн дагуу түүнд харьяалагдаж, тодорхой зорилгоор шууд хадгалж байсан болон түүний хяналтанд байх, өвлүүлэгч улсын үйл ажиллагааны явцад боловсруулагдан бий болсон өнгөрсөн үеийн баримт бичгийн нийлбэр цогц юм.

Нэгдэх

Өвлөгч улсад өвлүүлэгч улсуудын архив шууд шилждэг.

Задрах

Хэвийнүйлажиллагаагявуулахадшаардлагатай өвлөгч улсын нутаг дэвсгэрт оршин байх архивын хэсэг түүнд шилждэг.

Шилжих

Тухайн нутаг дэвсгэрт шинэ улс хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай өвлөгч улсын нутаг дэвсгэрт оршин байх ёстой архивын хэсэг түүнд шилждэг.



Бодлого

1. 1958 онд Сири, Египет хоёр улс нэгдэж Арабын Бүгд Найрамдах улс хэмээх шинэ улс байгуулжээ.
а. Эрх зүйн өвлөлийн асуудлыг ОУЭЗ-н дагуу шийдвэрлэнэ үү?
2. 1991 онд хуучин ЗХУ задарч 12 тусгаар тогтносон улс болж задарсан байна.
а. Эрх зүйн өвлөлийн асуудлыг ОУЭЗ-н дагуу шийдвэрлэнэ үү?



Даалгавар:

1. Олон улсын эрх зүйн өвлөлийн харилцаа үүсэх тохиолдол /нэгдэх, задрах, шилжих/ тус бүр дээр өвлөлийн харилцааны объект /олон улсын гэрээ, төрийн өмч, архив, өр төлбөр/ ямар журмаар шилжих харьцуулж, бүдүүвч хий.



Хяналтын асуулт

1. Олон улсын эрх зүйн өвлөлийг юу гэж ойлгож байна вэ?
2. Олон улсын эрх зүйн өвлөлийн асуудлаархи олон улсын баримт бичиг тэдгээрийн онцлог шинжийг дурьдана уу?
3. Улс задрах, нэгдэхэд олон улсын гэрээний эрх зүйн өвлөл хэрхэн явагдах вэ?
4. Ямар олон улсын Гэрээнд эрх зүйн өвлөл хамаардаггүй вэ?
5. Төрийн өмч, хөрөнгийн эрх зүйн өвлөлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?
6. Улс задрах тохиолдолд ямар журмаар өр, төлбөрийн эрх зүйн өвлөл шийдвэрлэгдэх вэ?



Эх сурвалж

1. М.Дүгэрсүрэн. О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. 64-67 х. УБ., 1999 он.
2. Б.Нармандах, Н.Гантулга. Олон улсын нийтийн эрх зүй. УБ., 2003 он.
3. Гэрээний эрх зүйн өвлөлийн тухай 1978 оны Венийн конвенц,
4. Төрийн өмч, архив, өр төлбөрийн эрх зүйн өвлөлийн тухай 1983 оны Венийн конвенц

7. Хүн ам ба нутаг дэвсгэр



Нэр томъёо

Дотоод далайн ус- нутаг дэвсгэрийн далайн шугамаас дотогш орших ус,

Нутаг дэвсгэрийн далай-дотоод далайн устай зах нийлсэн, улсын бүрэн эрхэд орших далайн хэсэг,

Нээлтэй далай- дотоод далайн ус, нутаг дэвсгэрийн уснаас гадна орших далайн хэсэг,

Залгаа бүс-нутаг дэвсгэрийн усны өргөнийг хэмжих шугамаас гадагш далайн 24 миль дотор багтах далайн хэсэг,

Эх газрын хормой-нутаг дэвсгэрийн усны гадаад хязгаараас 200 далайн миль доторх далайн ёроол, түүний хэвлий,

Эдийн засгийн онцгой бүс-нутаг дэвсгэрийн усны гадаад хязгаараас далайн 200 милийн доторхи далайн хэсэг,

Олон улсын гол- 2 буюу түүнээс улсын нутаг дэвсгэрээр урсдаг гол, мөрөн,

Харьяалал-аливаа бие хүн, улс хоорондын эрх зүйн холбоо,

Ургийн зарчим (Jus sanguinis)-оршия байх газрыг харгалзалгүй хүүхэд эцэг, эхийн харьяалал авах,

Нутаг дэвсгэрийн (Jus soli)- эцэг, эхийн харьяалалыг харгалзалгүй нутаг дэвсгэр дээр нь төрсөн улсын харьяалал авах,

Харьяалалгүй хүн (апатрид)-аль нэг улсын харьяат биш бие хүн,

Хоёрдмол харьяалалтай хүн (бипатрид) -нэгэн зэрэг 2 ба түүнээс дээш улсын харьяалалтай бие хүн,

Харьяалал совтох (оптаци)-нутаг дэвсгэрийн хэсэг шилжихэд үүсдэг харьяалал олж авах арга,

Хүсэлтээрээ харьяалал олж авах (натурализаци)- сонирхогч этгээдийн хүсэлтээр хэрэгжих харьяалал олж авах арга,

Хүсэлтээрээ харьяатгаас гарах (экспатриаци)- хувь хүн өөрийн хүсэлтээ тавьж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр харьяалалаа алдах,

Харьяалалаас хасах (денатурализаци)-өөрийн үйл ажиллагаагаар улсын аюулгүй байдалд хор учруулсан этгээдийг улс санаачилгаараа харьяатаасаа хасах,

Хүндэт иргэн-улсын эрх бүхий байгууллагын санаачилгаар хүндэт иргэн болдог.

Нутаг дэвсгэр, улсын хилийн ойлголт, тэдгээрийн ангилал

Олон улсын эрх зүй болон улсуудын эрх зүйн бүлд нутаг дэвсгэрийн нийтээр хүлээн зөвшөөрсөн ойлголт байдаг. Нутаг дэвсгэрт хамгийн өргөн утгаараа хүн төрөлхтний оршин тогтнох материаллаг орчин болсон Дэлхий, түүний усан болон




хуурай гадаргуу, газрын гүн, дээрхи агаарын орон зай, Нар, Сар бусад эрхэс гаригыг хамааруулж ойлгож болно.

Улсын хил -тодорхой нэг улсын засаглал, бүрэн эрхийн орон зайн хязгаар буюу агаар, усан, хуурай газар, газрийн гүнд улсын нутаг дэвсгэрийн хүрээг газрийн зурагт болон орон нутагт тодорхойлсон шугамыг ойлгоно.


Улсын хилийн дэглэм- хил залгаа улстай байгуулсан гэрээг үндэслэн улсын хилийг тодорхой байлгах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хилийн асуудалтай холбогдсон бусад үйл ажиллагааг зохицуулахаар тогтоосон журам юм.

Улсын хилийн зурвас- хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны зориулалттай хилийн ииженер, техникийн байгууламж барих зорилгоор улсын хилийн шугамаас дотогш эрх бүхий байгууллагаас тогтоож буй нутаг дэвсгэр юм.

Улсын хилийн бүс- лсын хил хамгаалах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг хилийн бүс гэнэ. Түүний өргөнийг хил хамгаалах байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргатаан зөвшилцсөний үндсэн дээр улсын хилийн шугамаас 100 км-ээс илүүгүйгээр тогтооно.



Хил тогтоох үе




Хүн ам

Улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа бүх хүнийг хүн ам гэнэ. Хүн амын эрх зүйн байдлыг улс өөрөө тогтооно. Нэг талаас хүн амын зорчих, шилжилт хөдөлгөөн улам нэмэгдэж, нөгөө талаас гадаадын иргэн, хүний эрх, зэрэг хүн амд холбоотой асуудлыг зохицуулдаг ОУНЭЗ-н хэм хэмжээ бий болж улс хүн амын эрх зүйн байдлаа тогтоохдоо олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ харгалздаг юм.



Харьяалал -бие хүн ба улс хооронд эрх зүйн тогтвортой холбоог ойлгоно.





Хяналтын асуулт

1. Улсын нутаг дэвсгэртэй адилгаж үзэх объект гэж юу? Жишээ татна уу?
1. Нутаг дэвсгэрийн үндсэн төрөл, тэдгээрийн орон зайн хязгаарыг тодорхойлох шалгуур юу вэ?
2. Улсын нутаг дэвсгэрийг тодорхойлж, түүний бүрэлдэхүүн хэсгийг дурьдана уу?
3. Улсын хил тогтоох ямар журам байдаг вэ?
4. Хүн ам хэмээх ойлголтыг тодорхойлж, эрх зүйн байдалтай холбоотой ямар асуудал олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг вэ?
5. Харьяалал олж авах ямар журам, алдах ямар тохиолдол байдаг вэ?
6. Хоёрдмол харьяалалд юуг ойлгох вэ? Монгол улсын хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрдөг эсэх?
7. Харьяалалгүй байх гэж юуг ойлгох вэ? Олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрдөг эсэх?



Бодлого

1. Иргэн А нь Б, Г гэсэн хоёр улсын харьяалалтай бөгөөд түүнд нэгэн зэрэг хоёр улсаас зэвсэгт хүчинд алба хаах мэдэгдэл иржээ.
 - a. Иргэн А-д зөвлөгөө өгнө үү?
 - b. Хоёрдмол харьяалалыг Монгол улс хүлээн зөвшөөрдөг үү?
2. Монгол улсын иргэн Б АНУ-ын иргэн К-тай гэр бүл болж Бостон хотод амьдардаг юм. Тэдний дундаас М гэдэг хүү мэндэлсэн байна.
 - a. Хүүгийн харьяалалын асуудлыг хэрхэн зохицуулах вэ?



Эх сурвалж

1. М.Дүгэрсүрэн. (ХХосбаяр. Олон улсын эрх зүй. 68-100 х. УБ., 1999 он.
2. Б.Нармандах, Н.Гантулга. Олон улсын нийтийн эрх зүй. УБ., 2003 он.
3. Монгол Улсын Үндсэн хууль
4. Хилийн тухай Монгол улсын хууль
5. Харьяатын тухай Монгол улсын хууль

III бүлэг. ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ТУСГАЙ АНГИ

8. Олон улсын гэрээний эрх зүй


Аливаа улсууд эрт дээр үеэс өөр хоорондоо гэрээ байгуулах замаар өөрийн эрх үүргийг тодорхойлсоор ирсэн. Олон улсын харилцааг зохицуулагчийн үүрэг гүйцэтгэсээр ирсэн олон улсын гэрээ нь түүхэн хөгжлийн явцад түүнийг байгуулах, хүчин төгөлдөр болгох, дуусгавар болгох, цуцлах зэрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээг бий болгожээ. Саяхныг хүртэл эдгээр хэм хэмжээ нь заншлын хэм хэмжээ байсан бол 1969 онд Вена хотноо хуралдсан Дипломат бага хурлаар Олон улсын гэрээний тухай конвенцийг баталснаар улс орнууд өөр хоорондоо байгуулах гэрээндээ уг конвенцийг мөрдлөг болгодог болсон.

"Олон улсын гэрээний тухай 1969 оны Венийн конвенц"-ийн 2 дугаар зүйлд "Гэрээ" гэж нэг баримт бичигт, эсхүл хоёр буюу өөр хоорондоо холбоотой хэд хэдэн баримт бичиг агуулагдаж байгаа эсэх, мөн түүнчлэн түүний тодорхой нэрээс хамаарахгүйгээр улсуудын хооронд бичгээр байгуулсан бөгөөд олон улсын эрх зүйгээр зохицуулагдаж байгаа олон улсын хэлэлцээрийг хэлнэ"

Олон улсын гэрээний тухай 1993 оны Монгол Улсын хуульд "Олон улсын гэрээ гэж Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ"

Олон улсын гэрээний **онцлог** нь түүний оролцогчид гагцхүү олон улсын харилцааны субъектууд байдагт оршино. Өөрөөр хэлбэл олон улсын гэрээг олон улсын харилцааны субъект болох улс, эсхүл засгийн газар хоорондын олон улсын байгууллагууд л өөр хоорондоо байгуулна.

Олон улсын гэрээг түүний оролцогчдоос шалтгаалж олон улсын түгээмэл гэрээ /олон улсын конвенц/ болон хязгаарлагдмал оролцогчтой олон улсын гэрээ /хоёр талт гэрээ/, үүнээс үүдэн нээлттэй болон хаалттай гэрээ гэж ангилна. Мөн зохицуулах зүйлээс шалтгаалан улс төрийн, эдийн засгийн, эрх зүйн туслалцаа үзүүлэх, тээврийн гэрээ зэргээр ангилж болно.





Гэрээ байгуулах бүрэн эрх

"Бүрэн эрхийн итгэмжлэл" гэж өөрийн улсыг төлөөлөн хэлэлцээ хийх, гэрээний эх бичвэрийг батлах буюу жинхлэх, гэрээг заавал биелүүлэх тухай өөрийн улсын зөвшөөрлийг илэрхийлэх буюу гэрээнд холбогдох бусад аливаа үйлдлийг гтйцэтгүүлэх зорилгоор тухайн улсын эрх бүхий байгууллагаас нэг буюу хэд хэдэн этгээдийг томилж байгаа баримт бичгийг хэлнэ.

Гэрээ байгуулах үе шат

а. **Гэрээний эх бичвэрийг бэлтгэх:** Хоёр талт гэрээний эх бичвэрийг дипломат шугамаар хоёр хоёр улс хоорондоо хэлэлцээ хийж тохиролидог бол олон талт гэрээний эх бичвэрийг олон улсын байгууллагууд ихэвчлэн бэлтгэж боловсруулдаг.

б. **Гэрээний эх бичвэрийг адил хүчинтэйг тогтоох:** Гэрээг үйлдсэн хэлүүд дээрх эх бичвэрүүд утга болон агуулгын хувьд хоорондоо гүйцэж байгааг тогтоох.

с. **Гэрээний хүчин төгөлдөр байдлыг түүнд оролцогчид илэрхийлэх:** Гэрээг заавал биелүүлэх зөвшөөрлөө гэрээнд гарын үсэг зурах, гэрээг бүрдүүлэгч баримт бичигүүдийг солилцох, гэрээг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох буюу урьдчилан тохиролцсон бусад аргаар илэрхийлнэ.

Эх хадгалагч (Депозитари)

Зөвхөн олон талт гэрээнд хамаарах бөгөөд адил хүчинтэй эх бичвэр бүхий гэрээг хадгалах үүрэгтэй.

Бүртгэх, нийтлэх

Олон улсын гэрээг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ. Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан олон улсын гэрээг нийтлэхдээ Монгол Улсын хууль нийтлэх журам, олон улсын бусад гэрээг нийтлэхдээ Засгийн газрын тогтоол нийтлэх журмыг тус тус баримтална. Олон улсын гэрээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн тусгай эмхтгэл болгон хэвлэж байна.

Гэрээ хүчин төгөлдөр болох

Тухайн гэрээгээр талууд эрх эдлэж, үүрэг хүлээх нөхцөл бүрдэхийг хэлнэ. Гэрээний оролцогчид гэрээг заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд түүнийг үнэнч шударгаар хэрэгжүүлнэ.

Гэрээнд тайлбар (reservation) хийх

Гэрээний жинхэнэ утга санааг илэрхийлэхийг хэлнэ. Хэрэв гэрээний оролцогчид тухайн гэрээнд орсон нэр томъёо тусгай утга санаа илэрхийлж байна гэж үзвэл уг гэрээнд заасны дагуу тайлбар хийж болдог.

Хүчин төгөлдөр бус гэрээ

Олон улсын нийтлэг эрх зүйн заавал мөрдөх хэм хэмжээ (jus cogens)-нд харшилсан гэрээ, Улсыг хүчээр сүрдүүлэх буюу хүч хэрэглэх замаар албадах, улсын төлөөлөгчийг албадах, улсын төлөөлөгчийг хахуульдах, хууран мэхлэх, алдаа

Гэрээний үйлчлэл дуусгавар болох

Гэрээ нь хууль зүйн хүчин төгөлдөр байдлаа алдах, эсхүл түүний аль нэг оролцогч гэрээнд заасны дагуу буюу бусад оролцогчийн зөвшөөрлөөр түүнээс гарах.



Хяналтын асуулт

1. Олон улсын гэрээний эрх зүйн субъект хэн байх бэ?
2. Олон улсын гэрээний эрх зүйн объектод юуг тооцох вэ?
3. Олон улсын гэрээний эрх зүйд олон улсын нийтийн эрх зүйн үндсэн зарчим хэрхэн холбогдох вэ?
4. Соёрхон батлах ажиллагаа нь батлахаас ялгарах онцлог шинжийг тайлбарлана уу? Заавал соёрхон батлах гэрээ гэж ямар гэрээг хэлэх вэ?
5. Олон улсын гэрээ хэрхэн хүчин төгөлдөр болдог вэ? Олон улсын гэрээний хүчин төгөлдөр болох болон үйлчлэх нэг ойлголт мөн үү?
6. Олон улсын гэрээг анхнаас нь хүчингүйд тооцох, хүчингүйд тооцох хоёрын ялгааг тодорхойлж, тус бүрийн үндэслэлийг тайлбарлана уу?
7. Олон улсын гэрээний эрх зүйг судлахын ач холбогдлыг тодорхойлно уу?



Бодлого

"А" аймгийн Засаг дарга "В" улсын "С" мужийн захирагчтай эдийн засгийн салбарт хамтран ажиллах тухай гэрээ байгуулав. Гэрээг байгуулахын өмнө хоёр тал гэрээний эх бичвэрийг хэд хэдэн удаа солилцож эх бичвэрийг тохиролцсон бөгөөд гэрээгээр "А" аймагт шаардлагатай цахилгаан стантцын тоног төхөөрөмжийг "С" мужаас тусламж болгон "А" аймагт нийлүүлэх түүний хариуд "А" аймаг тухайн тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөхөөр хоёр тал тохиролцов. Гэтэл тоног төхөөрөмжийг улсын хилээр оруулах үед гааль тухайн тоног төхөөрөмжид татвар ногдуулж, "А" аймгийн удирдлагаас түүнийг төлөхийг шаардав. "А" аймгийн Засаг дарга "С" мужийн захирагчтай байгуулсан гэрээгээ үзүүлж тухайн тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөхийг хүссэн боловч түүний хүсэлт талаар болов.

а. Засаг даргын хүсэлтийг хүлээж аваагүй үндэслэлийг гаргаарай.



Эх сурвалж

1. Олон улсын гэрээний тухай 1969 оны Венийн конвенц1,
2. Олон улсын гэрээний тухай 1993 оны хууль2,
3. Байгууллага хоорондын гэрээний тухай Засгийн газрын 1994 оны 201 тоот тогтоол



9. Олон улсын нийтийн эрх зүй болон үндэсний эрх зүй хоорондын харилцан хамаарал


Харилцан хамаарал

Үндэсний эрх зүйн хэм хэмжээ олон улсын эрх зүйн хэм хэмжээ бүрэлдэн бий болох гол нөхцөлийг бүрдүүлдэг бол олон улсын эрх зүйн хэмжээ эргээд үндэсний буюу дотоодын эрх зүйн хэм хэмжээнд нөлөөлдөг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөөний талаархи хэм хэмжээ нь хүний эрхийн талаархи олон улсын баримт бичгийн заалтуудад үндэслэгдсэн байдаг.



Олон улсын эрх зүйн нэг онцлог нь эрх зүйн тухайн тогтолцоон дахь субъектуудын эрх үүргийг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь улс орнуудын эрх хэмжээг тодорхойлдог бөгөөд тухайн улсын төрийн байгууллагууд, хувь болон хуулийн этгээд олон улсын эрх зүйн хэм хэмжээг шууд дагаж мөрддөггүй.

Нөгөөтэйгүүр, улс орнууд олон улсын эрх зүйн дагуу үүрэг хүлээхийн сацуу түүнийг үндэсний хэмжээнд буюу дотооддоо мөрдөх, нутаг дэвсгэрийнхээ хүрээнд биелэлтийг нь хангах үүрэгтэй. Үүнийг олон улсын эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилт буюу имплементаци гэнэ.




Олон улсын эрх зүйн нэг онцлог нь аливаа улс дотоодынхоо хууль тогтоомжийг ишлэл хийж олон улсын эрх зүйн хэм хэмжээг зорчиж болдоггүйд орших бөгөөд олон улсын эрх зүйн хэм хэмжээг биелүүлэхгүй байх шалтгаан нь дотоодын хууль тогтоомж байдаггүйд оршино. Өөрөөр хэлбэл дотоодын хууль тогтоомжоо биелүүлэх нэрийдлээр олон улсын хэм хэмжээг зөрчиж болохгүй гэсэн үг юм.

Практикт аливаа улсын дотоодын хууль тогтоомж нь олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй зөрчилдөх явдал цөөнгүй тохиолддог. Энэ тохиолдолд олон улсын эрх зүйн хэм хэмжээ давуу хүчинтэй. Тухайлбал, Олон улсын эрх зүйн арван жилд (1990-1999 он) зориулан Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1989 онд батласан тогтоолд олон улсын эрх зүйг олон улсын харилцаанд тэргүүлэх үүрэгтэй болохыг зааж түүнийг өргөн хүрээгээр зааж сурталчлах, түгээж дэлгэрүүлэхийг гишүүн орнуудад уриалжээ.

Монгол Улсын хувьд дотоодын хууль тогтоомж Монгол Улсын олон улсын гэрээтэй зөрчилдөх тохиолдолд олон улсын гэрээний заалт давуу хүчинтэй байх талаар ихэнх хуулинд заасан байдаг.

Олон улсын эрх зүй болон дотоодын хууль тогтоомжийн талаар хоёр онол байдаг





Хяналтын асуулт

1. Олон улсын эрх зүй болон үндэсний эрх зүйн хоорондын хамаарлыг тайлбарлана уу?
2. Монгол Улсын хууль тогтоомж олон улсын эрх зүйтэй зөрчилдөх тохиолдолд аль нь давуу хүчинтэй вэ, Яагаад?
3. Монист онол болон дуалист онолын талаар тайлбарлана уу?
4. Олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрхэн биелүүлдэг вэ?
5. Үндэсний эрх зүйд олон улсын эрх зүйн хэм хэмжээ хэрхэн нөлөөлдөг вэ?




Эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он.
2. МДүгэрсүрэн. (ХХосбаяр. Олон улсын эрх зүй 3-5 х УБ.1999 он.
3. Ю.М.Колосов. Э.С.Кривчикона. Международное. право Москва. 2000 9-11-стр

10. Олон улсын байгууллагын эрх зүй

Олон улсын байгууллагын ойлголт

Өнөөгийн олон улсын харилцаанд олон улсын байгууллагын гүйцэтгэх үүрэг өндөр хэдий ч "олон улсын байгууллага" гэж чухам юуг хэлдэг талаар нэгдсэн тодорхойлолт үгүй юм. "Олон улсын байгууллага" гэсэн нэр томъёог засгийн газар хоорондын олон улсын байгууллага, засгийн газрын бус олон улсын байгууллагын хувьд хэрэглэж заншсан. Энэхүү хоёр төрлийн байгууллага нь эрх зүйн зохицуулалтын хувьд өөр байдаг бөгөөд засгийн газар хоорондын олон улсын байгууллага засгийн газрын бус олон улсын байгууллагаас дараахь шинжээр ялгагддаг.




- > Тухайн байгууллагыг үүсгэн байгуулсан эрх зүйн баримт бичиг;
- > Тухайн байгууллагын гишүүнчлэл;
- > Тухайн байгууллагын зорилго зарчим;
- > Олон улсын эрх зүйн чадамжтай эсэх. Эдгээр шинжээс авч үзэхэд:

Засгийн газар хоорондын олон улсын байгууллага нь тусгаар улсуудын гишүүнчлэлээс бүрдсэн, тухайн байгууллагыг үүсгэн байгуулах эрх зүйн баримт бичиг нь улс хоорондын олон улсын гэрээнд үндэслэгдсэн, олон улсын эрх зүйн зарчмуудад нийцсэн зорилтыг биелүүлэх чиг үүрэг, байнгын ажиллагаатай механизм бүхий олон улсын эрх зүйн чадамжтай байгууллагыг хэлнэ гэж тодорхойлж болох юм. Засгийн газар хоорондын ийм байгууллагыг олон улсын эрх зүйн субъект гэж мөн хүлээн зөвшөөрдөг.



Олон улсын ийм төрлийн байгууллага нь төрөл бүрийн нэртэй байж болно. **Тухайлбал:** холбоо, сан, банк байгууллага гэх мэт нэр нь өөр өөр байх боловч эрх зүйн статусын хувьд бүгд ижил юм.

Олон улсын байгууллагын ангилал




Түгээмэл (НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд) болон бүс нутгийн олон улсын байгууллага (Европын холбоо, Зүүн өмнөд Азийн үндэстнүүдийн холбоо-АСЕАН, Африкийн нэгдлийн байгууллага, Латин Америкийн улсуудын башууллага гэхмэт);

Нийтлэг (улс төр, эдийн засаг, нийюм, соёл зэрэг гишүүн улсуудын бүх талын асуудлыг хамарсан байгууллага, тухайлбал НҮБ, Европын холбоо, АСЕАН) болон тусгай чиг үүрэг бүхий (МАГАТЭ, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын цагаачлалын байгууллага гэх мэт);

Нээлттэй (аль ч улс тухайн байгууллагын гишүүн болох эрх нь нээлттэй байх) болон хаалттай (аливаа улс зөвхөн тухайн байгууллагыг үүсгэн санаачлагчдын зөвшөөрлөөр гишүүн нь болдог, тухайлбал Дэлхийн худалдааны байгууллага, НАТО гэх мэт) байгууллага зэргээр ангилж болдог.

Засгийн газар хоорондын олон улсын байгууллага

Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын гол зарчим нь улсуудын бүрэн эрхт, тэгш байдлыг хүндэтгэх явдал юм. Уг зарчмын илэрхийлэл нь олон улсын байгууллагыг олон улсын гэрээгээр байгуулах, сайн дурын гишүүнчлэл, тухайн байгууллагаас гарах шийдвэр нь ихэвчлэн зөвлөмжийн чанартай байдаг, байгууллагын гишүүн улсуудын бүрэн эрхт байдал, эрх тэгш байдлыг хаана ч хадгалах зэргээр тусгалаа олдог. Сүүлийн үед улсууд олон улсын байгууллага байгуулснаар тухайн байгууллагад эрх зүйн тодорхой чадамж олгох, олон улсын эрх зүйн харилцаанд эрх зүйн хэм хэмжээ бий болгох, түүнийг хэрэгжүүлэхэд улсуудтай адил тэгш эрхтэй оролцох боломжоор хангах үзэгдэл түгээмэл болж



байна. Тухайлбал, олон улсын гэрээ конвенцц засгийн газар хоорондын олон улсын байгууллагыг улсуудын нэгэн адил оролцогч болж болохоор³ заасан байдаг.

Түүнчлэн засгийн газар хоорондын олон улсын байгууллага аливаа бүрэн эрхт улстай гэрээ хэлэлцээр байгуулах, олон улсын харилцаанд бие даан оролцох (тухайлбал, НҮБ зэрэг байгууллагын дэргэд улс орнууд төлөөлөгчийн газраа нээн ажиллуулж буй нь бусад улсад Элчин сайдын яам байгуулан ажиллуулахтай ижил юм) эрхтэй байдаг нь түүний нэгэн онцлог шинж юм.

Олон улсын байгууллагыг улсууд тодорхой зорилго дэвшүүлж, эл зорилгыг биелүүлэх үүднээс тодорхой эрх мэдэл өгч түүнийгээ тухайн байгууллагыг байгуулах эрх зүйн баримт бичигт нь тусгах замаар байгуулдаг. Тухайлбал, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк зэрэг олон улсын банк санхүүгийн томоохон байгууллагыг байгуулсан. Эдгээр байгууллага нь өөрийн гишүүн улсуудын эдийн засаг, санхүүгийн харилцаанд томоохон үүрэг гүйцэтгэсээр ирснээс гадна олон улсын байгууллагын статустайгаар үйл ажиллагаа явуулах, тухайлбал гишүүн орнуудад өөрийн салбар төлөөлөгчийн газраа нээн ажиллуулах, тухайн салбар нэгжид ажиллагсад нь дархан эрх, эрх ямба эдэлдгээрээ онцлогтой.



Олон улсын харилцааны субъект болох улсууд нь өөр хоорондоо дипломат харилцаа тогтоож, дипломат төлөөлөгчийн газраа харилцан нээн ажиллуулах, түүнд томилогдон очсон ажиллагсад нь Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенц- болон Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенцийн5 дагуу дархан эрх, эрх ямба эдэлдэг бол засгийн газар хоорондын олон улсын байгууллагаас гишүүн орнуудад суугаа төлөөлөгчийн газрын ажиллагсад нь НҮБ-ын эрх дархын тухай 1946 оны конвенц", НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын эрх дархын тухай 1947 оны конвенц, Түгээмэл шинжтэй олон улсын байгууллагад улс гүрнээ төлөөлөх эрхийн тухай 1975 оны конвенцийн8 болон олон улсын тухайн байгууллагыг үүсгэн байгуулсан эрх зүйн баримт бичигт заасны дагуу дархан эрх, эрх ямба эдэлдэг.

Манай улсад, өнөөдрийн байдлаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын ваиотын сан. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк гэсэн олон улсын байгууллага өөрийн салбар төлөөлөгчийн газраа ажиллуулж байна.

Засгийн газрын бус олон улсын байгууллага

Засгийн газрын бус олон улсын байгууллага нь засгийн газар хоорондын олон улсын байгууллагаас ялгагдах гол онцлог нь үүсгэн байгуулах эрх зүйн баримт бичиг нь улс хоорондын гэрээ хэлэлцээрт үндэслэгдээгүй, түүний гишүүнчлэлд улс орноос гадна улс үндэстний доторхи төрөл бүрийн холбоо, нийгэмлэг, төрийн бус байгууллага. хувь хүн орж болдог, тухайн байгууллагаас гарах шийдвэр нь улс орнуудын хувьд эрх зүйн хувьд заавал биелүүлэх хүчин төгөлдөр бус, олон улсын харилцаанд эрх зүйн чадамжгүй зэрэгт оршдог. Тухайлбал, Олон улсын улаан загалмайн нийгэмлэг, "Олон улсын эмнэсти интернэшнэл" зэрэг байгууллагыг үүнд дурдаж болно.



Хяналтын асуулт

1. Олон улсын байгууллага нь Олон улсын нийтийн эрх зүйн субъект болохын хувьд ямар шинжийг агуулах талаархи дүн шинжилгээ хийнэ үү.
2. Олон улсын байгууллагыг үүсгэн байгуулах баримт болон түүний шинжийг тодорхойлно уу.
3. Олон улсын байгууллага ямар чиг үүрэгтэй вэ?
4. Улс гүрэн олон улсын байгууллагын гишүүний хувьд ямар эрх эдэлж, үүрэг хүлээдгийг шинжилнэ үү?
5. НҮБ-ын эрх зүйн байдлыг тодорхойлно уу?
6. Засгийн газрын болон засгийн газрыш бус байгууллагын хоорондын ялгааг нэрлэнэ үү?



Бодлого

1994 онд НҮБ-ыш Ерөнхий ассамблейн 48 дугаар чуулганаар ОХУ болон Украинм төлөөлөгч нарын хооронд маш хурц маргаан өрнөжээ. Маргааны сэдэв нь Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгт /ТУХН/-т НҮБ-ын ажиглагч гишүүний статус олгох асуудал байлаа. Украины төлөөлөгч Владимир Ховдогий ТУХН-ийг олон улсын эрх зүйн субектэд тооцох асуудлыг няцааж, энхийг сахиулах ажиллагаа явуулах чадвартай бүс нутгийн байгууллага гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байлаа.

Энэ үзэл Оросын үзэл баримтлалтай үндсээрээ нийцэхгүй юм. Учир нь ОХУ нь ТУХН-ИЙГ олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө бололцоотой бүхий л арга хэрэгслэлээ ашиглаж байжээ. Москвагийн зүтгэлээр л уг асуудал НҮБ-ын Ерөнхий ассамблейн 48 дугаар чуулганаар авч хэлэлцэгдсэн. ОХУ-аас НҮБ-д суугаа төлөөлөгч Юрий Воронцов Украины байр суурийн талаар хэлэхдээ: ТУХН-ийн гишүүн орнуудын хувьд хамтын нийгэмлэгийн болон гишүүн улсын хоорондын хэлэлцээрийн шинж чанарын талаархи мэдээлэл дутмаг байсантай холбоотой гэжээ. Түүний хэлсэнчлэн ТУХН-ийн энхийг сахиулах ажиллагааны эрх зүйн үндэс нь 1992 оны 3-р сарын 2()-ны өдөр Украины нийслэл Киев хотноо гишүүн улсуудын гарын үсэг зурсан, тэр дундаа Украин мөн гарын үсэг зурсан гэрээ юм.

Хэдий Украин ийм онцгой байр суурьтай байсан ч ТУХН ажиглагч гишүүний статус олж авсан билээ. Өмнө нь Европын холбоо, Арабын улсуудын Холбоо Лига), Нэгдсэн Африкийн байгууллага гэх бүс нутгийн гурван байгууллага ийм статус олж авчээ.

1. Таны бодлоор Украйны байр суурь хэр үндэслэлтэй вэ?
2. Олон улсын байгууллага олон улсын эрх зүйн субектэд тооцогдох ямар шалгууртай байдаг вэ?
3. Олон улсын байгууллагыг хэрхэн ангилдаг вэ?



Эх сурвалж

1. М. Дүгэрсүрэн, О.Хосбаяр.Олон улсын эрх зүй. 177-208 х УБ., 1999 он
2. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн тусгай дугаарын II боть, 270-301х



11. Дипломатын эрх зүй


Дипломатын эрх зүйн ойлголт

Дипломатын эрх зүй нь олон улсын эрх зүйн хамгийн эртний салбарын нэг юм. Дипломат харилцааг зохицуулдаг гол баримт бичиг нь Вена хотноо 1961 онд батласан "Дипломат харилцааны тухай конвенц" болон 2000 онд батлагдсан Монгол Улсын "Дипломат албаны тухай хууль" юм. Мөн олон улсын заншлын эрх зүй дипломатын эрх зүйд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг.

Дипломатын эрх зүй нь элчин харилцааны эрх зүй, өөрөөр хэлбэл элчин харилцаатай холбоотой хэм хэмжээг зохицуулах хэлбэрээр үүсч хөгжиж байгаад ХХ зууны эхэн үеэс улс хоорондын албан ёсны харилцааг зохицуулдаг өнөөгийн дипломатын эрх зүйн үндсийг бүрдүүлжээ. Эндээс үзэхэд дипломатын эрх зүй нь аливаа улс орны гадаад харилцааг эрхлэн явуулах үйл ажиллагааг зохицуулах хэм хэмжээ гэж ойлгож болох юм.

Эртний болон дундад зууны үед элчин харилцаа нь түр зуурын шинжтэй байсан бол XV зууны үеэс байнгын элчин харилцаа үүсч хөгжсөөр өнөөг хүрчээ.

Энэ нь аливаа хоёр улс өөр хоорондоо дипломат төлөөлөгч солилцох замаар хоорондын харилцааг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.



Дипломат төлөөлөгчийн газрын чиг үүрэг

Дипломат төлөөлөгчийн газар нь үйл ажиллагаагаа байнга явуулдаг онцдогтой бөгөөд тухайн суугаа орныхоо онцлогоос хамаарч улс төр, эдийн засаг, соёл боловсрол, консул, худалдаа, цэргийн зэрэг асуудал хариуцсан нэгжтэй байдаг. Тухайлбал, Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдын яаманд эдгээр асуудлыг тухайлан хариуцсан ажилтнууд байдаг бол Монгол Улсаас БНБолгарУлсад суугаа ЭСЯ-нд 2-3 дипломат ажилтан дээрх асуудлыг ажил үүргийн хуваарийн дагуу эрхлэн явуулдаг.

Аль нэг улсаас гадаад оронд томилон ажиллуулж буй Дипломат төлөөлөгчийн газар дахь дипломат ажилтнуудын зэрэг зиндааг томилогч улсын хуулиар зохицуулдаг. Монгол Улсын хувьд Дипломат төлөөлөгчийн газар дахь дипломат ажилтнуудын албан тушаал, зэрэг дэвийг 2006 онд батласан "Дипломат албаны тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай хууль"-аар тодорхойлсон байдаг.




Дипломат төлөөлөгчийн газар томилогч улсыг хүлээн авагч улсад төлөөлөх; томилогч улсын болон түүний иргэдийн ашиг сонирхлыг хүлээн авагч улсад олон улсын эрх зүйн хүрээнд хамгаалах; хүлээн авагч улсын засгийн газартай хэлэлцээ хийх; хүлээн авагч улсад болж байгаа үйл явдал, нөхцөл байдлыг хууль ёсны бүхий л арга замаар судалж тодруулах, тэдгээрийн тухай томилогч улсын засгийн газарт мэдээлэх; томилогч улс болон хүлээн авагч улсын хооронд найрсаг харилцааг хөгжүүлэх, мөн тэдгээрийн хооронд эдийн засаг, соёл, шинжлэх ухааны салбарт харилцаа хөгжүүлэх үндсэн үүрэгтэй.

Дипломат харилцааг улс орнууд харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтоож төлөөлөгчийн газраа нээх эсэх, түүнчлэн дипломат төлөөлөгчдийн зэрэг дэвийг харилцан тохиролцдог. Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилогч улс томилох бөгөөд хүлээн авагч улс агреман (зөвшөөрөл) өгснөөр тухайн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх эрхтэй болохоос гадна хүлээн авагч улс шалтгааныг дурдахгүйгээр агреман өгөхөөс татгалзаж болдог байна.

Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг дараахь дөрвөн үе шатын дагуу томилдог.



Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг:



Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн хүлээн авагч улсын онцлогоос шалтгаалж: Итгэмжлэх жуух бичгээ барьсан мөчөөс эхлэн, эсхүл Итгэмжлэх жуух бичгийн баталгаат хуулбарыг хүлээн авагч улсын Гадаад хэргийн яаманд өгсөн мөчөөс эхлэн албан үүргээ гүйцэтгэж эхэлж дараагийн тэргүүн албан үүргээ гүйцэтгэж эхэлснээр, эсхүл түүнийг эгүүлэн дуудсан, эсхүл дипломат харилцаа тасарсан, эсхүл томилогч болон хүлээн авагч улсын аль нэг нь олон улсын эрх зүйн субъект байхаа больсон зэрэг шалтгаанаар түүний үүрэг дуусгавар болдог. Дипломат төлөөлөгчийн газрын бусад ажилтны хувьд дипломат томилолт авч хүлээн авагч улсын эрх бүхий холбогдох байгууллагад мэдэгдсэнээр албан үүргээ гүйцэтгэдэг бөгөөд тэдэнд агреман хүсэх шаарддагагүй.

Хүлээн авагч улсад байгаа гадаад орны дипломат төлөөлөгчийн газруудыг бүхэлд нь дипломат корпус гэж нэрлэдэг. Дипломат корпус нь явцуу утгаараа дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнүүд, өргөн утгаараа дипломат паспорт буюу хүлээн авагч улсаас олгосон дипломат карт бүхий дипломат ажилтнууд юм. Дипломат корпусын дуайен (ахлагч)-г хүлээн авагч улсад хамгийн удаан алба хашиж буй дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн хашдаг.

Гадаад оронд суугаа дипломат төлөөлөгчийн газрын ажилтнууд дархан эрх, эрх ямба эдэлдэг онцлогтой.



Дипломат харилцааны тухай Вений конвенцид зааснаар дархан эрх, эрх ямба нь аль нэг дипломат ажилтны хувийн эрх ашигт бус гагцхүү албан үүргээ үр дүнтэй биелүүлэхэд нь зориулагдсан бөгөөд ямар тохиолдолд дархан эрх, эрх ямба эдлэхийг тогтоосон байдаг.

Орчин үеийн олон улсын харилцаанд тусгай үүрэг гүйцэтгүүлэх талаар эрх зүйн зохицуулалт бий болсон бөгөөд энэ нь аль нэг улсыг төлөөлж нөгөө улсаас зөвшөөрөл авсны үндсэн дээр томилогдон очиж тухайн улстай тодорхой нэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх, эсхүл өөрийн улсын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх үүрэг бүхий элчийг тусгай үүрэг гүйцэтгэгч гэж хэлдэг. Хойд Солонгосын цөмийн асуудлаар АНУ, ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, БНАСАУ-ын төлөөлөгчдийн зохион байгуулж буй уулзалтууд нь үүний нэг тод жишээ болно.



Хяналтын асуулт

1. Дипломат ажиллагаа Олон улсын нийтийн эрх зүйн ямар үндсэн зарчимд тулгуурлан явагдах талаархи дүн шинжилгээ хийнэ үү?
2. Монгол Улсын гадаад харилцааны төрийн төв байгууллагын шинжийг тодорхойлоно уу?
3. Монгол Улсын Их Хурал дипломат ажиллагаанд ямар үүрэг гүйцэтгэх байгууллага вэ?
4. Дипломат төлөөлгчийн газрын үндсэн үүргийг тодорхойлно уу?
5. Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг ямар журмаар томилдог вэ?
6. Дипломат харилцааны тухай Венийн конвенцоос дипломат дархан эрх, эрх ямбыг нэрлэнэ үү.



Эх сурвалж

1. М.Дүгэрсүрэн. О.Хосбаяр. Олон улсын эрх зүй 151-170 х. УБ.1999 он.
2. Төрийн мэдээлэл" эмхтгэлийн тусгай дугаарын II боть, 405-419 х
3. Монгол улсын Үндсэн хууль. 1992 он



12. Консулын эрх зүй


Консулын харилцаа нь дипломат харилцааг бодвол илүү өмнө үүсэн бий болсон. Эртний Ромд МЭӨ III зуунд гадаадын иргэдийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэх үүрэг бүхий албан тушаал бий болсон нь орчин үеийн консулын үндсийг тавьсан. Консулын харилцааг зохицуулдаг эрх зүйн гол эх сурвалж нь Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенц юм. Түүнчлэн хоёр болон олон талт хэлэлцээр, конвеннууд, үндэсний хууль тогтоомж, олон улсын заншлын хэм хэмжээг хамааруулдаг.

Консулын эрх зүй нь консулын газар болон түүний албан хаагчдын гүйцэтгэх үүрэг, эрх зүйн статусын асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр шаардлагатай тохиолдолд дотоодын хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээний цогцыг хэлдэг.

Консулын эрх зүй нь дипломатын эрх зүйтэй салшгүй холбоотой бөгөөд зарим тохиолдолд бие даасан шинжтэй байдаг ч ихэнх тохиолдолд дипломатын эрх зүйн салшгүй хэсэг байдаг. Консулын эрх зүйн гол зарчим нь консулын асуудлаархи Хоёр талын гэрээ хэлэлцээрийг биелүүлэх юм.

Консулын харилцааг улс орнууд харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулдаг. Ихэнх тохиолдолд дипломат харилцаа тогтоосноор нэгэн зэрэг консулын харилцаа тогтоосонд тооцдог бол дипломат харилцааг тасалснаар консулын харилцааг тасалсанд тооцдоггүй. Тухайлбал, ХБНГУ 1956 онд Югославтай дипломат харилцаагаа тасалсан боловч консулын төлөөлөгчид нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулсаар байжээ.

Консулын харилцаа тогтоосноор консулын үйл ажиллагаа явуулах боломж нээгдэх бөгөөд хүлээн авагч улсын зөвшөөрснөөр консулын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийг тодорхойлдог. Олон улсын практикт консулын дараахь албан тушаалыг өргөн хэрэглэдэг.



Консулын газрын тэргүүнийг томилох тухай

Консулын газрын тэргүүнийг **томилох** тухай баримт бичгийг **патеет** гэх бөгөөд түүнд консулын овог нэр, албан тушаал, ажиллах тойргийг тусгаж хүлээн авагч талд хүргүүлдэг. Хүлээн авагч тал тухайн консулын газрын тэргүүнийг зөвшөөрсөн тухай баримтыг томилогч улсад хүргүүлэх бөгөөд түүнийг экзекватур гэдэг. Хүлээн авагч улс экзекватур өгөхөөс татгалзах эрхтэй бөгөөд ийнхүү татгалзах

болсон шалтгаанаа өчих албагүй. Ихэнх улсын хууль тогтоомжид консулын албан тушаалтныг томилогч улсаас томилохоор заасан байдаг бөгөөд хүлээн авагч улсын иргэнийг тухайн албан тушаалд томилох тохиолдолд хүлээн авагч улсаас зөвшөөрлийг авах шаардлагатай. Түүнчлэн Хүлээн авагч улс консулын аль нэг албан тушаалтныг **persona non grata**, эсхүл консулын бүрэлдэхүүний аль нэг гишүүнийг тааламжгүй этгээд гэж үзэж байгаагаа томилогч улсад хэдийд ч мэдэгдэж болно. Энэ тохиолдолд томилогч улс уг хүнийг эгүүлэн татах буюу консулын байгууллагад гүйцэтгэх чиг үүргийг нь зогсооно.


Консулын газрын чиг үүрэг

Консулын газрын үүрэг нь улс хоорондын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын харилцааг хөгжүүлэх, хүлээн авагч улс дахь өөрийн иргэдийн эрх ашгийг хамгаалахад орших бөгөөд Элчин сайдын яамнаас ялгагдах гол онцлог нь улс төрийн асуудлыг эрхлэн явуулдаггүй, хүлээн авагч улстай гэрээ хэлэлцээрийг Засгийн газрын түвшинд байгуулдаггүйд түүний онцлог нь оршино.

Түүнээс гадна консул нь Консулын харилцааны тухай 1963 оны конвенцид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, томилогч улсын иргэдэд паспорт, буцах үнэмлэх олгох, томилогч улсад зорчихыг хүссэн хумүүст виз буюу зохих бичиг баримт олгох; нотариатын үйлдэл хийх, иргэний байдлыг бүртгэх болон ийм төрлийн бусад үүрэг гүйцэтгэх; томилогч улсын харьяат насанд хүрээгүй буюу эрх зүйн бүрэн чадамжгүй бусад иргэдийн ашиг сонирхлыг ялангуяа тэднийг асран хамгаалах, харгалзан дэмжих; томилогч улсын харьяалал бухий хөлөг онгоц, тэр улсад бүртгэлтэй нисэх онгоц, түүнчлэн тэдгээрийн багийг томилогч улсын хууль, журамд заасан эрхийн дагуу хянаж, шалгах зэрэг үүргийг дурдаж болох юм.

Консулын газрын ажилтан

Консулын газрын ажилтан дипломат ажилтны адил дархан эрх, эрх ямба эдэлдэг бөгөөд үүнийг Консульш харилцаны тухай 1963 оны конвенцоор зохицуулсан байдаг. Энэхүү конвенцоор консулын байгууллага болон консулын албан тушаалтны эдлэх дархан эрх, эрх ямбыг тус тусад нь зааснаараа онцлогтой. Консулын байгууллагын дархан эрх, эрх ямбыг схемээр үзүүлэв.





Өргөмжит консул

Консулын харилцааны тухай Вений конвенц өргөмжит консулын статусыг зохицуулснаараа онцлогтой. Өргөмжит консул гэдэг нь консулын, эсхүл диломат буюу төрийн бусад алба хашдаггүй боловч өөрийг нь харьяалах улсын зөвшөөрснөөр томилогч улсын нэрийн өмнөөс консулын чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдийг хэлдэг. Өргөмжит консулыг голдуу улс төр бизнесийн хүрээний нэр хүнд бүхий этгээдүүдээс томилдог бөгөөд гүйцэтгэж буй үүргийнх төлөө томилогч улсаас цалин хөлс олгодоггүй. Өргөмжит консул үйл ажиллагаа консулын тойрог гэж түүнийг томилогч улсаас зөвшөөрч, өөрийн харьяат улстай зөвшөөрөлцсөн нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийг хэлнэ.

Өргөмжит консул томилогч улсыг сурталчлан таниулах үйл ажиллагааг идэвхтэй явуулахын зэрэгцээ худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан технологи, соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлээр ажиллана.

Томилогч улсын байгууллага, иргэдийн эрх ашгийг хамгаалах нь Өргөмжит консулын үндсэн үүрэг байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын 50 шахам өргөмжит консул дэлхийн гуч гаруй улсад үйл ажиллагаа явуулж байна.



Хяналтын асуулт

1. Консулын эрх зүйн онцлог, эх сурвалж, дипломатын эрх зүйгээс ялгагдах онцлогийг нэрлэнэ үү?
2. Консулын харилцааг яаж тогтоодог вэ?
3. Консулын патент, экзекватур гэж юу вэ?
4. Консулын албаи тушаалтны дархан эрх, эрх ямбын онцлогыг дурьдана уу?
5. Консул болон өргөмжит консулын ялгааг тодорхойлно уу?



Эх сурвалж

1. О.Хосбаяр. МДүгэрсүрэн. Олон улсын эрхзүй 171-174 х УБ.1999 он
2. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн тусгай дугаарын II боть, 420-448
3. Монгол Улсын Дипломат албаны тухай хууль. 2000 он

13. Хүний эрх



Нэр томъёо

Хүний эрхийн билль-хүний эрхийн салбар дахь үндсэн баримт бичгийг буюу 1948 оны Хүний эрхийн Түгээмэл тунхаглал, 1966 оны Иргэн, улс төрийн эрхийн болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пактыг хамааруулж ойлгодог.


Хүний эрхийн стандарт-дээрхи баримт бичгийн агуулга буюу хүний эрхийг хамгаалах талаархи олон улсын эрхзүйн хэм хэмжээ

Омбудсман-хүний эрхийн парламентын итгэмжлэгдсэн төлөөлөгч

Хүний эрхийг олон улсын түвшинд хамгаалахын ач холбогдол, хэрэгцээ

Тусгаар Тогтнолын тухай Америкийн Тунхаглал, Францын Хүн ба Иргэний эрхийн Тунхаглалаас хойш хүний үндсэн эрх, чөлөөг хүлээн зөвшөөрч, улсуудын Үндсэн хуулийн нэг институт болж төлөвшсөн. Дэлхийн II дайны үеэр хүний эрх бүдүүлгээр зөрчигдөн, олон сая хүний амь нас үрэгдсэн байна. 1945 онд НҮБ-ын Дүрэм батлагдсанаар хүний эрхийн салбар дахь улсуудын хамтын ажиллагааны эрхзүйн үндэс тавигдсан юм. НҮБ-ын Дүрмийн 1-р зүйлийн 3-д байгууллагын үндсэн зорилгын нэг нь "арьс үндэс, хүйс, шашин шүтлэгээр үл ялгаварлан хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг сайшаан хөгжүүлэх талаар олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх" хэмээн тусгасан. Орчин үеийн ОУНЭЗ-н үндсэн зарчмын нэг болох хүний эрхийг хүндэтгэх зарчим нь улс өөрийн захиргаанд байгаа бүх хүний эдэлбэл зохих эрхийг хүндэтгэн хэрэгжүүлэх талаар хүлээж буй үүргээр тодорхойлогдоно.

Хүний эрхийн ойлголт, ангилалт





Хүний эрхийн салбарт улс хоорондын хамтын ажиллагааны гол баримт бичиг. Хүний эрхийн олон улсын стандарт

НҮБ-ын Дүрэм	НҮБ Дүрэм хүний эрхийн салбар дахь хамтын ажиллагааны эрхзүйн үндсийг тавьсан. Дүрмийн 1.3, 55, 56, зүйлд тусгадаг.
Хүний эрхийн Түгээмэл тунхаглал	НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1948 оны 12-р сарьш 10-нд баталсан. Анх удаа иргэн, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлыг эрхийг багтаан, тодруулж стандарт тогтоосон байна.
Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт	Ерөнхий Ассамблей 1966 онд баталж, 1974 онд хүчин төгөлдөр болсон. Энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн иргэнийн буюу хувийн болон улс төрийн эрхийг хүндэтгэж, хангах үүргийг оролцогч улс хүлээдэг.
Иргэний болон улс төрийн эрхийн тухай пактын нэмэлт 1-р проткол	Иргэний ба улс төрийн эрхийн пактын заалтыг зөрчсөн тухай хувь хүний гомдлыг хэлэлцэх журмыг тусгасан.
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт	Ерөнхий Ассамблей 1966 онд баталж, 1974 онд хүчин төгөлдөр болсон. Энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхийн тулд бололцооны бүх арга хэмжээ авах үүргийг оролцогч улс хүлээдэг.
Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай тухай койвенци	1979 онд батлагдсан. Нийгмийн амьдралын бүх салбарт эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг устгах талаар бүхий л арга хэмжээг авах үүргийг хүлээсэн.
Хүүхдийн эрхийн тухай конвенци	1989 онд Ерөнхий Ассамблей баталсан. Хүүхдийн эдэлбэл зохих эрхийг дэлгэрэнгүй тусгаж, хүүхэд бүрийг асрамжлан хамагаалах эрх зүйн үндсийг олон улсын хэмжээнд баталгаажуулсан юм.

НҮБ байгуулагдсаны дараа НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн Зөвлөл 1946 онд өөрийн туслах байгууллага Хүний эрхийн Комиссыг байгуулж, түүнд олон улсыг баримт бичиг боловсруулах асуудлыг шилжүүлсэн. 1948 оны 12-р сарын 10-нд улс орны дэвшүүлсэн санал, үзэл бодол, байр суурийг удаа дараа хэлэлцсэний үр дүнд Хүний эрхийн Түгээмэл тунхаглалыг баталсан.

Хууль зүйн хүчин чадлын хувьд Түгээмэл Тунхаглал НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Зөвлөмжийн хэлбэрээр батлагдсан учир заавал биелэгдэх хууль зүйн шинжгүй билээ. Олон улсын эрх зүйд заншил үндсэн эх сурвалж болдог. Өөрөөр хэлбэл улсуудын практикт үүссэн горим, журам яваандаа эрх зүйн хэм хэмжээ гэж хүлээн зөвшөөрөгддөг. Түгээмэл тунхаглалын тусгагдсан үндсэн эрх, эрх чөлөө өнөөдөр ихэнхи улсад заавал биелэгдэх гэрээний хэм хэмжээ болсон юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей Түгээмэл тунхаглал баталж Эдийн Засаг Нийгмийн Зөвлөлөөр дамжуулан Хүний эрхийн комисст хүний эрхийн нэгдсэн баримт бичиг боловсруулах үүрэг өгсөн. 1951 оны 5-р чуулган дээр хүний эрхийн пактад эдийн засаг, нийгэм соёлыг эрхийг оруулах шийдвэр гаргасан. Гэвч АНУ зэрэг барууны улс эрс эсэргүүцэж байсан тул Ерөнхий Ассамблей шийдвэрээ эргэн харж 1952 онд хүний эрхийн 2 баримт бичиг гаргахаар шийдвэрлэсэн. Барууны улсуудын татгалзах гол үндэслэл нь эдийн засаг, нийгэм, соёлыг эрх тэдний Үндсэн хуулиас хальсан гланжтэй байсан. Ингээд 1966 оны 12-сарын 16-нд энэхүү 2 пакт батлагдсан.

Дээрхи баримт бичиг 1-үүд материаллаг байдлаар хүний эрхийг хангаж, хамгаалдаг гэж ойлгох нь өрөөсгөл бөгөөд зөвхөн улсад үүрэг хүлээлгэдэг.



Хяналтын асуулт

1. Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын хууль зүйн хүчин чадлыг хэрхэн үнэлэх вэ?
2. 1966 онд батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактад зааснаар хувь хүн хийгээд иргэний ямар эрхийг хязгаарлаж болохгүй вэ?
3. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактад улс гүрэн нэгдэн орсноор энэ пактад тусгагдсан эрхүүдийг яаж хэрэгжүүлэх вэ?



Эх сурвалж

1. М. Дүгэрсүрэн. 0. Хосбаяр. Олон улсын эрх зүй 101-116 х. УБ.1999 он
2. Монгол улсын Үндсэн хууль
3. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
4. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
5. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол
6. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
7. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
8. Хүүхдийн эрхийн тухай конвенц



14. Хүний эрхийг хамгаалах олон улсын механизм


Хүний эрхийг олон улсын түвшинд хамгаалахын ач холбогдол, хэрэгцээ шаардлага

Хүн төрөлхтний түүхийн хөгжлийн үе шат бүрд хүний эрх, эрх чөлөөний ойлголт, агуулга хэмжээ, хүрээ өөр байжээ. 20-р зууны дунд үе хүртэл хүний эрхийн асуудал улсын дотоод хэрэгт бүрэн хамаарч үндэсний эрх зүйгээр зохицуулагддаг байсан. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой бусад улсын дотоод хэрэгт оролцож болох үндэслэлийг онолын төвшинд хуульчид боловсруулсан байна. Харин зарим эрдэмтэд "хэрэв тухайн улс өөрийн иргэдийн эрх, чөлөөг хөндөж байвал түүнтэй аливаа харилцаагаа таслан зогсоох хэрэгтэй, харин түүний дотоод хэрэгт зэвсгийн хүчээр хөндлөнгөөс оролцох шаардлагагүй юм" гэж үзэж байв. Ингэж хүний эрхийг хамгаалах зорилготой зэвсгийн хүч хэрэглэх нь хөгжингүй буурай улс оронд өндөр хөгжилтэй орнуудаас нөлөөлөлдөө авахыг эрмэлзэх нэг үндэслэл болж байв.

Дэлхийн 1-р дайны дараа Үндэстний Зөвлөл байгуулагдснаар улс ийм нөхцөлөөр хүч хэрэглэхийг хориглоогүй боловч эрх хязгаартай болсон. Энэ үед тодорхой тооны улс хооронд боолчлол, боолын худалдаа, хүүхэд, эмэгтэйчүүдийн худалдааг таслан зогсоох, угсаатан, хэл, шашны цөөнхийг болон зэвсэгт мөргөлдөөний үед хүний эрхийг хамгаалах хэм хэмжээ агуулсан гэрээ, конвенци батлагдаж байв. Эдгээрийн зорилго зөвхөн хувь хүний зарим эрхийг хангахад чиглэсэн бөгөөд хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоог бүрдүүлж чадаагүй байв.


Дэлхийн 2-р дайны үед хүний эрхтэй холбоотой олон улсын эрх зүйн зохицуулалтад бодит дутагдалууд илэрсэн. НҮБ-ын Дүрэм хүний эрхийн талаархи улс орны хамтын ажиллагааны эх үндсийг тавьсан юм.

НҮБ хүний эрхийг хамгаалах гол механизм болох нь



1997 он хүртэл НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт хөтөлбөр боловсруулах, үндэсний байгууллагыг бэхжүүлэх, хууль тогтоомжийг шинэчилэх, хүний эрхийн мэргэжилтэн бэлтгэх, хүний эрхийн хэрэгжилт, төлөв байдлын талаар мэдээлэл авах чиг үүрэг бүхий Хүний эрхийн төв ажилладаг байсан. 1993 оноос НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний эрхийн Дээд Комиссарын албан тушаалыг бий болгож, Хүний эрхийн төвийн чиг үүргийг шилжүүлж авсан. 1970 оны 05-сарын 27-ны Эдийн Засаг, Нийгмийн Зөвлөлийн 1503 тоот тогтоолыг үндэслэж хувь хүний өргөдөл гомдлыг хүлээн авч пшидвэрлэдэг журам тогтсон.

Хүний эрхийн конвенцийн байгууллагууд



Хороо тухайн конвенцийн хэрэгжилтийг хянаж байхын тулд байгуулагддаг. Тэдний гишүүд улсын төлөөлөгч биш, ёс суртахууны өндөр чанартай, хүний эрхийн тухайн салбартаахүлээн зөвшөөрөгдсөн, мэргэшсэн байдаг. Гишүүдийг конвенцийн оролцогч улсууд өөрсдийн иргэдээс сонгох ба тэд гишүүн улсаас хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг. Хорооны гишүүдийг сонгохдоо газарзүйн тэгш хувиарлалт, олон соёлын хэлбэр, үндсэн эрх зүйн тогтолцооны төлөөлөлийг оруулах зарчмыг баримталдаг.



Хяналтын асуулт

1. Хүний эрхийг олон улсын хэмжээнд хамгаалахад нөлөөлсөн гол хүчин зүйл юу байсан бэ?
2. Олон улсын эрх зүйн үндсэн зарчим болох хүний эрхийг хүндэтгэх зарчмын хууль зүйн агуулгыг тодорхойлно уу?
3. Орчин үеийн олон улсын харилцаанд хүний эрхийн олон улсын хамгаалалтын байр суурь, ач холбогдолыг гаргана уу?
4. НҮБ-ын Ерөнхий Ассамблей хүний эрхийг хамгаалахад ямар чиг үүрэгтэй вэ?
5. Конвенцийн байгууллагуудын нийтлэг чиг үүргийг тодорхойлно уу?



Даалгавар:


1. С улс 1997 оны 12-р сард Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пактад нэгдэн оржээ. Ямар хугацаанд С улсын Засгийн газар, тайлангаа Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороонд хэрхэн гаргах вэ? Уг тайланд ямар асуудлыг заавал тусгасан байх шаардлагатай вэ?
2. Монгол улсын иргэн Б түүний Иргэн, улс төрийн эрхийн олон пактад тусгагдсан эрх зөрчигдөж байна гэж үзэж Хүний эрхийн хороонд хандах болжээ. Та түүнд ямар зөвлөгөө өгөх вэ?



Эх сурвалж

1. М. Дүгэрсүрэн, Ө. Хосбаяр. Олон улсын эрх зүй 101-113 х УБ.1999 он
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
4. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт I
5. протокол
6. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
7. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
8. Хүүхдийн эрхийн тухай конвенц


15. Олон улсын хүмүүнлэгийн эрхзүй



Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн ойлголт, тогтолцоо


Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй гэж зэвсэгт мөргөлдөөний үед дайн явуулах арга, хэрэгслийг хязгаарлах, түүнд хохирогчдыг хамгаалах болон эдгээрийг зөрчсөн тохиолдолд зохих хариуцагаа ногдуулах талаар улс хоорондын харилцааг зохицуулсан олон улсын эрх зүйн зарчим хэм хэмжээг хэлнэ.





Гаагийн тогтолцоо.

Дувдад зууны үеэс дайныг нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж байх ёстой гэж үзэж байсан. Дайны ажиллагааг эхлэх асуудлаар Гаагийн 1907 оны III конвенцид: урьдчилан тодорхой сануулахгүйгээр дайн өдөөх ёсгүй гэж заагаад тийнхүү зарлах хоёр хэлбэрийг тогтоосон:



Дайн зарласнаар эрх зүйн үүднээс дайны байдал үүснэ. Дайн эхэлснээр дайтагч талуудын хооронд энхийн харилцаа зогсож дипломат болон консулын харилцаа тасардаг бөгөөд дайтагч улсад шууд хамаарах хөрөнгө (дипломат болон консулын газрын төлөөлөгчийнхөөс бусад -ийг хураадаг. Байлдаан болж байгаа газрыг дайны талбар гэж нэрлэдэг. Дайн эхэлснээр дайтаж байгаа улсуудын хоорондын гэрээ хэлэлцээрийн үйлчлэлд нөлөө үзүүлдэг боловч олон талт гэрээний хувьд тэдгээр улсын хувьд бүр мөсөн зогсоно гэж үздэггүй. Дайтаж байгаа улс, түүний иргэдийн эрх ашгийг нөгөө дайтаж байгаа улсад төлөөлөх ажлыг уг талуудтай дипломат харилцаатай гурав дахь улс гүйцэтгэж болдог бөгөөд үүнийг голцуу төвийг сахисан улс гүйцэтгэдэг. Орчин үед дайн өдөөх нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчиж гэмт хэрэг үйлдсэнд тооцдог.



Женевийн тогтолцоо.

Дайны буюу зэвсэгт мөргөлдөөний үед хүмүүнлэг ёсыг баримтлах үзэгдэл ХК зуунд олон оронд үйл ажиллагаа явуулж эхэлсэн нийгмийн хөдөлгөөнтэй салшгүй холбоотой., Австри-Итали- Францын хооронд 1859 онд болсон дайны үеэр Сольферинод болсон тулалдааны дараа Швейцарийн иргэн Анри Дюнан шархадагсдад зориулсан тусламжийг зохион байгуулж "Сольфериногийн тухай дурдатгал" ном бичсэн нь олон хүний сэтгэл хөдөлгөжээ. Ийнхүү Женев хотноо 1863 онд шархадагсдад зориулсан олон улсын хороо байгуулсан нь өнөөдрийн Олон улсын улаан загалмайн хороо (ОУУЗХ) бөгөөд АДюнанаас гадна Женевийн иргэн Муанье, тенерал Дюфур, эмч Аппиа, Монуар нар нэгдэцгээсэн. ОУУЗХ нь Засгийн газрын бус төвийг сахисан Швейцарийн байгууллага юм. Байгууллагын гол зорилго нь дайны хохирогчдод Женевийн конвенцууд болон түүний протоколуудын дагуу тусламж үзүүлэх юм.

Женевийн конвенцууд нь дайнд дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээг зэвсэгт мөргөлдөөнд хамааруулахаар заасан нь шинэлэг зүйл юм.



Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч бие бүрэлдэхүүн

Байлдагч (combatant)

Мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчинд захирагдаж буй хүний удирдлагын дор байгаа зохион байгуулалттай зэвсэгт хүчин, бүлэг болон нэгжүүд.

Байлдагч бус (non combatant)

дайнд олзлогдогч, шархтан, өвчтөн, түүнчлэн зэвсэгт хүчний бүтцэд хамаардаг боловч байлдааны ажиллагаанд шууд оролцдоггүй бүрэлдэхүүн-эмнэлэг болон хангамжийн ажилтнууд, цэргийн хуульч, лам.

Дайны ажиллагаанд хориглосон арга,хэрэгсэл

Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай конвенц

Байгаль орчинд нөлөөлөх арга хэрэгслийг цэрэг дайны болон дайсагнах бусад аливаа зорилгоор ашиглахыг хориглох тухай конвенц

Амьсгал боогдуулагч,хортой буюу тэдгээртэй ижил бусад хий болон бактериологийн хэрэгслийг дайнд хэрэглэхийг хориглох тухай протокол

Үлэмж хохирол учруулах буюу нэлд нь хөнөөх чанартайд тооцогдох тодорхой төрлийн ердийн зэвсэг хэрэглэхийг хориглох буюу хязгаарлах тухай конвенци

Бактериологийн биологийн болон токсин зэвсэг болов сруулах,үйлдвэрлэх,нөөцлөхийг хориглох болон тэдгээрийг устгах тухай конвенци

Илрүүлэх боломжгүй хэлтэрхийн тухай протокол 1-протокол

Мина,урхин мина болон бусад төхөөрөмж хэрэглэхийг хориглох буюу хязгаарлах тухай протокол 2-протокол

Шатаах зэвсгийг хэрэглэхийг хориглох буюу хязгаарлах тухай протокол 3-протокол

Нүд сохлогч лазерийн зэвсгийн тухай протокол 4-протокол

Химийн зэвсгийг боловсруулах,үйлдвэрлэх,нөөцлөх болон хэрэглэхийг хориглох,түүнийг устгах тухай конвенци

Монгол улс Женевийн 4 конвенцид нэгдэн орохоос гадна, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зарим гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурж, нэгдэн орсон билээ. Мөн түүнчлэн Эрүүгийн хуульдаа зохих заалтыг оруулж өгсөн.



Хяналтын асуулт

1. Монгол улс олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэхийг дээрхи конвенцээр тайлбарлана уу?
2. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн талаар ямар заалт Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан байдаг вэ?
3. Зэвсэгт мөргөлдөөний үе дэх Олон улсын нийтийн эрх зүйн үндсэн зарчмыг тодорхойлно уу?
4. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг тодорхойлно уу?
5. Дайн явуулах ямар хориглосон арга, хэрэгсэл байдаг вэ? Хориглох шалтгаан юунд орших вэ?
6. Дайнд оролцогч гэж хэнийг хэлэх вэ? Энэ этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлно уу?
7. Цэргийн олзлогдогчид үл хамаарах этгээдийн эрх зүйн статусыг тодорхойлно уу?



Бодлого

Японы генерал Ямашито Филиппиний газар нутагт байлдааны ажиллагаа явуулж байхдаа хүмүүнлэгийн эрх зүйн дүрэм, заншлыг зөрчсөн гэж буруутгагджээ. Ямашитог 1944 оны 10 дугаар сарын 9-өөс 1945 оны 9 дүгээр сарын 2-ны хооронд Филиппин дэх Японы армийн бүрэлдэхүүнийг удирдаж байх хугацаанд түүний удирдлага дор алба хааж байсан офицер, цэргүүд АНУ, түүний холбоотон улсын болон Филиппиний иргэд, олзлогсдын эсрэг эрүү шүүлт, хүчирхийллийн гэмт хэрэг хийсэн хэмээжээ. Ямашитогийн гомдлыг АНУ-ын дээд шүүх хүлээж авсан байна.

- a. Ямашито өөрөө эрүүдэн шүүлт, хэрцгийллийг гардан үйлдээгүй гэж үзвэл энэ гэмт хэрэгт буруутгагдаж болохуу?*
- b. Энэ нь АНУ-ын дээд шүүхэд харьяаагдах хэрэг төн үү?*




Эх сурвалж

1. МДүгэрсүрэн. О.Хосбаяр. Олон улсын эрхзүй, 295-312 х УБ.1999 он.
2. НҮБ-ын дүрэм, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн тусгай дугаарын II боть,
3. Төрийн мэдээлэл" эмхтгэлийн тусгай дугаарын V боть,
4. Төрийн мэдээлэл" эмхтгэлийн тусгай дугаарын VI боть,



16. Олон улсын эрүүгийн эрх зүй


Гэмт хэрэгтэй тэмцэх улс орнуудын хамтын ажиллагааны түвшин, арга хэлбэр нь тухайн гэмт хэрэг олон улсын хамтын нийгэмлэгийн ашиг сонирхлыг аль хэр хөндөж байгаагаар тодорхойлогдоно. Энэ үүднээс авч үзвэл:



Олон улсын эрүүгийн гэмт хэрэг буюу хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг харъяалан шийдвэрлэх Олон улсын эрүүгийн шүүхийг 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон Ромын дүрмээр байгуулсан. Энэ нь олон улсын хамтын нийгэмлэгийн сэтгэлийг түгшээсэн, энэхүү Дүрэмд дурдсан хамгийн ноцтой гэмт хэргийн төлөө хариуцлага хүлээх ёстой этгээдийн хувьд хэргийг нь шүүн шийдвэрлэх эрх бүхий байнгын байгууллага бөгөөд эрүүгийн шүүн таслах үндэсний шүүх эрх мэдэлд нэмэлт хөшүүрэг болно. Шүүхээс хэрэг шүүн шийдвэрлэх болон гүйцэтгэх үүргийг энэхүү Дүрмийн заалтаар зохицуулна.

Шүүх нь олон улсын эрх зүйн чадамжтай байх бөгөөд өөрийн чиг үүрэг болон зорилгыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм эрх зүйн чадвартай байна.

Шүүх өөрийн чиг үүрэг болон бүрэн эрхийг Дүрэмд заасны дагуу оролцогч аливаа улсын нутаг дэвсгэр дээр болон тусгай хэлэлцээрийн дагуу аливаа бусад улсын нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлж болох онцгой эрх хэмжээтэй.



Төрлөөр устгах гэмт хэрэг: ямар нэгэн үндэс угсаа, арьсны өнгө болон шашин шүтлэг нэгтгэйнх нь хувьд тийм бүлэг хүнийг бүхэлд нь буюу хэсгийг нь устгах зорилгоор үйлдсэн дараахь үйлдлийн аль нэгийг хэлнэ: а/ тийм бүлгийн гишүүдийг алах, б/ тийм бүлгийн гишүүдийн бие махбодид нотцой гэмтэл учруулах буюу оюун ухааныг сарниулах, в/ тийм бүлгийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь устгахад чиглэсэн амьдралын нөхцлийг санаатай бий болгох, г/ тийм бүлгийн төрөлтийг зогсооход чиглэсэн арга хэмжээ авах, д/ хүүхдийг нэг бүлгээс нөгөөд хүчээр шилжүүлэх.

Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг: энгийн аливаа хүмүүст өргөн хүрээтэй буюу байнга халдах байдлаар санаатай үйлдэж байгаа дараах үйлдлийн аль нэг болно: а/ алах, б/ устгах, в/ боолчлох, г/ хүн амыг албадан гаргах буюу хүчээр шилжүүлэх, д/ шоронд хорих буюу бусад байдлаар олон улсын эрх зүйн үндсэн хэм хэмжээг зөрчих замаар хүний бие махбодийн эрх чөлөөг харгис, хэрцгийгээр хасах, е/ эрүүдэн шүүх, ё/ хүчиндэх, бэлгийн боолчлолд оруулах, биеэ үнэлэлтэд тулган хавчих зэрэг Эрүүгийн шүүхийн дүрэмд заасан бусад үйлдэл.


Цэргийн гэмт хэрэг: а/ Женевийн 1949 оны 8 дугаар сарын 12-ны Конвенцийн ноцтой зөрчил, ялангуяа Женевийн холбогдох Конвенцийн заалтын дагуу хамгаалагдвал зохих хүмүүс буюу эд хөрөнгийн эсрэг үйлдсэн дараах үйлдлийн аль нэг: Тухайлбал, санаатай алах, эрүү шүүлт тулгах буюу биологийн туршилт хийх зэргээр хунлэг бус харьцах, хүмүүсийг барьцаанд авах, түүнчлэн б/ олон улсын эрх зүйтр тогтсон олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэх хууль болон зан заншлыг өөрөөр ноцтой зөрчсөн, ялангуяа дайны ажиллагаанд шууд оролцдоггүй энгийн хүн ам буюу энгийн тодорхой хүмүүст санаатайгаар халдан довтлох, иргэний байгууламж, өөрөөр хэлбэл цэргийн зориулалтгүй байгууламжид санаатайгаар халдан довтлох зэрэг Эрүүгийн шүүхийн дүрэмд заасан бусад үйлдэл.

Түрэмгийллийн гэмт хэрэг: уг гэмт хэргийн хувьд энэ гэмт хэргийг шүүн шийдвэрлэх талаар энэ гэмт хэргийн тодорхойлолт болон зохих нөхцлийг агуулсан заалтыг дараа жич гаргахаар Дүрэмд тусгасан.

Олон улсын Эрүүгийн шүүхийн дүрмээр түүнд заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд авах арга хэмжээний талаар мөн тусгасан хэдий ч гэм буруутай нь нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутайд тооцохгүй байх зарчмыг тусгаснаараа онцлогтой.



NE BIS IN IDEM



Олон улсын эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмууд

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмээр Олон улсын эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмуудыг тодорхойлсон. Үүнд:

Зарчмууд



Зарчмын агуулга:

- > Гэмт хэргийг яв цав нарийн тодорхойлох
- > Гэм буруутайг шүүх тогтоож ял оногдуулах
- > Дүрэм буцаж үйлчлэхгүй байх
- > Гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдийг нэг бүрчлэн хариуцлага хүлээлгэх

- > Шүүхэд харъяалагдах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байх
- > Санаатай болон зориуд гэмт хэрэг үйлдсэний төлөө эрүүгийн хариуцлага болон ял оногдуулах
- > Сэтгэцийн өвчин буюу сарнилт нь хууль зөрчсөн байдлыг ухамсарлах буюу өөрийн зан үйлийн шинж чанар, өөрийн үйлдлийг хуулийн шаардлагад нийцүүлэх боломжийг алдагдуулсан
- > Бодит байдлын алдаа нь тухайн гэмт хэргийн заавал байх шаардлагатай субъектив талыг үгүйсгэсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болно



Хяналтын асуулт

1. Олон улсын гэмт хэргийн болон олон улсын пшнжтэй гэмт хэргийн пшнжийг тодорхойлно уу?
2. Олон улсын гэмт хэргийн төрөл, бүрэлдэхүүнийг тодорхойлно уу?
3. Олон улсын эрүүгийн эрх зүйн нийтлэг зарчмуудыг тодорхойлно уу?
4. Олон улсын шинжтэй гэмт хэргийн үндсэн төрлийг тодорхойлно уу?



Бодлого

Монгол Улсын Засгийн газар АНУ-ын Засгийн газартай 2003 оны 6 дугаар сарын 9-нд гэрээ байгуулжээ. Уг гэрээ ёсоор АНУ-ын зэвсэгт хүчинд алба хааж буй болон АНУ-ын зарим иргэдийг Олон улсын эрүүгийн шүүхийн өмнө аливаа хариуцлагаас чөлөөлөх зорилготой ажээ. Харин Монгол Улсын "Олон улсын эрүүгийн түүхийг дэмжих үндэсний эвсэл" нь Монгол Улсын Үндсэн хууль, монгол Улсын Олон улсын гэрээний тухай хууль, Олон улсын эрүүгийн шүүхийн дүрэм, Олон улсын гэрээний тухай Венийн конвенц зэргийг Монгол Улсын Засгийн газар зөрчиж байна гэж үзжээ.

- a. Уг гэрээ олон улсын эрх зүйн зарчимтай нийцэж байгаа юу?*
- b. Олон улсын эрүүгийн эрх зүйн зарчим гэж юу вэ?*
- c. Олон улсын эрүүгийн эрх зүй болон үндэсний эрх зүй хоорондоо хамааралтай юу?*



Эх сурвалж


1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. М.Дүгэрсүрэн. О.Хосбаяр. Олон улсын эрхзүй. 313-327 х. УБ.1999 он.
3. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн тусгай дугаарын II боть, 319-405



17. Олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх асуудал

Үндэсний хууль тогтоомжид хариитахаас гадна улс орны хоорондын хэв ёсны харилцааг хөндөн, хамтын ажиллагаанд ямар нэгэн хэмжээгээр хор хохирол учруулдаг гэмт үйлдлийг олон улсын шинжтэй гэмт хэрэг гэж өмнөх хэсэгт тодорхойлсон билээ. Улс орнууд хоорондоо гэрээ хэлэлцээр байгуулах, олон талт гэрээ конвенцийн заалтуудыг үндэснийхээ хууль тогтоомжид тусгах замаар уг төрлийн гэмт хэрэгтэй тэмцдэг.

Олон улсын шинжтэй гэмт хэргийг терроризмын эсрэг гэмт хэрэг болон бусад төрлийн гэмт хэрэг гэж хоёр ангилан үзэж болох юм.



Терроризм

Терроризмын тухай олон орны эрдэмтдийн бүтээсэн ном зохиолуудад 150 орчим ойлголт байгаа боловч нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй байгаа нь түүний зорилго, шинж чанар, онцлог, арга хэлбэр, шалтгааныг өөрөөр тодорхойлж, тайлбарлаж байгаатай холбоотой юм. Терроризмын тухай тодорхойлолт боловсруулах зорилгоор НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1970 оны эхээр тусгай хороо байгуулж уг асуудлаар нэлээд маргалдсан бөгөөд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг терроризмтой адилтгаж үзэхийг Хорооны олонх гишүүн эсэргүүцсээр оноог хүрчээ.

Терроризмтой тэмцэх тухай Монгол Улсын хуульд: "Терроризм" гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагааг; "Олон улсын терроризм" гэж олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хяналт, удирдлагад нөлөөлөх зорилго бүхий улс дамжсан терроризмыг" тус тус хэлнэ гэж заажээ.

Олон улсын түвшинд терроризмын талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй ч НҮБ-аас баталсан 13 конвенцийн хүрээнд террорист үйлдлийг тодорхойлох хандлага өргөн дэлгэрсэн. Эдгээр конвенцийн гол ач холбогдол нь түүнд дурдсан гэмт хэргийг оролцогч улс бүр гэмт хэрэг гэж үзэн дотоодын эрүүгийн хууль тогтоомждоо тусгах явдал юм.

Терроризмын эсрэг олон улсын түгээмэл
конценцууд

Агаарын хөлгийг хууль бусаар булаан авар
үйлдлийг хориглох тухай конвенц

Иргэний нийсэхийн аюулгүй байдлын эсрэг
хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц

Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс, түүний
дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс
урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенц

Агаарыш хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг
болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц

Хүн барьцаанд авахын эсрэг олон улсын,
конвенц

Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх
буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг
хориглох тухай нэмэлт протокол

Хуванцар тэсрэх бодис илрүүлэх зорилгоор
тэмдэг тавих тухай конвенц

Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхийг
хориглох тухай олон улсын конвенц

Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай
олон улсын конвенц

Далайн навигацын аюулгүй байдлын эсрэг
хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц

Эх газрын хормойд байрлуулсан суурилуулах
төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус
үйлдлийг хориглох тухай протокол

Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай
олон улсын конвенц



Олон улсын шинжтэй бусад гэмт хэрэг

Энэ бүлэгт олон улсын терроризмд хамаарах конвенцид зааснаас бусад төрлийн гэмт хэрэг хамааруулна. Тухайлбал, боолчлол, боолын худалдаатай тэмцэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, авилгын гэмт хэрэг, мансууруулах бодисын хууль бус наймаа, хүн худалдаалах зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх асуудал үүнд хамаарна. Үүнд:

Олон улсын шинжтэй бусад гэмт хэрэг

Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц

Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, зантлыг усгах тухай нэмэлт конвенц

Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц

Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх

Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц

Авилгалын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц

Хүн, ялашуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол

Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар буюу агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол

Галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протокол

Эдгээр конвенцид тусгагдсан гэмт хэргийг таслан зогсоох талаар хамтарч ажиллах, харилцан туслалцах нь улс бүрийн хувьд авч хэрэгжүүлэх чухал арга хэмжээ юм.

Олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх улс орнуудын хамтын ажиллагаа хоёр буюу олон талт хэлэлцээрт үндэслэгдэн дараахь чиглэлээр явагддаг:



Гэмт хэрэгтэн буюу сэжштэн этгээд нутаг дэвсгэр дээр нь байгаа улс тухайн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах буюу ял шийтгэл ногдуулах зорилгоор харьяалах улсад нь буюу нутаг дэвсгэр дээр нь гэмт хэрэг үйлдсэн улсад, эсхүл гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн улсад тэдгээрийн шаардлагаар шилжүүлж өгөхийг гэмт хэрэгтнийг шилжүүлэх буюу экстрадиц гэнэ. Гэмт хэргийг шилжүүлэх асуудлыг улс орнууд хоорондоо байгуулсан гэрээ хэлэлцээрээр, эсхүл нэгдэж орсон олон талт конвенцийн хүрээнд шийдвэрлэдэг. Гэхдээ ямар нэгэн этгээдийг арьсны өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, улс төрийн итгэл үнэмшлийн шалтгаанаар мөрдөн шийтгэхийн тулд шилжүүлж өгөхийг шаардаж байна гэж үзэх баттай үндэслэл хүлээн авсан талд байгаа бол уг этгээдийг шилжүүлж өгдөггүй.

Цагдаагийн олон улсын байгууллага (Интерпол).

Вена хотноо 1923 онд хуралдсан Цагдаагийн олон улсын бага хурлаас Олон улсын эрүүгийн цагдаагийн хороог байгуулж, түүний дүрмийг баталжээ. Гэвч уг дүрэм, түүний заалтууд нь тухайн үеийн нөхцөл байдалд төдийлөн нийцэхгүй байсан тул Хорооны гишүүд байгууллагын шинэ дүрмийг хэлэлцэн 1956 онд Вена хотноо баталсан. Энэхүү шинэ дүрмээр Цагдаагийн олон улсын байгууллага (ИНТЕРПОЛ)г байгуулсан. Интерполын гол зорилго нь эрүүгийн цагдаагийн үндэсний байгууллагуудын харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох талаар хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.



Тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэл нь "олон улсын гэмт хэрэгтнүүдийн" талаархи мэдээллийг бүртгэх, хадгалах, тухайлбал, Интерполд өнөөгийн байдлаар 600 гаруй террорист байгууллагын талаархи мэдээлэл хадгалагдаж байгаа бөгөөд түүнчлэн гэмт хэрэгтнүүд, сураггүй болсон этгээдүүд хулгайд алдсан өмч хөрөнгийг олон улсын хэмжээнд эрж хайх явдал юм. Энэхүү байгууллага нь 1982 онд засгийн газрын бус байгууллагаас засгийн газар хоорондын байгууллагын статустай болсон.

Интерполын бүтэц нь ерөнхий Ассамблей, Гүйцэтгэх зөвлөл, Ерөнхий нарийн бичгийн дарга, Үндэсний төв товчоо, зөвлөхүүдийн багаас бүрддэг.



Хяналтын асуулт

1. Олон улсын терроризм болон олон улсын шинжтэй гэмт хэргийн шинжийг тодорхойлно уу?
2. Олон улсын шинжтэй гэмт хэргийн үндсэн төрлийг тодорхойлно уу?
3. Гэмт хэрэгтэнг шилжүүлэн өгөхөд харилцан адил нөхцөл олгох зарчмыг тайлбарлана уу?
4. Цагдаагийн олон улсын байгууллагын зорилгыг тодорхойлно уу?



Даалгавар:

1. Сингапурт 1994 оны 9 дүгээр сарын 23-нд хар тамхи наймаалсан хэргээр Голландын бизнесмен Иоханнес Ван Даммыг цаазаар авчээ. 1991 онд Сингапурын нисэх онгоцны буудалд баригдсан 59 настай Ван Дамм нь 4,32 кг цэвэр героин хууль бусаар Сингапурт оруулж ирсэн гэсэн хэрэгт сэжиглэгдсэн юм. Сингапурын ерөнхийлөгчөөс Голландын хатан хаан Беатрикс ВанДаммыг өршөөх тухай өөрөө гуйсан байна. Мөн Дэлхийн сүм, хийдийн зөвлөл, Олон улсын эмнести байгууллага Ван Даммын ялыг хөнгөрүүлэх хүсэлт тавьсан байна. Хэдэн зуун Голландчууд Сингапурын Засгийн газарт амь насыг нь үлдээж өгөөч гэсэн хүсэлттэй захидал илгээжээ. Голландын сум хийдийн хэргийн сайд биечлэн Сингапурт хүрэлцэн ирж Ван Даммыг эргэсэн байна. Ялыг өөрчлөх бүх арга хэмжээг Сингапурт суугаа Голландын элчин сайд авсан боловч үр дүнд хүрсэшуй. Сингапурын хуулиар цагдаа таны болон сэжигтний халааснаас 15 грамм героин олсон уу, эсхүл 500 гр конопля (conopis) олсон уу ямар ч тохиолдолд ялын дээд хэмжээг оногдуулдаг байна. Уг хууль 1975 онд хүчин төгөлдөр болсноос хойш 80 орчим хүнийг цаазаар авсан байна. Тэдгээрийн тал хувь нь гадаадын иргэн байжээ. Шүүх хуралдаан дээр Ван Дамм героин авч явсанаа мэдээгүй ялыг хэрэгжүүлэхээс хэдхэн хоногийн өмнө Голландын тусгай алба Ван Даммыг хар тамхины наймааны сүлжээг илрүүлэх ажиллагаанд өгөөш болгон ашиглаж байсан гэж мэдэгдсэн байна.

- а. Мансууруулах болон сэтгэхүйд хүчтэй нөлөөлөх бодистой холбоотой хууль бус ажиллагаа гэдэгт юуг ойлгох вэ?*
- б. Уг асуудлаар 1961 оны Мансууруулах бодисын тухай конвенцийн үндсэн дээр ятар хяналтын механизм бий болсон бэ?*
- с. 2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуульд уг асуудлаар ямар зохицуулалт байдаг вэ?*



Эх сурвалж

1. М.Дүгэрсүрэн. 0.Хосбаяр. Олон улсын эрх зүй 313-327 х. УБ.1999 он.
2. Төрийн мэдээлэл" эмхтгэлийн тусгай дугаарын IV боть,
3. Ч.Баатар "Терроризм, аюулгүй байдал" Уланбаатар 2006 он.
4. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 он



18. Олон улсын эдийн засгийн эрх зүй



Нэр томъёо

Үндэсний дэглэм- улс гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн харилцаанд өөрийн иргэд болон хуулийн этгээдтэй тэгш эрх, бололцоо олгохоор харилцан тохиролцох,

Үлэмж найр тавих -аливаа улсад гуравдагч улсад хэрэглэдэг, цаашид хэрэглэж болох хамгийн таатай нөхцлийг олгох үүрэг хүлээх,

Онцгой дэглэм- улсууд гааль, худалдааны журмын талаар харилцан бие биедээ тусгайлсан хөнгөлөлт үзүүлэх,

Үндэстэн дамнасан корпораци-үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний ажиллагааг олон салбарт явуулдаг хуулийн этгээдүүдийн нэгтгэл юм.

Олон улсын эдийн засгийн эрх зүйн ойлголт, эх сурвалж

Худалдаа, эдийн засгийн харилцаа нь улс хоорондын харилцааны үндсэн бүрэлдэхүүн, материаллаг үндэс нь болдог. Аливаа улсын хөгжилийн гадаад таатай орчинг бүрдүүлэх нь түүний хөгжих үндэс болдог. Улсуудын өөрийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн эдийн засгийн харилцан ажиллагааны асуудлууд олон улсын эдийн засгийн эрх зүйн зохицуулах зүйл нь юм. **Улсууд болон ОУНЭЗ-н бусад субъектын олон улсын эдийн засгийн харилцааг зохицуулдаг зарчим хэм хэмжээний нийлбэр цогцыг олон улсын эдийн засгийн эрх зүй** гэнэ. Олон улсын эдийн засгийн эрх зүйгээр зохицуулагдах харилцаа цогц шинжтэй ба дараахи онцлогтой байдаг. Үүнд:


> Олон улсын нийтийн эрх зүй ба олон улсын хувийн эрх зүйн харилцаа нягт сүлэлддэг. Өөрөөр хэлбэл нийтийн эрх зүйн субъектүүд бааз, суурь гэрээг байгуулж, түүнийг үндэслэж иргэн, хуулийн этгээдүүд хоорондоо иргэний эрх зүйн шинжтэй гэрээ хэлцэл байгуулдаг.

> Энэ салбарт олон улсын нийтийн эрх зүй үндэсний эрх зүй илүү харилцан үйлчлэлддэг онцлогтой. Байгуулсан бааз, суурь олон улсын гэрээ шууд зохицуулалт хийхгүй, харин үндэсний эрх зүйд гарээний зохицуулалт заавал тусгагддаг онцлогтой.

Олон улсын эдийн засгийн эрх зүйн эх сурвалжийн цөмийг олон талт гэрээнүүд бүрдүүлдэг. Орчин үед ийм олон талын харилцаа өргөжиж буй боловч тодорхой улсын хооронд тодорхой салбарын харилцааг зохицуулдаг 2 талт гэрээ чухал ач холбогдолтой.


Худалдааны харилцаанд баримталж ирсэн заншил чухал үүрэг гүйцэтгэдэг ба Орчин үед зорилго агуулгын хувьд Шинэ нөхцөл байдалд нийцэн өөрчлөгдөх хэлбэрийн хувьд гэрээний хэм хэмжээ болох үйл явц эрчимтэй явагдаж байгаа юм.

ОУБ-ын тогтоол, зөвлөмж заавал биелэгдэх хүчингүй хэмээн тооцогддог боловч дийлэнхийн хүсэл зориг, зөвшилцөлд тулгуурладаг учир олон улсын эдийн засгийн эрх зүйн зарчим, хэм хэмжээг нотлох, бататгахад чухал үүрэгтэй байдаг.



Олон улсын эдийн засгийн эрх зүйн зарчим


ОУЭЗ-н үндсэн зарчим нь эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалтын үндэс суурь болдог. Үндсэн зарчмаас гадна эдийн засаг, худалдааны харилцаанд хамаарах салбарын зарчим үйлчилдэг. Үүнд:





Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны зарим салбарын эрх зүйн зохицуулалт

Олон улсын эдийн засгийн эрх зүйн харилцааны үндсийг олон улсын худалдаа бүрдүүлэх ба тээвэрлэлт, төлбөр тооцоо, зээл, санхүү, даатгалын зэрэг бусад харилцаа ямар нэг байдлаар түүнтэй холбоотой байдаг.



Дэлхийн эдийн засгийн даяарчилал, олон улсын худалдааны хурдацтай хөгжлийн шаардлагаар 1947 онд Тариф худалдааны Ерөнхий хэлэлцээр /ТХЕХ/ байгуулагдсан. Худалдааны олон талт хэлэлцээр байгуулах замаар олон улсын худалдааны эрх зүйн хэм хэмжээ, журам тогтоох нь түүний зорилго байв.

1986-1993 оны Уругвайн үе шатны Төгсгөлд 1994 оны 04-р сарын 15-нд Марокко улсын Марракеш хотод байгуулсан хэлэлцээрээр Дэлхийн худалдааны байгууллагыг байгуулсан байдаг. ДХБ хүн амын амьдралын төвшин, орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг багасгах, бараа, үйлчилгээний худалдаа, үйлдвэрлэлийн өсөлтийг нэмэгдүүлэх, хүн төрөлхтний нөөц, баялагыг зохистой ашиглах явдлыг хангахыг зорилгоороо тодорхойлсон байдаг.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд олон улсын худалдаанд ялгаварлах явдлыг арилгах, худалдааны өндөр тариф болон бусад саадыг бууруулах, худалдааг харилцан ашигтай болгох системийг бий болгох зорилтыг дэвшүүлсэн байна.



Даалгавар:

1. Монгол улс Дэлхийн Худалдааны байгууллагын гишүүнээр 1996 онд элсэн орсон юм. Энэ нь манай улсын эдийн засаг, худалдаа, техник, технологи, хөрөнгө оруулалтын салбарт ямар эерэг таатай орчин, нөхцлийг бүрдүүлж болох вэ?

2. Олон улсын эдийн засгийн эрх зүйн нийтлэг зарчмын агуулгыг судлан, олон улсын худалдаанд Монгол улсын эзлэх байр суурь, гадаад худалдааны бодлогод дүн шинжилгээ хийнэ үү?
3. Дэлхийн худалдааны байгууллага өөрийн Дүрэмийн зорилго, чиг үүрэгээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаа хэвийн явуулахад шаардлагатай дотоод бүтцийн байгууллагуудтай билээ. Дэлхийн худалдааны байгууллагын бүтэц, эрх хэмжээ, үйл ажиллагааны хүрээгээр бүдүүвч хийнэ үү.



Эх сурвалж

1. М. Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. 247-267 х. УБ., 1999 он
2. Монгол Улсын Аюулгүй байдлын үзэл баримтлал 1994 он.



Хяналтын асуулт

1. Олон улсын эдийн засгийн эрх зүйн эх сурвалжийн тэдний онцлог шинжийг тодорхойлно уу?
2. Олон улсын эдийн засгийн эрх зүйг тодорхойлж, олон улсын эрх зүйн бусад салбараас ямар онцлогтой вэ?
3. Олон улсын эдийн засгийн эрх зүйн салбарын зарчмыг нэрлэж, хууль зүйн агуулгыг тодорхойлно уу?
4. Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийг байгуулах ямар шаардлага байсан бэ?
5. Дэлхийн худалдааны байгууллагын зорилго, чиг үүргийг тодорхойлно уу?



19. Олон улсын аюулгүй байдлын эрх зүй

Олон улсын энх тайван аюулгүй байдал.

Олон улсын харилцаанд нийтийн энх тайвныг зөрчихгүй, улс түмний аюулгүй байдалд заналхийлэл учруулахгүй нөхцөл бүрэлдсэн байхыг олон улсын аюулгүй байдал гэнэ.

Орос улсын санаачилгаар Гаага хотноо 1899 онд болсон олон улсын хурал анх удаа энх тайвны асуудал хэлэлцэж түүнийг зэвсэг хураах шаардлагатай холбон тавьсан. Олон улсын харилцаанд хүч хэрэглэх, дайн өдөөхийг хязгаарлан хориглох үзэл баримтлал, хэм хэмжээг нэвтрүүлэхэд Бриан-Келлогийн 1928 оны пакт, түүнчлэн Үндэстнүүдийн Холбооны дүрэм зохих үүрэг гүйцэтгэсэн. XX зууны дунд үеэс Нэгдсэн Үндэстний Байгууллага үүсч, түүний Дүрмийн зорилго, зарчим хэрэгжиж эхэлснээр олон улсын энх тайван, аюулгүй байдлын үзэл баримтлалд үндсэн өөрчлөлт орсон.

Тогтвортой хөгжлийг хангах олон төрлийн нөхцөлийг хооронд нь бүх талын уялдаатай авч үзэхийг аюулгүй байдлыг цогцоор нь, иж бүрнээр нь хангах үзэл баримтлал (comprehensive security) гэж нэрлэдэг. Энэхүү үзэл баримтлалын онцлог нь улс орнууд үлдэснийхээ ашиг тусыг эрхэмлэхийн хамт хүн төрөлхтний үнэт зүйлс, ашиг сонирхлыг харгалзах хэм хэмжээг бататгахад чиглэгдэж байна.

Энхтайваны тогтолцоог бүрдүүлдэг
улс гүрний аюулгүй байдал нь:

Хүний эрхийг хангах

Эдийн засаг, нийгмийн хөгжлийг
бэхжүүлэх

Нийгмийн амьдралд ардчиллыг
бэхжүүлэх


Хүрээлэн буй орчныг хамгаалах

Олон улсын хамтын ажиллагааг
хөгжүүлэх

Бүх талын аюулгүй байдлыг олон улсын түвшинд улс орнуудын зохицол хамтын ажиллагаагаар л бий болгох бөгөөд үүнийг хамтын аюулгүй байдал буюу cooperative security гэж нэрлэх болсон.


ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ТУСГАЙ АНГИ






Олон улсын энх тайвны үндсийг НҮБ-ын дүрэмд тодорхойлсон бөгөөд аюулгүй байдлыг сахин хамгаалах үүргийг Ерөнхий Ассамблей болон Аюулгүйн Зөвлөл хэрэгжүүлдэг. Ерөнхий Ассамблей аюулгүй байдлыг сахин хамгаалахтай холбоотой бүх асуудлыг хэлэлцэх эрхтэй бол Аюулгүйн Зөвлөл энх тайвныг сахин хамгаалах талаар гол хариуцдагыг хүлээж, урьдаас сэргийлэх, албадлагын арга хэмжээг НҮБ-ын нэрийн өмнөөс авч явуулах онцгой үүргийг хэрэгжүүлдэг. НҮБ-н дүрмийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Аюулгүйн Зөвлөл энх тайванд заналхийлсэн буюу түүнийг зөрчсөн, мөн түрэмгийлэл үүссэн эсэхийг юуны өмнө тодорхойлон тогтоох үүрэгтэй.



Энх тайвныг сахих НҮБ-ын хүчинг (Энхийг сахиулах хүчин) ихэнхдээ мөргөлдөөн үүссэн, эсхүл гал зогсоосон нөхцөлд хэрэглэдэг бөгөөд гол зорилго нь НҮБ-ын хяналтад авсан бүсийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, гал зогсоосон тохиролцооны биелэлтийг хангах, эсрэг талуудыг зааглан тусгаарлах, нийгмийн самуун дэгдсэн улсад дэг журам тогтоох, орон нутгийн хууль бус зэвсэгт хүчнийг тараах, байгалийн гамшигт нэрвэгдсэн газарт тусламж үзүүлэх, НҮБ-ын бусад бие бүрэлдэхүүнийг хамгаалахад оршино. Манай улс өөрийн цэргийн албан хаагчдыг 2006 оноос эхлэн НҮБ-ын Энхийг сахиулах хүчинд алба хаалгаж байгаа билээ.



Зэвсэглэлийг хязгаарлах, эцсийн дүнд зэр зэвсгийг устгах нь нийтийн энх тайван хамтын аюулгүй байдлыг хангах материаллаг нөхдөл юм. Зэвсэг хураах үзэл баримтлал нь олон улсын эрх зүйн нэг үндсэн зарчим бөгөөд хоёр төрлийн үүргийг улс орнуудын хувьд бий болгодог:



Монгол Улсын Аюулгүй байдал.

Монгол Улсын Их Хурлаас 1994 онд батласан "Аюулгүй байдлын үзэл баримтлал" д манай үндэсний аюулгүй байдлын цогц нь: Монгол Улсын тусгаар тогтнолын аюулгүй байдал, нийгэм, төрийн байгууллын аюулгүй байдал, иргэний эрх чөлөөний аюулгүй байдал, шинжлэх-ухаан, технологийн аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн амын удмын сангийн аюулгүй байдал, экологийн аюулгүй байдлаас бүрдэнэ гэж заасан байдаг.



Хяналтын асуулт

1. Олон улсын аюулгүй байдлыг хангах асуудал Олон улсын нийтийн эрх зүйн ямар үндсэн зарчимд тулгуурлах талаархи дүн шижилгээ хийнэ үү?
2. Аюулгүй байдлыг хамтын хэлбэрээр хангах нь ямар ач холбогдолтой вэ?
3. Аюулгүй байдлыг хангахад олон улсын байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлно уу?
4. Монгол Улсын аюулгүй байдлын талаархи эрх зүйн баримт бичигт дүн шижилгээ хийнэ үү?
5. Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангахад төвийг сахих статусын ач холбогдлыг хэлнэ үү?



Эх сурвалж

1. М. Дүгэрсүрэн, О.Хосбаяр.Олон улсын эрх зүй. 247-267 х. УБ.(1999 он
2. Төрийн мэдээлэл" эмхтгэлийн тусгай дугаарын II боть, 270-301,
3. Монгол Улсын Аюулгүй байдлын үзэл баримтлал 1994 он.



20. Олон улсын далайн эрх зүй



Нэр томъёо

Нэр томъёоны тайлбарыг "Нутаг дэвсгэр ба хүн ам" сэдвээс харна уу

Олон улсын далайн эрх зүйн тухай ойлголт, эх сурвалж

Дэлхийн гадаргууны 70 орчим хувийг далай, тэнгис эзэлдэг. Улс гүрэн далайг зам харилцаа, байгалийн баялаг олборлох, эрдэм шинжилгээний ажил, цэргийн гэх мэт зорилгоор ашигласаар ирэх явцад далайн эрх зүй бүрэлдсэн. Далайн эрх зүйн дэглэм тогтоож, ОУНЭЗ-н субъект хоорондын далай дахь үйл ажиллагааг зохицуулдаг зарчим, хэм хэмжээний нийлбэр цогцыг олон улсын далайн эрх зүй гэнэ. ОУНЭЗ-н салбаруудаас хамгийн эртний салбар бөгөөд удаан хугацаанд заншлийн хэм хэмжээгээр зохицуулагдаж байв.




Энэхүү конвенци ОУНЭЗ-д хамгийн томд тооцогдох 17 бүлэг, 320 зүйлтэй 9 хавсралт бүхий олон улсын гэрээ юм. 1994 оны 11-р сараас эхлэн үйлчилсэн. 1958 оны Женевийн конвенцийн зохицуулалтыг бататгаж, шинэ зохицуулалтаар баяжуулсан онцлогтой.

Далайн орон зайн ангилал, тэдгээрийн дэглэм

Физик-газарзүйн талаасаа далайн орон зай нэгдмэл боловч эрх зүйн талаас авч үзвэл тухайн орон зайд ямар дэглэм үйчилэхээс шалтгаалж далайн орон зай ангиллагддаг.

Далайн боомт тохой, нутаг дэвсгэрийн далайн шугамаас дотогш орших усыг дотоод далайн ус гэнэ.



Эргийн улсын нутаг дэвсгэрийн хэсэг, онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлнэ

Улсын далайн эрэг буюу дотоод далайн устай зах нийлсэн түүний бүрэн эрхэд орших хэсгийг нутаг дэвсгэрийн ус гэнэ.

Нутаг дэвсгэрийн усны өргөнийг далайн 12 мильд багтааж тогтоох ба тэрхүү шугам нь улсын далайн хил болно. Түүний хэвлий, агаар мандал эргийн улсын бүрэн эрхэд хамаарна. Эргийн улсын аюулгүй байдлыг алдагдуулахгүй дамжин өнгөрөх эрхтэй.

Нутаг дэвсгэрийн усны өргөнийг хэмжиж хээлдэг шугамаас гадагш далайн 24 миль доторхи хэсгийг залгаа бүс гэнэ.

Эргийн улс бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй, харин нутаг дэвсгэрийн далайд гааль, эрүүл ахуй, татвар, цагаачилалын журам зөрчихөөс урьдчилан сэргийлэхийн тулд хяналт тогтооно.

Нутаг дэвсгэрийн усны гадаад хязгаараас 200 далайн мильд багтдаг орших далайн ёроол, хэвлийг эх газрын хормой гэнэ.

Эргийн улс эх газрийн хормойн байгалийн баялагийг ашиглах, олборлох эрхтэй, хормойг бүрхсэн ус ба агаар мандалд эрх үл хамаарна.

Нутаг дэвсгэрийн усны гадаад хязгаараас 200 далайн мильд багтдаг орших далайн ёроол, хэвлийг эх газрын хормой гэнэ.

Эргийн улс байгалийн баялаг ашиглах, олборлох, судалгаа, шинжилгээний ажил явуулах эрхтэй. Бусад улс гэрээний үндсэн дээр оролцдог.

Нутаг дэвсгэрийн уснаас гадагш орших усан мандлыг нээлттэй далай гэнэ.

Нээлттэй далай, агаар мандалд тэгш эрхтэй ашиглах, үйл ажиллагаа явуулах эрхтэй.

Далайн ёроол

Нийт хүн төрөлхтний дундын өв



Далайд гарцгүй улсын эрх зүйн байдал

Далайн эрх зүйн тухай 1982 оны конвенцид зааснаар

- > Далайд гарах, буцах эрхтэй.
- > Дамжин өнгөрөх улсын нутаг дэвсгэрийг тээврийн бүх хэрэгслээр чөлөөтэй нэвтрэх,
- > Далайд гарцгүй улсын далайн тээвэрт бараа, таваарт үйлчилгээний хөлснөөс бусад татвар ногдуулахгүй байх,
- > Тээврийн хэрэгсэлд өөрийн улсын тээврийн хэрэгслээс илүүгүй хураамж ногдуулж байх,
- > Дамжин өнгөрөх хөдөлгөөнийг саатуулахгүй байхад шаарддагатай арга хэмжээ авах,
- > Дундын өв болох далайн ёроолоос олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.



Даалгавар:

1. Монгол улс Далайн эрх зүйн тухай конвенцид нэгдэж орсон далайд гарцгүй улсын нэг юм. 1991 оны 08-р сард Монгол улс, Хятад улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх, тээвэр хийх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдсан. Уг хэлэлцээрээр Монгол улс Тяньжин хотын Синьган боомтоор дамжин далайд гарч байхаар тохиролцжээ.

a. Олон улсын далайн эрхзүйн дагуу Монгол улс ямар эрх эдлэж, үүрэг хүлээх вэ?

b. Далайд гарцгүй улсын эрх зүйн байдлыг тодорхойлоно уу?

2. А улсын худалдааны хөлөг онгоц Б улсын нутаг дэвсгэрийн далайд зорчиж байжээ. Гэтэл хөлөг онгоцонд зөрчиж явсан нэгэн иргэний үнэт эд зүйлс алга болсон гэмт хэрэг гарсан байна.

a. Энэхүү гэмт хэрэгт аль улс ажиллагаа явуулах эрхтэй вэ?

b. Ямар тохиолдол, үндэслэлээр Б улс нутаг дэвсгэрийн далай дахь хөлөг онгоцонд ажиллагаа явуулах бүрэн эрхтэй вэ?

c. Нутаг дэвсгэрийн далайн эрх зүйн байдлыг тодорхойлно уу?

d. Чөлөөтэй дамжин өнгөрөх гэдгийг тайлбарлана уу?



Эх сурвалж


1. М. Дүгэрсүрэн, (ХХосбаяр.Олон улсын эрх зүй. 371-380 х. УБ., 1999 он
2. 1982 оны Далайн эрх зүйн тухай конвенц
3. 1991 оны Монгол улс, Хятад улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх, тээвэр хийх тухай Засгийн хоорондын хэлэлцээр

21. Олон улсын агаарын эрх зүй

XX зууны эхээр агаарын нислэг (навигац) бие даасан салбар болж, олон улсын харилцаа, улс төр, эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй үүрэг гүйцэтгэж эхэлсэн. Онолын хувьд нэг хэсэг нь агаарын зайг нээлттэй далайтай жишиж, "агаарын чөлөөт" дэглэм байх ёстой гэж үзэж байсан бол нөгөө номлол нь нээлттэй далай дээрх агаарын зайд чөлөөт дэглэм байхыг зөвшөөрөхийн хамт улс гүрний нутаг дэвсгэрийн дээрх агаарын зайд түүний бүрэн эрхийг тогтоохын чухлыг нотлож байдаг.

Олон улсын агаарын эрх зүй нь агаарын зайд нислэг үйлдэх, түүний аюулгүй байддыг хангах, хяналт тавих талаар олон улсын харилцааны субектүүдийн үйл ажиллагааг зохицуулдаг зарчим, хэм хэмжээний цогц мөн.

Агаарын нислэгийн зохицуулалтын тухай Парисын 1919 оны конвенцид зааснаар "улс орон бүр өөрийн нутаг дэвсгэрийн дээрх агаарын зайд төгс бөгөөд онцгой бүрэн эрх эдлэхийг хэлэлцэн тохирогч эрхэм талууд хүлээн зөвшөөрч байна" гэж тунхагласан. Түүнчлэн, Олон улсын иргэний нислэгийн тухай Чикагогийн 1944 оны конвенцид улсын нутаг дэвсгэрийг тодорхойлохдоо түүнд нутаг дэвсгэрийн усыг (далайг) хамруулснаар улс орон тэр усныхаа дээрх агаарын зайд бүрэн эрхээ тогтоохыг зөвшөөрсөн байдаг.




Чикаго хотод 1944 онд байгуулсан Олон улсын иргэний нислэгийн (тээврийн) тухай конвенц олон улсын агаарын эрх зүйн тулгуур баримт бичиг болох бөгөөд энэхүү конвенцид 160 гаруй улс оролцож байна. Түүнчлэн Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ-ЮАО)-аас баталсан конвенц болон улс бүрийн иргэний нислэгтэй холбоотой хууль тогтоомжийг эх сурвалжид хамааруулж болно. Манай улсын хувьд агаарын зайд иргэний нислэг үйлдэх дэг журмыг "Агаарын нисэхийн тухай" Монгол Улсын 1999 оны хуулиар тогтоосон.

Олон улсын агаарын эрх зүйн зарчим

Тухайн улсын агаарын зайг бусад улс гүрэн зөвхөн түүний зөвшөөрлөөр ашиглана. Ийнхүү зөвшөөрөл олгохдоо нислэгийн зам (маршрут), агаарын хилээр орж гарах үүд, бууж болох аэропорт, түүнчлэн хаалттай бүс зэргийг тодохойлон заасан байх



ёстой. Зорчигчид, ачаа, тээш, шуудан зэргийг тухайн улсын нутагт буулгах, тэндээс авах зэрэг гүйлгээний ажиллагаа бүхий нислэгийг зөвхөн засгийн газар хоорондын хэлэлцээрийг үндэслэн тухайн засгийн газраас тогтоосон журмын дагуу хийдэг. Монгол Улсын хувьд Агаарын тээврийн хэлэлцээрийг дэлхийн 30 гаруй оронтой байгуулаад байна. Аливаа улс гүрний агаарт нисэх буюу нутагт нь байхдаа гадаадын агаарын хөлөг бүр агаарын харилцаанд хамаарах хууль тогтоомжийг нь чанд сахин биелүүлэх үүрэгтэй.



Улсын нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэх журам

Агаарын хөлөг буюу бусад нисдэг хэрэгслээр нутаг дэвсгэрийнхээ хүрээнд нислэг үйлдэх журмыг улс гүрэн өөрийн бүрэн эрхийн хүрээнд тогтоодог. "Агаарын нисэхийн тухай" Монгол Улсын хуульд тус улсын иргэний агаарын тээврийн бүх үйл ажиллагаа, мөн түүний нутаг дэвсгэрт байрлаж байгаа буюу агаарын зайд нь нислэг үйлдэж байгаа бүх агаарын хөлгийн нислэгийг захиран зохицуулахаар тусгасан байдаг. Түүнчлэн Олон улсын агаарын тогтмол харилцаа (нислэг) гэдгийг ОУИНБ дор дурдсанаар тодорхойлсон: агаарын тогтмол харилцаа нь зорчигчид, ачаа, шууданг хөлсөөр тээвэрлэх зорилгоор (нэгээс дээш тооны) гадаад улсын агаарын зайгаар нэвтрэх олон удаагийн нислэг байх бөгөөд тэдгээрийн давтамж тоо, цагийн хуваарийг нийтлэх замаар нийтэд нээлттэй, хүртээлтэй байх ёстой гэжээ.

Олон улсын агаарын эрх зүйн зөрчил

Улс гүрний агаарын зайд гадаадын агаарын хөлөг зөвшөөрөлгүй орвол олон улсын эрх зүйн зөрчил гэж үздэг. Зөрчил гарсан нөхцөл байдлаас хамааран агаарын хөлгийн дарга эрүүгийн, захиргааны эсхүл сахилгын хариуцлага хүлээнэ. Уг хөлөг үндэсний бүртгэлд нь бүртгүүлсэн улс олон улсын эрх зүйн зохих хариуцлага хүлээнэ. Ийм зөрчил давагдашгүй (форс мажор) хүчин зүйлийн шалтгаанаас үүссэн нь нотлогдвол зохих акт тавьж, асуудлыг хааж болдог.


Нээлттэй далай, олон улсын усан хоолой дээгүүр нислэг үйлдэх журам

Нээлттэй далай чөлөөтэй байх зарчмыг 1958 оны Женевийн конвенц, мөн Далайн эрх зүйн тухай НҮБ-ын 1982 оны конвенц тус тус тогтоосны дагуу түүний дээрх агаарын зайд нислэг чөлөөтэй үйлдэх зарчим тогтсон. Гэхдээ энэ "чөлөөт" дэглэм нь огт хязгаарлалгүй зүйл биш юм. Агаарын хөлөг нээлттэй далай дээгүүр нисэхдээ олон улсын эрх зүйн зохих шаардлагыг даган мөрдөх үүрэгтэй. Ийм нислэг үйлдэж байгаа хөлөг нь үндэсний болон бүртгэлийн тэмдэг дугаартай байна. Олон улсын далайн хоолойн дээгүүр үйлдэх нислэгийн эрх зүйн зохицуулалт өөрийн онлогтой. Олон улсын хоолойг өвөрмөц байдлаар нь ялгаж нислэгийн эрх зүйн зохицуулалт хийдэг. Зарим нь нээлттэй далай юмуу эдийн засгийн тусгай бүсийг холбосноор дэлхийн хэмжээний усан замын статустай байдаг. Ийм төрлийнхөд: Балтийн, Гибралтарьш, Ла-Манпшийн, Па-де-Кале(Дувр)-ийн, Сингапурийн Магелланы гэх зэрэг хоолой ордог. Ийм хоолой дээгүүр үйлдэх нислэг нь дамжин өнгөрөх нислэгийн журмыг баримтална. Харин ямарваа хоолой эргийн улсын нутаг дэвсгэрийн далайд байвал тухайн улсын зөвшөөрлийг заавал авдаг.

Олон улсын агаарын эрх зүйн арга, хэлбэр

Тогтмол нислэгийн тухай улс хоорондын хоёр талын үндсэн хэлэлцээрийн гол агуулга нь дээр дурдсан таван төрлийн эрх зүйн хэм хэмжээнд үндэслэнэ. Хэлэлцээрт нислэгийн хуваарь, давтамж тоо, тийзгийг (тасалбарыг) борлуулах журам, түүний үнийн тохиролцоо, үйлчилгээний тариф, нислэгийг удирдах дохио, харилцах хэл, техникийн үйлчилгээ, онцгой тохиолдолд эрж сурвалжлах, үзүүлэх туслалцаа зэрэг өргөн хүрээтэй нарийн асуудлыг зохицуулах хэм хэмжээг тохиролцдог.

Үүнд агаарын тээврийн 5 эрхийг хамааруулдаг.





Хяналтын асуулт

1. Монгол улсын агаарын зайд иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын зам, агаарын хаалгыг ямар байгууллага тогтоох вэ?
2. Улсын Их Хурал иргэний нисэхийн талаар ямар бүрэн эрхийг хэрэгжүүлдэл вэ?
3. Монгол улс агаарын орон зайг бусад улсад ашиглуулахад Олон улсын эрх зүйн дагуу ямар үүрэг хулээдэг вэ?



Даалгавар:

А улсад бүртгэлтэй Монгол Улсын агаарын зайд улсын хилийг агаарын хаалгаар нэвтрэх журмыг зөрчиж, түүнчлэн эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүй улсын хил нэвтэрсэн байна.

1. Монгол улсын ямар байгууллага ямар арга хэмжээ авах үүрэгтэй вэ?
2. Олон улсын эрх зүй болон Монгол улсын зохих хууль тогтоомжид заасны дагуу хэнд ямар хариуцлага оногдуулж болох вэ?
3. Зохих хууль тогтоомжид заасан хариуцлагаас чөлөөлөгдөх ямар үндэслэл байж болох вэ?




Эх сурвалж

1. М. Дүгэрсүрэн, 0.Хосбаяр.Олон улсын эрх зүй. 383-397 х. УБ.,1999 он.
2. Ю.М.Колосов, Э.С.Кривчикова "Международное право" Москва 2000



22. Олон улсын сансрын эрх зүй

ЗХУ1957 онд, АНУ1958 онд дэлхийн хиймэл дагуул хөөргөж, 1961 онд ЗХУ-ын иргэн Ю А Гагарин түүхэнд анх удаа дэлхийн их тойрогт нислэг хийснээр сансрын уудмыг судлах, практик зорилгод апшглах эрин үеийг нээсэн. Түүний газрын дээрх агаар мандал болон (далайн төвшинөөс 100 км дээш орпшх) сансрын уудам гэж хоёр хуваасан. Ийнхүү зааглан тогтоосоны учир, ач холбогдлыг зөвхөн техникийн талаас нь биш, юуны өмнө дэлхий дахины энх тайван, хүн төрөлхтний хөгжил дэвшлийн үүднээс авч үзэх шаарддагатай. Сансарт явуулах үйл ажиллагаа, түүний эрх зүйн здрилго, зарчмыг тогтоон мөрдөхөд дараах хүчин зүйл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.



Сансрын эрх зүй гэж: а) сансрын уудам, тэнгэрийн эрхсийг судалж ашиглах эрх зүйн дэглэмийг тогтоох; б) энэ ажиллагаанд оролцогчдыш эрх үүргийг зохицуулах зарчим, хэм хэмжээний тогтолцоог хэлнэ.




Олон улсын сансрын эрх зүйн эх сурвалж

Сансрын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг боловсруулах ажлыг амжилттай гүйцэтгэх зорилгын үүднээс хууль зүйн салбар хороо байгуулсан. НҮБ-ын Салбар хороо өнгөрсөн хугацаанд сансрын эрх зүйн эх сурвалжийг бүрэлдүүлэхэд чухал алхам болсон таван гэрээ боловсруулжээ.

Сансрын эрх зүйн объектод сансрын уудам, тэнгэрийн эрхсийг судлах, үр дүнг нь ашиглах, сансрын нисгэгчид, түүнд хөөргөсөн биет зүйлст хавдах зэрэг үйл ажиллагаанд улс гүрнээс гүйцэтгэх эрх үүргийн асуудал орно. Энэ эрх зүйн субъект нь олон улсын нийтийн эрх зүйн субъект юм. Тухайлбал, улс гүрэн, олон улсын засгийн газар хоорондын байгууллага голчлон багтана. Сүүлийн үед сансрын үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага субъектийн статустай болох хандлага өргөжиж байна.

Олон улсын сансрын эрх зүйн зарчим.





Сар болон тэнгэрийн бусад эрхэсийн дэглэм

Сар түүний тойрог тийш нисэх замыг зөвхөн энхийн зорилгод ашиглах ёстой. Хүч хэрэгл эх, хүчээр сүрдүүл эх аргыг дээр дурдсан бүх зайнаас дэлхий бол он сарны хувьд, мөн сансрын хөлөг, түүний баг, хиймэл объектын хувьд хэрэглэхийг хориглосон. Дурдсан орон зайд цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсэгтэй объект гаргахгүй, сарны гадаргуу дээр, түүнчлэн хэвлийд нь байрлуулахгүй байх үүрэгтэй.

Саран дээр цэргийн бааз, бусад байгууламж, бэхлэлт барих, аливаа зэвсэг шалгах, цэргийн сургуулилт маневр хийхийг хориглосон.

Сансрын 1967 оны гэрээнд зааснаар улс гүрэн өөрийн явуулж байгаа сансрын үйл ажиллагааны хувьд эрх зүйн хариуцлага хүлээнэ.



Хяналтын асуулт

1. Олон улсын сансрын эрх зүйн үүсэл, эх сурвалжийг нэрлэнэ үү.
2. Олон улсын сансрын эрх зүйг хөгжүүлэхэд НҮБ-аас гүйцэтгэж байгаа үүргийг нэрлэнэ үү?
3. Сансрын нисгэгч болон объектын эрх зүйн статус ямар байх вэ?
4. Сар болон тэнгэрийн бусад эрхэст ямар эрх зүйн дэглэм үйлчлэх вэ?



Эх сурвалж

1. М. Дүгэрсүрэн, О.Хосбаяр.Олон улсын эрх зүй. 399411 х. УБ.1999 он,
2. Ю.М.Колосов, Э.С.Кривчикова "Международное право" Москва 2000



23. Олон улсын олон нийтийн мэдээллийн эрх зүй

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн ойлголт, эрх зүйн зохицуулалт

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэдэгт цахим холбоо (радио, телевиз, компьютерийн сүлжээгээр түгээж буй нэвтрүүлэг гэх мэт), түүнчлэн хэвлэмэл, дуу буюу дүрст хэлбэрээр түгээгдэж буй ном, сонин, сэтгүүл, пянз, аудио болон видео хальс, диск гэх мэтийг хамааруулж болно. Өнөөдөр дэлхийд өдөрт 400 сая орчим сонин, 600 мянга гаруй ном хэвлэгдэн гарч, 1 тэрбум гаруй радио хүлээн авагч, 500 сая гаруй телевизороор 25 мянга гаруй станц өөрийн мэдээллээ цацаж байна гэсэн тооцоо байдаг.

Олон улсын олон нийтийн мэдээллийн эрх зүй гэж олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах явцад бий болох олон улсын эрх зүйн субъектуудын эрх үүргийг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг хэлнэ. Олон улсын олон нийтийн мэдээллийн асуудал нь улс хоорондын эрх зүйн харилцааны объект болж байдаг.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь нийгмийн болон олон улсын хэмжээнд нийтийн сэтгэл зүй төлөвшин тогтоход ихээхэн үүрэг гүйцэтгэдэг төдийгүй аливаа улс орны дотоод болон гадаад боддогыг хэрэгжүүлэх салшгүй хэрэгсэл болдог. Мэдээллийг түгээхдээ аливаа улс орон улс орны бүрэн эрхт байдалд үл халдах, дотоод хэрэгт үл оролцох зэрэг олон улсын түгээмэл зарчмуудыг удирддага болгох ёстой. Олон улсын олон нийтийн мэдээллийн эрх зүйн гол эх сурвалж нь олон улсын гэрээ хэлэлцээр, улс орны үндэсний хууль тогтоомж байдаг. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд аливаа хүний мэдээлэл хүртэх эрх чөлөөг тусгасан хэдий ч түүнийг ямар тохиолдолд хязгаарлаж болохыг мөн тусгасан.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал

Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.

Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх бүтээгдэхүүнийг улс хооронд зөөвөрлөх, дамжуулах асуудлыг олон улсын гаалийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг. Гэхдээ энэ салбарт хэд хэдэн конвенц батлагдан гарсан. Тухайлбал, 1954 онд НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО) нь

"Боловсрол, шинжлэх ухаан, соёлын шинжтэй дуут болон дүрст материалыг олон улсын хэмжээнд солилцох явдлыг хөнгөвчлөх тухай конвенц"-д заасны дагуу конвенцид дурдсан материалыг гишүүн улсууд өөр хоорондоо солилцохдоо гаалийн хөнгөлөлт үзүүлж байхаар тусгажээ.

XIX зууны сүүлч буюу XX зууны эхэн үеэс радио өргөн дамжуулах станцууд дэлхийн өнцөг булан бүрт олноор байгуулагдах болсонтой холбогдуулан бие биедээ саад болохгүй байх радио сувгийг зөв зохистой зохицуулах үүднээс 1932 онд Мадрид хотноо болсон бага хурлаар Олон улсын цахим холбооны байгууллагыг байгуулсан нь өнөөдөр НҮБ-ын нэгэн төрөлжсөн байгууллага болсон. Түүнчлэн, Олон улсын цахим холбооны байгууллагын тухай конвенцийг 1992 онд Женев хотноо баталжээ.

Олон улсын цахим холбооны байгууллагын гол зорилго нь цахим холбооны бүх хэлбэрийг үр дүнтэй ашиглах явдлыг дээшлүүлэхэд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, техникийн тоног төхөөрөмжийн хөгжлийг түргэтгэх, тэдгээрийг аль болох үр дүнтэй ашиглах, гишүүн орнуудад техникийн тусламж үзүүлэх, шинэ техник технологийг нэвтрүүлэхэд оршдог. Олон улсын цахим холбооны байгууллага дараахь 3 секторт хуваагддаг:



Түүнчлэн өнөө үед зарим үзэл бодлыг түгээхийг хориглодог. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1947 оны 110(II) дугаар тогтоолд олон улсын энх тайван аюулгүй байдалд заналхийлсэн, хохирол учруулахуйц ямар ч мэдээллийг аль ч хэлбэрээр түгээхийг хориглосон. Түүнчлэн Радио өргөн нэвтрүүлгийн тухай Женевийн 1936 оны конвенцид аль нэг орны ард түмэн, нийтийн дэг журам, аюулгүй байдлын эсрэг нэвтрүүлгийг конвенцид оролцогч нөгөө улс явуулахгүй байх үүргийг хүлээлгэсэн байдаг.



Олон улсын олон нийтийн мэдээллийн эрх зүйн зарчмууд

Улс бүр өөрийн хилийн гадна
мэдээлэл түгээх эрхтэй

Улс бүр дайн,садар
самуун,апаргейд болон бусад олон
улсын эрх зүйгээр хориглосон зүйл
сурталчилхаас зайлс хийх

Бусад улсын эсрэг чиглэсэн
өдөөн хатгасан,гүтгэлгийн шинжтэй
мэдээлэл түгээхгүй

Улс бүр дэвшилтэд ардчилсан үзэл
санааг нэвтрүүлэхийг дэмжинэ

Бүх ард түмэн мэдээлэл хүртэх
тэгш боломжоор хангагдана

Бүх улс олон нийтийн мэдээллийн
хэрэгслийг хөгжүүлэх эрхтэй

Хилийн чанадад нэвтрүүлэг явуулж
буй өөрийн мэдээллийн хэрэгсэлд бүх улс
үр дүнтэй хяналт тавих ёстой

Олон улсын сэтгүүлчийн эрх зүйн байдал

Олон улсын сэтгүүлч нь өөрийг нь харьяалах улсыг төлөөлж гадаад оронд үйл ажиллагаа явуулдаг хэдий ч дипломат дархан эрх, эрх ямба эдэлдэггүй. Тэд голдуу суугаа орныхоо мэдээллийн агентлагтай харилцан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Нөгөөтэйгүүр, хоёр ард түмний хооронд ямар уур амьсгал тогтох вэ гэдэг нь сэтгүүлчдийн үйл ажиллагаанаас ихээхэн шалтгаалдаг. Иймээс ихэнх улсад үндэсний олон нийтийн мэдээллийн хэрэгслийн байгууллагууд сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг батлан мөрдлөг болгож ажилладаг. Энэхүү ёс зүйн хэм хэмжээ нь тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд мөрддөг нэг ёсны дүрэм журам болдог.

Олон улсын сэтгүүлчид зэвсэгт мөргөлдөөний үед ажил үүргээ гүйцэтгэж байгаад амиа алдах нь цөөнгүй ч үүнийг олон улсын гэрээ хэлэлцээрээр зохицуулсан. Тухайлбал, Женевийн 1949 оны конвенцийн I протоколыг үүнд дурдаж болох юм.



Хяналтын асуулт

1. Олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж юуг хэлдэг вэ?
2. Олон улсын хэвлэл мэдээллийг зохицуулах шаардлагыг дурдана уу.
3. Олон улсын цахим холбооны байгууллага ямар онцлогтой вэ?
4. Олон улсын хэмжээнд нэвтрүүлэхийг хориглосон зүйл гэж юуг хэлдэг вэ?
5. Олон улсын олон нийтийн мэдээллийн эрх зүйн зарчмуудыг нэрлэнэ үү.



Эх сурвалж

1. Ю.М.Колосов, З.С.Кривчикова "Международное право" Москва 2000. стр 488498

24. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах олон улсын эрх зүй



Нэр томъёо

Хүрээлэн буй орчин - хүн төрөлхтний оршин тогтнох, хөгжих нөхцлийг бүрдүүлэгч олон хүчин зүйлсийн нэгдэлийг ойлгоно.



Хүрээлэн байгаа орчныг хамгаалах олон улсын нийтийн эрх зүйн тухай ойлголт.

Хүрээлэн орчныг хамгаалах, түүний бүрэлдэхүүн хэсгийг зохистой ашиглахтай холбоотой ОУНЭЗ-н субъектүүд хооронд үүсэх харилцааг зохицуулдаг зарчим хэм хэмжээний нийлбэр цогцыг ойлгоно. Хүрээлэн байгаа орчны эрх зүй нь шинэхэн салбар бөгөөд далай, сансар, агаар гэх мэт бусад салбартай нягт уялдаатай харилцан биенээ нөхцөлдүүлж байдаг.

Хүрээлэн орчины эрх зүйн зохицуулах зүйл

Хүрээлэн орчинд хортой нөлөөлөх үйлдлийг урьдчилан сэргийлэх, аюулыг хязгаарлах харилцаа


Байгалийн нөөц, баялагыг зохистой ашиглахтай холбоотой харилцаа

Түүхийн хувьд хүрээлэн орчныг хамгаалах салбарын олон улсын хамтын ажиллагаа XIX зуунд үүссэн боловч зөвхөн байгалийн тодорхой объектыг хамгаалах хүрээнд хоёр талт гэрээнд үндэслэгдэж байсан. Хүрээлэн орчны бохирдол, байгаль, экологийн гамшиг, сүйрэл зэрэг нь XX зууны 2-р хагасаас дэлхий нийтийн анхааралыг татаж эхэлсэн.



Хүрээлэн орчны олон улсын эрх зүйн эх сурвалж

НҮБ-ын Хүрээлэн орчны Хөтөлбөрийн бүртгэлээр өнөөдөр 1000 гаруй олон талт гэрээ, 3000 орчим хоёр талт гэрээ хэлэлцээр үйлчилдэг байна. Эдгээрээс хүрээлэн орчныг хамгаалах үр дүнтэй нь олон талт гэрээ бөгөөд түгээмэл шинжтэй эх сурвалжийг дурьдахад:



Хүрээлэн орчны олон улсын эрх зүйн үндсэн зарчим

Хүрээлэн орчны эрх зүй нь ОУНЭЗ-н нэг салбарын хувьд түүний үндсэн зарчимууд үйлчилнэ. Энэ салбарт дараах зарчим үүсэж, хөгжиж байна. Үүнд:

Хүрээлэн орчныг хамгаалах

Урьдчилан мэдэгдэх ба мэдээлэл солилцох

Улс байгалийн нөөцөө эзэмших халдашгүй эрхийн

Болгоомжлох арга хэмжээ авах

Улс өөрийн хязгаараас гадна орчинд хохирол үл учруулах

Хүрээлэн орчинд нөлөөлөх байдлыг үнэлэн тогтоох


Хүрээлэн байгаа орчныг хамгаалах салбар дахь олон улсын байгууллага

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1974 онд баталсан "Улсуудын эдийн засгийн эрх, үүргийн харти" хэмээх баримт бичигт хүрээлэн орчныг хамгаалах, хадгалах, зохистой ашиглах нь бүх улс орны үүрэг болох тухай заажээ. 1973 онд НҮБ-ын Хүрээлэн орчны Хөтөлбөр буюу ЮНЕП байгуулагдсан. НҮБ-ын туслах байгууллагын статустай боловч байнгын үйл ажиллагаатай, бусад байгууллагаас харьцангуй өргөн эрх хэмжээтэй. ЮНЕП-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хүрээлэн орчны талаархи олон улсын гэрээ, конвенцийг боловсруулах, явдал юм.



Хүрээлэн байгаа орчныг хамгаалах салбар дахь Олон улсын бага хурал

Орчин үед нүүрлээд буй экологийн аюулыг нэг буюу хэсэг улсын хүчин зүтгэлээр даван туулж чадахгүй болсон юм.





Бодлого

Хятад улсын Монгол улстай хиллэдэг тариалангийн бүс нутагт маш их халууг болж, гантай байсан учир хиймэлээр бороо оруулах пшидвэр гаргаж үүл буудсан байна. Үүний улмаас Монгол улсын нутгийн өмнөд хэсгээр хүчтэй аадар бороо орж улмаар хэд хэдэн хүний амь нас эрсдэж, эд материалын асар их хохирол учиржээ.

а Энэхүү үйлдэлд дүгнэлт өгнө үү?

б. Ийм зорилгоор байгаль орчинд нөлөөлөх нь зөв үү?



Хяналтын асуулт

1. Хүрээлэн орчныг хамгаалах улс хоорондын хамтын ажиллагааны агуулга юунд орших вэ?
2. Хүрээлэн буй орчны эрх зүйн салбарын ямар зарчмуудыг та мэдэх вэ?
3. Олон улсын эрх зүйн бусад салбарын хэм хэмжээ хүрээлэн орчныг хамгаалахад нөлөө үзүүлдэг нь ямар учир шалтгаантай вэ?
4. Хүрээлэн орчны асуудаар ЮНЕП ямар чиг үүргийг хэрэгжүүлдэг вэ? Хүрээлэн орчныг хамгаалахад Засгийн бус олон улсын байгууллагын гүйцэтгэх үүргийг та хэрхэн үнэлэх вэ? Тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно уу?



Эх сурвалж

1. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. 270-290 х. УБ., 1999.
2. Ю.М.Колосов, Э.С.Кривчикова "Международное право" Москва 2000.


25. олон улсын цөмийн эрх зүй

Олон улсын цөмийн эрх зүйн ойлголт

Дэлхийн АНУ анх удаа цөмийн зэвсэг бүтээж түүнийгээ 1945 оны 8 дугаар сарын 6-ны өдөр Японы Хирошима, 1945 оны 8 дугаар сарын 9-ний өдөр нагасаки хотноо туршиж эхэлснээр цөмийн зэвсгийн асуудал хурцаар тавигдаж эхэлсэн түүхтэй. Гэвч цөмийн инергийг хамгийн анх энхийн зорилгоор хэрэглэсэн нь буюу атомын цахилгаан станцыг дэлхийд анх удаа 1954 онд тухайн үеийн ЗХУ байгуулсан бол өнөөдөр дэлхийн хэмжээнд 400 гаруй атомын цахилгаан станц ажиллаж байгаа бөгөөд Франц Улс гэхэд л эрчим хүчнийхээ 80 илүү хувийг атомын цахилгаан станцаас авч байна.

Олон улсын цөмийн эрх зүй гэж улсууд болон олон улсын эрх зүйн бусад субъектын хооронд цөмийн энергийг энх тайвны зорилгоор ашиглах, цөмийн зэвсгийн аюулаас урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор хамтарч ажиллах хэм хэмжээ, зарчмыг хэлнэ. Олон улсын цөмийн эрх зүйн гол эх сурвалж нь цөмийн аюулгүй байдал болон цөмийн энергийг энхийн зорилгоор хэрэглэхтэй холбогдсон олон улсын гэрээ хэлэлцээр юм.

Тухайлбал: Цөмийн зэвсгийг агаар мандал, огторгуйн уудам, усан дор туршихыг цаазлан хориглох тухай гэрээ, Цөмийн зэвсэг дэлгэрүүлэхгүй байх тухай гэрээ, Тэнгис далайн ёроол, түүний хөрсөн дор цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсэг байрлуулахыг хориглох тухай гэрээ, Цөмийн туршилтыг бүрэн хориглох тухай гэрээ зэргийг дурдаж болох юм.






Эдгээр асуудлаар Олон улсын цөмийн эрх зүйн холбооны дэргэд хуульч мэргэжилтнүүдийн ажлын хэсэг байгуулагдан ажиллан тайлан илтгэлээ бэлтгэж Олон улсын цөмийн эрчим хүчний агентлаг (МАГАТЭ)-д хүргүүлжээ.

Цөмийн зэвсгийн аюулаас сэргийлэх

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн анхдугаар чуулган цөмийн зэвсгийг устгах асуудлаар эхнийхээ тогтоолыг гаргасан билээ. Цөмийн дайныг хэзээ ч гаргаж болохгүй гэдгийг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн бөгөөд эл зорилгод хүрэх хамгийн найдвартай арга зам нь цөмийн зэвсгийг бүрэн хориглох явдал юм.

Цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх тухай гэрээг 1968 онд баталснаар уг зэвсгийг түгэхээс сэргийлсэн эрх зүйн чухал арга хэмжээ болсон.



Үүний зэрэгцээгээр, өөрсдийн энхийн зориулалттай цөмийн төхөөрөмжид олон улсын хяналт тавихыг хүлээн зөвшөөрөх үүргийг гэрээнд оролцогч бүх улс хүлээсэн.

Цөмийн зэвсэггүй бүс

Аливаа нутаг дэвсгэр, орон зайг цөмийн зэвсэггүй бүс болгож зарлах нь уг зэвсгийн тархалтыг хязгаарлах, улс гүрний итгэлцлийг бэхжүүлэх ач холбогдолтой. Цөмийн зэвсэггүй бүсийн тухай хэд хэдэн гэрээ байгуулагдсан. Тухайлбал: Латин Америкт цөмийн зэвсгийг хориглох гэрээг (Тлателолкийн гэрээ) 18 улс байгуулж 1969 онд хүчин төгөлдөр болсон бол Номхон Далайн өмнөд хэсгийг цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан гэрээг (Раротонгийн гэрээ) 11 улс байгуулж үүрэг хүлээсэн, түүнчлэн АСЕАН-ы гишүүн орнууд Зүүн Өмнөд Азийг цөмийн зэвсэггүй болгох тухай гэрээ (Бангкокийн гэрээ)-г 1995 онд байгуулсан. Эдгээр гэрээнд тусгагдсан нийтлэг заалт нь цөмийн аливаа байгууламжийг үйлдвэрлэхгүй, олж авахгүй, нутагтаа байрлуулах буюу туршихгүй, дамжин өнгөрүүлэхгүй, тухайн бүс нутгийн дотор цацраг идэвхт бодис буюу хаягдлыг байрлуулахгүй байх үүрэг хүлээлгэдэг.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 1992 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47 дугаар чуулган дээр Монгол Улсын нутаг дэвсгэрийг цөмийн зэвсэггүй бүс болгон тунхагласан. Ийнхүү тунхагласан явдлыг ОХУ, БНХАУ,

ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ


ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ТУСГАЙ АНГИ

АНУ, ИБУИНВУ болон БНФУ нь 1993, 1994 онд сайшааж, манай саналыг хүндэтгэн дэмжихээ илэрхийлсэн албан ёсны мэдэгдэлийг гаргаж байсан билээ. Манай улс ОХУ, БНХАУ, АНУ, ИБУИНВУ-ын Элчин сайдын яамдад "Хамтарсан мэдэгдэл"-ийн төслийг албан ёсоор гардуулж байсан бөгөөд 2000 оны 10 дугаар сарын 5-нд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн цөмийн зэвсэг бүхий таван гүрнээс Монгол Улсын цөмийн зэвсэггүй статустай холбогдуулан хамтарсан мэдэгдлээ гаргасан болно.

Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас "Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын тухай" 53/77D, 55/33S, 57/67, 59/73, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс 2004 онд 1540 тоот тогтоолуудыг тус тус баталсан байдаг.

Олон улсын цөмийн эрчим хүчний агентлаг (МАГАТЭ)

Энэхүү байгууллагын гол зорилго нь энх тайвныг сахин хамгаалж бэхжүүлэх, бүх нийтийн эрүүл мэнд сайн сайхны төлөө цөмийн энергийг аль болох өргөнөөр ашиглаж хөгжүүлэхийн төлөө оршдог.



Түүнчлэн бусад байгууллагад тэр бүр байддаггүй нэг онцгой эрх бол МАГАТЭ-ийн гишүүн аливаа улс уруу түүний өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхийг хянаж шалгуулахаар өөрийн мэргэжилтнүүдийг илгээдэгт оршдог.



Хяналтын асуулт

1. Олон улсын цөмийн эрх зүйн зохицуулалтын онцлог, ач холбогдол юунд орших вэ?
2. Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглахад хэрхэн хамтарч ажилладаг вэ?
3. Цөмийн зэвсгийн аюулаас сэргийлэх хамтын ажиллагааны ямар хэлбэрүүд байх вэ?
4. Цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх тухай гэрээгээр хүлээсэн үүргийг нэрлэнэ үү?
5. Цөмийн зэвсэггүй бүс гэж юу вэ?
6. Монгол Улсын онцлог ба цөмийн зэвсэггүй бусад бүсийн тухай.
7. МАГАТЭ-ийн үндсэн чиг үүрэг, онцлогийг дурьдана уу?



Эх сурвалж

1. М. Дүгэрсүрэн, (Х.Хосбаяр.Олон улсын эрх зүй. 260-262 х. УБ.1999 он,
2. Монгол Улсын Аюулгүй байдлын үзэл баримтлал 1994 он.

26. Олон улсын нийтийн эрх зүйн хариуцлага



Нэр томъёо

Сатисфакци -улсын нэр хүнд учруулсан хохиролыг сэргээх шаарддага бүхий материаллаг бус хариуцлагын хэлбэр,

Рестораци-тодорхой материаллаг объектыг урьдын хэвийн байдалд оруулахаар засварлах

Репараци-материаллаг хохиролын хэлбэр ба учруулсан хохиролыг мөнгө, бараа, үйлчилгээ хэлбэрээр нөхөн төлөх,

Реституци-хууль бусаар хурааж авсан эд хөрөнгийг биет байдлаар нь буцааж өгөх,

Субституци -эвдсэн, гэмтээсэн эд зүйлсийг адилхан өртөг бүхий эд зүйлсийг оронд нь өгөх

Олон улсын нийтийн эрх зүйн хариуцлага, үндэслэл, түүний ангилал, төрөл, хэлбэр

Олон улсын эрх зүйн харилцааны субъектүүд эрх, эдлэж үүрэг хүлээдэг. Олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөнтэй холбоотой үүсэх харилцаа нь олон улсын эрх зүйн хариуцлага юм. Олон улсын эрх зүйн хариуцлага нь ОУНЭЗ-н хэм хэмжээгсахин биелүүлэх явдлыг хангадаг чухал хэрэгсэл юм. ОУНЭЗ-н хариуцлагын институт нь салбар дундын шинжтэй нь түүний гол онцдог юм. Субъектэд оногдуулах хариудиагын талаар зохицуулсан олон улсын баримт бичиг байхгүй ба заншлийн хэм хэмжээгээр зохицуулж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн даалгавараар Олон улсын эрх зүйн комисс 1956 оноос хариуцлагын институтын кодификацийн ажлыг эхэлсэн боловч одоог хүртэл үргэлжилж байгаа юм.





ОУНЭЗ-н хариуцлага үүсэх үндэслэл олон улсын эрхзүйн хэм хэмжээ, зарчмыг зөрчсөн субъектын үйлдэл, эс үйлдэл юм. Зөрчил болохын хувьд үйлдэл, эс үйлдэл нь бүрэлдэхүүнийг агуулсан байх ёстой юм.

ОУНЭЗ-н зөрчлийг ангилах нь тухайн зөрчлийн нийгмийн хор аюулаас шууд шалтгаална. Зөрчил гаргагч субъектэд оногдох хариуцдагын төрөл, хэлбэр мөн зөрчлийн мөн чанараас шалтгаална.

Материаллаг бус буюу улс төрийн хариуцлага Олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ субъект зөрчсөний үр дүнд үүснэ. Материаллаг бус хариуцлага нь ямар эдийн болон бусад илэрхий хохирол учираагүй байсан тохиолдолд үүсэж болдог. Харин материаллаг хариуцдагын хувьд учирсан хохирол эрх зүйн зөрчсөн үйлдлийн хооронд шалтгаант холбоо байх ёстой.

Материаллаг болон материаллаг бус хариуцдагын нарийн зааг ялгааг харуулсан зохицуулалт үгүй боловч давхардаж хэрэглэгдэх тохиолдол байна.

Олон улсын нийтийн эрх зүйн хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцөл

Субъектын хэм хэмжээ зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг зөрчил гэж авч үзэхгүй буюу хариуцдагаас чөлөөлөх үндэслэлийг ОУНЭЗ-д тусгасан байдаг.



Олон улсын байгууллагын хүлээх хариуцлага

Олон улсын байгууллагын хүлээх хариуцдага тухайн байгууллагын өөрийн эрх зүйн байдалтай холбоотой. Олон улсын байгууллага өөрөө болон албан хаагчид Дүрмийн үүргээ сахин биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээнэ. ОУБ материаллаг болон материаллаг бус хариуцлагыг хүлээнэ. ОУБ материаллаг хариуцлагыг дангаар эсвэл гишүүн улсуудын хамтаар хүлээнэ.



Бодлого

1. 1988 онд АНУ Иран улсын иргэний нисэх онгоцыг санамсаргүй андуурч сөнөөсөн байна. Үүнийг эсэргүүцэн Иран улсын нийслэл Багдад хотод Америкийн Элчин Сайдын яамны байрны ойролцоо хэсэг иргэд жагсаал зохион байгуулж, улмаар халддага үйлдсэн байна.

а. Энэ тохиолдолд АНУ ямар хариуцлагыг, ямар хэлбэрээр ногдуулах вэ?

б. Элчин сайдын яаманд халдсан үйлдэлд Иран улс хариуцлага хүлээж болох уу? Хэрэв хүлээх бол ямар үндэслэлээр хүлээх вэ?

2. 1996 оны 3-р сард Английн эрэгт "Си эмпресс" танкер суужээ. Түүнээс 70 мянга орчим тонн нефть асгарсан байна. Асгарсан хаягдлын хэмжээ энэ төрлийнхөө арван том сүйрлийн нэг болсон. Танкер английн нефтийг зөөж явсан ба уг танкер Испани улсад үйлдвэрлэгджээ. Кипрт бүртгэлтэй Норвегийн компани эзэмшдэг ба энэхүү компанитай хийсэн гэрээгээр Оросын экипаж; Либерийн далбаан дор хөвж байжээ.

Олон улсын эрх зүйн дагуу хариуцлагыг хэрхэн оногдуулах вэ?



Хяналтын асуулт

1. Олон улсын эрх зүйн хариуцлагын институтын онцлог, бусад салбар эрх зүйд гүйцэтгэх ач холбогдлыг та хэрхэн үнэлэх вэ?
2. Олон улсын эрх зүйн дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл тус бүрийг тодрхойлно уу?
3. Олон улсын эрх зүйн зөрчлийг ангилахад баримтлах үндсэн шалгуур юу вэ?
4. Материаллаг ба материаллаг бус хариуцлагыг харьцуулна уу?
5. Материаллаг хариуцлагыг хүлээлгэх ямар хэлбэр байдаг вэ?
6. Материаллаг бус хариуцлагыг хүлээлгэх ямар хэлбэр байдаг вэ?
7. Хариуцлагаас чөлөөлөгдөх ямар үндэслэл байдаг вэ?
8. Олон улсын байгууллагын хүлээх хариуцлага ямар онцлогтой вэ?



Эх сурвалж

1. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. 234-242 х. УБ., 1999 он.
2. Б.Нармандах, Н.Гантулга. Олон улсын нийтийн эрх зүй. УБ., 2003 он.




27. Олон улсын маргааныг эв зүйгээр шийдвэрлэх арга зам

Олон улсын нийтнийн эрх зүйн маргааны ойлголт, төрөл, маргааныг шийдвэрлэх зарчим,

Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх нь ОУЭЗ-н үндсэн зарчим бөгөөд ОУНЭЗ-н субъектүүд хоорондын маргаанаа эв зүйгээр шийдвэрлэх үүрэгтэй.

Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх арга: олон улсын эрхзүйн субъект хоорондын маргааныг ямар нэг албадлагын арга хэрэглэхгүйгээр олон улсын эрхзүйн зарчмын дагуу зохицуулах олон улсын эрх зүйн арга, журмыг ойлгоно. НҮБ-ын Дүрэмд маргаан, байдал гэсэн нэр томъёо хэрэглэгддэг боловч нарийвчилж тодорхойлоогүй, харин хоёулаа ашиг, сонирхол зөрчилдөхөд үүсдэг нийтлэг шинжтэй. Зөрөлдөж буй асуудлаар улс харилцан гомдол гаргавал маргаан, харин үгүй тохиолдолд байдал болох юм.



Олон улсын маргааныг шийдвэрлэх аргууд

ОУНЭЗ-д маргааныг шийдвэрлэх эв зүйн аргууд үүсэл, хөгжлийн үйл явц нь хүн төрөлхтний түүхийн хөгжил, олон улсын харилцааны хүчний харьцааны онцлогоос шалтгаалж иржээ. Аливаа маргааныг шийдвэрлэх арга сонгох тухайн маргаанаас шалтгаалах боловч үндсэн хоёр арга байдаг. Үүнд:

> Гэрээгээр /маргаан гарахаас өмнө талууд үндсэн гэрээнд арга тусгах/

> Зөвшилцөж сонгох /маргаан гарсны дараа аргаа сонгох/

Аливаа сонгосон арга үр дүнд хүрэхгүй байх тохиолдол өөр бусад арга сонгох үүрэгтэй байдаг нь маргааныг заавал шийдвэрлэх ёстой гэж дүгнэж болох юм.



Хэлэлцээр маргааныг эцэслэн шийдвэрлэх олон шийдлийг гаргах боломжтой байдаг. Хэлэлцээр эв зүйн аргын хувьд үндсэн болон туслах шинжтэй байдаг. Үндсэн арга болох тохиолдолд шууд хэлэлцээрээр төгсдөг. Харин бусад аргуудын хувьд хэлэлцээр хийснээр эхэлдэг. НҮБ-ын Дүрмийн 33-р зүйлд дээрхи уламжлалт аргуудыг тооцохын зэрэгцээ маргалдагч талуудад "өөрсдийн үзэмжээр эв зүйн бусад аргыг хэрэглэнэ" гэж дурьджээ. ОУНЭЗ-н субъектүүд ямар нэг өвөрмөц маргаан шийдвэрлэхийн тулд шинэ аргыг хэрэглэж болохыг хуульчилж өгсөн байна.



Хяналтын асуулт

- Олон улсын маргаан ба маргаант байдлын ялгааг тодорхойлно уу?
- Олон улсын маргааныг эв зүйгээр шийдвэрлэх зарчим улсад ямар үүрэг ногдуулах вэ?
- Найрсаг туслалцаа, зуучлалын ялгааг тодорхойлно уу?
- Магадлан шалгах болон эвлэрүүлэх журам ямар онцлогтой вэ?



6. Олон улсын маргааныг шийдвэрлэх шүүх болон арбитрын төсөөтэй болон ялгаатай тал юунд орших вэ?



Даалгавар:

НҮБ-ын хүрээнд маргааныг эв зүйгээр шийдвэрлэх журмаар бүдүүвч хийнэ үү.



Эх сурвалж

1. О. Хосбаяр, М. Дүгэрсүрэн. Олон улсын эрхзүй 221-234 х. УБ.1999 он.
2. Б.Нармандах, Н.Гантулга. Олон улсын нийтийн эрх зүй. УБ., 2003 он.
3. НҮБ-ын Дүрэм